

“МОЭНКО” ХХК-ИЙН ХОВД АЙМАГ, ДАРВИ СУМ, МӨРӨН БАГИЙН
НУТАГТ ОРШИХ “ЧУЛУУН НҮҮРСИЙГ ИЛ АРГААР АШИГЛАХ”
ТӨСЛИЙН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР: (MV-
001414A, MV-001640A, MV-004322A, MV-006525A, MV-011887A, MV-
011888A, MV-015289A, MV-020299A,)

АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 5141583

ХЯНАСАН

ХБОБЗГ-ын Ахлах шинжээч:...../Ц. ЖАРГАЛНЭМЭХ/

БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАСАН:

“МОЭНКО” ХХК-ИЙН ЗАХИРАЛ..... /Ж.ОЮУНЧИМЭГ/

“МОЭНКО” ХХК

БАЙГАЛЬ ОРЧНЫ ОРЛОГЧ МЕНЕЖЕР:...../Б.ГАНБОЛД/

2025 ОН

ГАРЧИГ

Зурган мэдээ.....	iv
График мэдээ.....	v
Хүснэгтэн мэдээлэл	v
Хавсралт материал	vi
ОРШИЛ.....	1
БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	4
1.1 Төслийн ерөнхий мэдээлэл	4
1.2 Ордын нөөц	7
1.3 Дэд бүтэц	7
1.4 Нүүрс олборлолт, ил уурхайн хүчин чадал	9
1.5 Нүүрс баяжуулах технологи, тоног төхөөрөмж	10
1.6 Өрөмдлөг, тэсэлгээний ажил	11
1.7 Уурхайн тээвэр	11
1.8 Ил уурхайн үндсэн хэмжээс, загварчлал	11
1.9 Усан хангамж	12
1.10 Ажиллах хүчний тухай мэдээлэл	13
БҮЛЭГ 2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	14
2.1 Уурхайн технологийн замаас үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор технологийн замын усалгааг тогтмол хийх:	16
2.2 Техник хэрэгслүүдийн эвдрэл гэмтлийг хянаж, техникийн хэвийн ажлын горимыг ханган:	16
2.3 Хүйсийн говь, Цэцэг нуурын сав газрын захиргаатай ус ашиглах гэрээ байгуулж, ус ашигласны төлбөр төлөх:	17
2.4 Үржил шимт хөрсийг стандартын дагуу (шинээр хөрс хуулах бүрт) хуулж, хадгалах үйл ажиллагаанд хяналт тавих:	27
2.5 Асгаралттай холбоотой үүссэн бохирдсон хөрсийг хуулж авах, саармагжуулах:	27
2.6 Хуурай баяжуулах үйлдвэр болон гаалийн хяналтын ачиж буулгах талбайд үүсэх тоожилтыг бууруулах:	28
БҮЛЭГ 3. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	29
3.1 Техникийн нөхөн сэргээлт:	30
3.2 Биологийн нөхөн сэргээлт:	30
3.3 Шимт хөрсний үржил шимийг алдагдуулахгүй байх, тарьсан олон настын үрийг шувуу идэх, салхинд хийсэхээс хамгаалах:	30
3.4 Уурхайн орчмын ногоон байгууламжыг нэмэгдүүлэх, нөхөн тариалалт хийх:	30
БҮЛЭГ 4. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭХ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	32
4.1 Дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлт:	34
4.2 Булгийн эх хашиж хамгаалах:	36
4.3 Дарви сумын Мөрөн багийн нутаг Хойд голын тариалангийн 100 га талбайг хашиж хамгаалах:	38
4.4 Сутай хайрхан УТХГ-ын мөстлөг, цасны судалгаагаар авиралт хийх:	39
4.5 Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд ойжуулалтын ажлыг хэрэгжүүлэх:	39
БҮЛЭГ 5. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	41

БҮЛЭГ 6. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	42
6.1 Говийн их дархан цаазат газрын “Б” хэсгийн орчны бүсийн Алтай, Үенч, Булган сумдаас дархан цаазат газарт нэвтрэн ордог 5 цэг дээр иргэдийн экологийн боловсролыг дээшлүүлэх, анхааруулах самбар байршуулах:	43
6.2 Архелогийн судалгаагаар тогтоогдсон уурхай орчмын хиригсүүр болон булшнуудыг фото зургаар баримтжуулж бүртгэх:	43
БҮЛЭГ 7. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	45
7.1 Химийн бодисын MSDS-д заасны дагуу хадгалах, асгаралт үүссэн онцгой үед хэрэглэх, шингээгч материалыг зохих газруудад бэлэн байлгах:	46
7.2 Аливаа халдварт өвчин бохирдлоос сэргийлэх зорилгоор ариутгал халдавгүйжүүлэлт хийх:	48
7.3 Химийн хорт болон аюултай бодисын тооллого хийх:	48
7.4 Гал түймэр гамшигаас хамгаалах, эрэн хайх, аврах ажиллагааны онол практик хосолсон сургалт:	50
БҮЛЭГ 8. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ...	51
8.1 Уурхайн ойр орчмын уст цэгүүд, төслийн зам талбайд хийсч тарсан хог хаягдлын цэвэрлэгээ зохион байгуулах:	53
Кемп болон Оффисын чиглэлийн зам дагуу хог хаягдлыг цэвэрлэх	53
8.2 Хог хаягдал ангилан ялгаж түр хадгалах талбай байгуулах.	54
Усны хуванцар савыг цуглуулах	54
8.3 Гэрээт байгууллагаар нүүрс тээврийн 311 км зам дагуух хог хаягдлын цэвэрлэгээг хийлгэх, гэрээ байгуулах	54
8.4 Уурхайн эмнэлгийн гаралтай хог хаягдлыг Цэцэг сумын эмнэлэгт хүргүүлж журмын дагуу устгах:	55
8.5 Хог хаягдал шатаах зуух авах:	56
8.6 Засварын газраас гарах ашигласан тосыг хуримтлуулж хадгалахад хяналт тавих, бүртгэл хөтлөх, тусгай зөвшөөрөлтэй ААН-д акт үйлдэж шилжүүлэх, аюултай хог хаягдлын тайлан мэдээг улирал тутам БО-ны газарт хүргүүлэх:	56
БҮЛЭГ 9. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ.....	59
9.1 Гадаргын ба газар доорхи усны хяналт шинжилгээ	62
9.1.1 - 9.1.3 Хөшөөтийн уурхай орчмын уст цэгүүд болон Үенч голын ус, ҮГХТ, Булган голын уснаас дээж авч химийн ерөнхий, хүнд металл, цацрагийн шинжилгээг итгэмжлэгдсэн лабораториор шинжлүүлэх:	62
9.1.4 Бохир усны химийн шинжилгээ	63
9.1.5 Үенч, Бодонч, Булган голын мониторингийн судалгаа:	63
9.1.6 Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор хөв байгуулах:	63
9.2 Агаарын чанарын хяналт шинжилгээ	64
9.2.1 Мэргэжлийн байгууллагаар уурхай орчмын агаарын төлөв байдлын судалгааны ажил хийлгэх:	64
9.2.2 Уурхай орчмын агаарын тоосонцорын /PM10, PM2.5/ хэмжилтийг хийх:	67
9.2.3 Dust track багажны үйлдвэрийн тохиргоо хийлгэх:	68
9.3 Хөрсний судалгаа шинжилгээ.....	69
9.3.1 Уурхай орчмын хөрсний мониторингийн цэгээс дээж авч хими, физик, хүнд металлын шинжилгээнд хамруулах:	69
9.3.2 Уурхай орчмын хөрсний мониторингийн цэгээс дээж авч цацрагийн шинжилгээ хийлгэх:	69

9.4 Ургамал, Амьтны аймгийн судалгааны дүгнэл, санал.....	69
9.4.1 Усны амьтад болон голын татмын ургамал, шавьжийн судалгаа мэргэжлийн байгууллагаар хийлгэх:	69
9.4.2 Цаг хүндэрсэн үед уурхайн нөлөөллийн бүс дэх зэрлэг ан амьтанд биотехникийн арга хэмжээ авах:	72
БҮЛЭГ 10. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	76
10.1 Байгаль орчны менежментийн төлөвлөгөө ба түүний биелэлтийн тайланг боловсруулах	77
10.2 Уурхайд ашиглагдаж байгаа Химийн бодисын БОННУ-нд нэмэлт тодотгол хийлгэх	77
10.3 Уурхайн газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийлгэх:	77
БҮЛЭГ 11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	80
11.1-11.2 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан, холбогдох төрийн байгууллагад тайлагнах, Дарви сумын ЗДТГ, байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч нарт тайлагнах	82
11.3 Байгаль орчны чиглэлээр хийж хэрэгжүүлж буй ажлыг олон нийтэд мэдээллэх.	82
11.4 Говь-Алтай аймгийн 2, Ховд аймгийн 3 сумын эко клубийн сурагчдын экологийн боловсрол олгох хэлэлцүүлэг, уулзалт, сургалт, суртчилгааны ажлыг санхүүжүүлэх, оролцох	83
11.5 Үенч, Бодонч, Булган голын сав газрын захиргаатай хамтран Алтай, Үенч, Булган сумдын эко клубийн сурагчдад экологийн боловсрол олгох сургалтыг санхүүжүүлэх, оролцох	84
БҮЛЭГ 12 НЭМЭЛТЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН	87
12.1 Дарви сум болон ГИДЦГ-ын Б хэгийн хамгаалалтын бүс нутагт эко нойл хийж гүйцэтгэх:	88
12.2 Дарви сум болон ГИДЦГ-ын Б хэгийн хамгаалалтын бүс нутагт ангилан ялгалтын хогийн сав хийж байрлуулах:	88
12.3 Цэцэг сумын Цэцэг нуурын хөвөөнд гүний усны түвшин ажиглах ажиглалтын цооног гаргах:	89
12.4 Ховд аймгийн хэмжээнд эвдэрсэн газрын тооллого судалгааны ажилд санхүүгийн дэмжлэг үзүүлэх:	90
Төсөв задаргаа.....	91

Зурган мэдээ

Зураг 1. Хөшөөтийн нүүрсний ордын байрилын зураг.....	4
Зураг 2. Тоног төхөөрөмжийн холболтын бүдүүвч.....	10
Зураг 3. Ил уурхайн ашиглалтын эцсийн байдал.....	12
Зураг 4. Тоосжилтийн эсрэг зам усалгаа.....	16
Зураг 5. Авто тээврийн үзлэг явагдах үеийн зураг.....	17
Зураг 6. Мониторингийн цэгүүдийн байршил.....	19
Зураг 7. Автомат түвшин хэмжигч.....	20
Зураг 8. Well-2 худаг, суурилуулсан усны тоолуур.....	22
Зураг 9. WDH-03 шавхалтын худаг, суурилуулсан усны тоолуур.....	22
Зураг 10. Худагт суурилуулсан ус ашиглалтын хяналтын камер.....	23
Зураг 11. Ус зөөвөрлөх машиныг зориулалтаар нь ялгасан байдал.....	23
Зураг 12. Шинэ баяжуулах үйлдвэрийн тээвэрлэлт хийх зориулалттай замын шимт хөрс хуулалт хийж байгаа байдал.....	27
Зураг 13. Хөрс саармагжуулж туршилтын ажил.....	28
Зураг 14. Мананжуулагч машинаар уурхайн үйл ажиллагаанаас гарч буй тоосыг бууруулах зорилгоор өдөр бүр усалгаа хийж байгаа нь.....	28
Зураг 15. Шимт хөрсний талбайд болон модны тариалалт усалгаа хийж байгаа нь.....	31
Зураг 16. Мөст суманд хийгдэх нөхөн сэргээлтийн талбайн зураг.....	35
Зураг 17. Булгийн эхийн хамгаалалтын талбайд дрон зураг авалт, газар хэмжилт хийж, хашилтын төлөвлөлтийн зураглал боловсруулав.....	36
Зураг 18. Булган сумын булгийн эхийг хашиж хамгаалах ажлын байршил.....	37
Зураг 19. Үенч сумын Хөх үзүүрийн булгийн эх.....	37
Зураг 20. Цэцэг сумын Хажинга багийн нутаг Давааны ус булгийн эх.....	37
Зураг 21. Дарви сум хойд гол 100 га талбайн торлох ажлын зураг.....	38
Зураг 22. Сутай хайрхан УТХГ-ын мөстлөг, цасны судалгаагаар авиралт.....	39
Зураг 23. Өвөрхангай аймгийн Хархорин хотын нутагт 10,000 ширхэг мод тарих ажил.....	40
Зураг 24. Говийн их дархан цаазат газрын “Б” хэсгийн орчны бүсийн, самбар.....	43
Зураг 25. 60-63 дүгээр хиргисүүрийн бүрэн бүтэн байдлыг зургаар баримжуулсан байдал.....	44
Зураг 26. Асгаралтаас сэргийлэх иж бүрдэл болон анхны тусламжийн хйарцаг байрлуулсан байдал.....	46
Зураг 27. Лабораторийн дотоод зохион байгуулалт.....	47
Зураг 28. Хүндлэл кемп, оффис, засварын газруудад ариутгал халдваргүйжүүлэлт хийж байгаа нь.....	48
Зураг 29. Онцгой байдлын ерөнхий газрын дэрэгдэх аврах 9-р ангиас сургалт.....	50
Зураг 30. Тахилтын булаг болон Түвшин буйрын рашааны ойр орчмыг цэвэрлэгээ.....	53
Зураг 31. Хог цэвэрлэгээ хийх үеийн зураг.....	54
Зураг 32. Хуванцар сав преслэгч ажлуулж байгаа байдал.....	54
Зураг 33 Нүүрс тээврийн зам дагуу цэвэрлэгээ хийж байгаа нь.....	55
Зураг 34. Шатаах зууны танилцуулга болон худалдан авах гэрээ.....	56
Зураг 35. Ашиглалтаас гарсан аккумулятор, агаар шүүгч, тос маслоны шүүр, ашигласан тосыг түр хадгалах талбайд барлуулсан байдал.....	57
Зураг 36. Аюултай хог хаягдлын бүртгэлийн маягт.....	57
Зураг 37. Аюултай хог хаягдлын талбайн ерөнхий зураг, байгуулах газрын хөрс хуулалт ажил хийгдэж байгаа байдал.....	58
Зураг 38. Уст цэгүүдийн усыг химийн ерөнхий шинжилгээ.....	62
Зураг 39. Бохир ус соруулах болон шинжилгээ авч буй байдал.....	63
Зураг 40. Үенч Бодонч Булган голын сав газрын мониторинг.....	63
Зураг 41. Хөв байгуулах ажлын төлөвлөлтийн зураг.....	64
Зураг 42. Уурхайн Усан халаалтын зуухнуудын бамбар утааны дагуух хэмжилт.....	66
Зураг 43. Агаарын чанарын хяналтын цэгүүдийн байршил.....	67
Зураг 44. Уурхай орчмын агаарын тоосоны хэмжилт.....	67

Зураг 45. “DustTrak II Aerosol Monitor” багажсний үйлдвэрийн тохиргоо хийлгэсэн гэрчилгээ	68
Зураг 46. Хөрсний дээж	69
Зураг 47. Судалгааны талбайн байршлын зураг	70
Зураг 48. Судалгааны үр дүнгээр илэрсэн ургамалын төрөл зүйл	71
Зураг 49. Судалгааны үр дүнгээр илэрсэн макро-сээрнуруугүйтэн	71
Зураг 50. Дарви сум зэрлэг ан амьтад биотехникийн арга хэмжээ	72
Зураг 51. Цэцэг сум зэрлэг ан амьтад биотехникийн арга хэмжээ	73
Зураг 52. Үенч сум зэрлэг ан амьтад биотехникийн арга хэмжээ	74
Зураг 53. Алтай сум зэрлэг ан амьтад биотехникийн арга хэмжээ	75
Зураг 54. Булган сум зэрлэг ан амьтад биотехникийн арга хэмжээ	75
Зураг 55. Газрын төлөв байдлын, чанарын хянан баталгааны нэгж талбайн сүлжээний зураг	78
Зураг 56. Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны дүгнэлт цахимаар гарсан.	79
Зураг 57. Аймгийн БОГ болон Дарви сумын ЗДТГ-т хүлээлгэн өгсөн маягт	82
Зураг 58. Мөрөн багийн иргэдийн нийтийн хурал	82
Зураг 59. Байгаль орчны хийж хэрэгжүүлсэн ажлын цахим орчноор дамжуулан олон нийтэд мэдээлэл дамжуулсан байдал	83
Зураг 60. МоЭнко ХХК-ийн БО мэргэжилтэн, Усны ахлах гидрогеологич нар байгаль хамгаалах чиглэлээр “Эко клуб-ийн сурагчид танилцуулж байгаа агишин	84
Зураг 61. Дарви сумын Засаг дарга засаг дарга, МоЭнКо-ийн БОГазрын мэргэжилтэн, Дэлхийн байгаль хамгаалах сан(WWF)ҮББГСГЗ, ХГЦНСГЗахиргаа “Эко клуб”-ийн сурагчдыг үйл ажиллагаанд оролцоо	85
Зураг 62. Хоёр дахь удаагийн чуулга уулзалт, оролцсон багш, ажилчид оролцсон байдал	85
Зураг 63. Дарви сум болон ГИДЦГ-ын Б хэгийн хамгаалалтын бүс нутагт ангилан ялгалтын хогийн сав хүлээлгэн өгсөн	89
Зураг 64. Цэцэг нуурын хөвөөнд гүний усны түвшин ажиглах ажиглалтын цооног	90
Зураг 65. Эвдэрсэн газрын тооллог судалгааны ажилд санхүүгийн дэмжлэг үзүүлсэн баримт	91

График мэдээ

График 1. Хөшөөтийн уурхайн 2025 онд ашигласан гүний усны хэмжээ Well-2 худаг /2025.01.01-2025.10.31 -ийн байдал/	18
График 2. Хөшөөтийн уурхайн 2025 онд ашигласан гүний усны хэмжээ Well-1 худаг /2025.01.01-2025.10.31 -ийн байдал/	18
График 3. Хөшөөтийн уурхайн 2025 онд шүүрлийн усыг шавхан зайлуулсан хэмжээ	18
График 4. 2025 оны Well-1 худгийн усны түвшиний хэмжээ	20
График 5. 2025 оны Well-2 худгийн усны түвшиний хэмжээ	20
График 6. 2025 оны ВНД-3 цоонгийн усны түвшиний хэмжээ	20
График 7. 2025 оны WDH02 худгийн усны түвшиний хэмжээ	21
График 8. 2025 оны WDH03 худгийн усны түвшиний хэмжээ	21
График 9. Тахилтын булгийн ундрагын хэмжээ	21

Хүснэгтэн мэдээлэл

Хүснэгт 1. . Байгаль хамгаалах чиглэлээр хийгдсэн ажил	1
Хүснэгт 2. Мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн судалгаа шинжилгээний ажил	2
Хүснэгт 3. Тусгай зөвшөөрлийн мэдээлэл	5
Хүснэгт 4. Төслийн техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд	6
Хүснэгт 5. Ордын нөөц (B+C)	7
Хүснэгт 6. Ил уурхайн үндсэн хэмжээс	11
Хүснэгт 7. Ажиллах хүчний мэдээлэл	13
Хүснэгт 8. Техникүүд авто тээврийн үзлэгт хамрагдсан байдал	17
Хүснэгт 9. Тухайн жилд хийгдэх усны хиймийн шинжилгээний төрөл, тоо ширхэг	22

Хүснэгт 10. Унд-ахуйн ус ашиглалт (Нэг хүний хоногийн хэрэглээг 2025 оны 10 сарын 30 өдрийн байдлаар тооцсон байдал)	23
Хүснэгт 11. Хөшөөтийн уурхайн 2025 оны жилийн ашигласан усны хэмжээ, 10 дугаар сарын 31 - ны байдлаар	25
Хүснэгт 12. Хөшөөтийн уурхайн 2025 оны жилийн ашигласан усны хэмжээ Well-1 худаг, 2025.01.01-2025.10.31 -ийн байдлаар.....	26
Хүснэгт 13. Булгийн эх хаших газрын байршил болон талбайн хэмжээ	38
Хүснэгт 14. 2025 оны химийн бодис ашигласан мэдээ	49
Хүснэгт 15. Эмнэлэгийн үйл ажиллагаанаас гарсан эмнэлгийн аюултай хог хаягдал.....	55
Хүснэгт 16. Эко нойлуудыг дараах байршил	88
Хүснэгт 17. БОМТ 2025 оны тайлангийн зарцуулалтын задаргаа	91

Хавсралт материал

Хавсралт 1. Нэгдүгээр улирлын хөрсний дээжийг 2025.03 дугаар сард авч шинжилгээнд хамруулсан. Дээжний үндсэн үзүүлэлтүүд бохирдолгүй хэвийн хэмжээнд байна.	92
Хавсралт 2. Хоёрдугаар улирлын хөрсний дээжийг 2025.05 дугаар сард авч шинжилгээнд хамруулсан. Дээжний үндсэн үзүүлэлтүүд бохирдолгүй хэвийн хэмжээнд байна.	96
Хавсралт 3. Гуравдугаар улирлын хөрсний дээжийг 2025.09 дугаар сард авч шинжилгээнд хамруулсан. Дээжний үндсэн үзүүлэлтүүд бохирдолгүй хэвийн хэмжээнд байна.	100
Хавсралт 4. Цацрагийн дээжийг 2025. 10 дугаар сард авч шинжилгээнд хамруулсан. Дээжний үндсэн үзүүлэлтүүд бохирдолгүй хэвийн хэмжээнд байна.	104
Хавсралт 5. Нэгдүгээр улирал усны дээжийг 2025. 04 дугаар сард авч шинжилгээнд хамруулсан. Дээжний үндсэн үзүүлэлтүүд бохирдолгүй хэвийн хэмжээнд байна.	105
Хавсралт 6. Нэгдүгээр улирал бохир усны дээжийг 2025. 04 дугаар сард авч шинжилгээнд хамруулсан. Дээжний үндсэн үзүүлэлтүүд бохирдолгүй хэвийн хэмжээнд байна.	107
Хавсралт 7. Хоёрдугаар улирал бохир усны дээжийг 2025. 05 дугаар сард авч шинжилгээнд хамруулсан. Дээжний үндсэн үзүүлэлтүүд бохирдолгүй хэвийн хэмжээнд байна.	108
Хавсралт 8. Гуравдугаар улирал бохир усны дээжийг 2025. 09 дугаар сард авч шинжилгээнд хамруулсан. Дээжний үндсэн үзүүлэлтүүд бохирдолгүй хэвийн хэмжээнд байна.	110
Хавсралт 9. 311 км зам дагуу хог хаягдлын цэвэрлэгээний гэрээ	113
Хавсралт 10. Цэцэг сумтай хийгдсэн эмнэлгийн 2025 оны гэрээ.....	115
Хавсралт 11. Химийн бодис ашиглах тусгай зөвшөөрөл.....	117
Хавсралт 12. Лаборатори итгэмжлэлийн гэрчилгээ	119
Хавсралт 13. Булган сум биотехникийн арга хэмжээ акт	121
Хавсралт 14. Үенч сум биотехникийн арга хэмжээ акт.....	122
Хавсралт 15. Алтай сум Биотехникийн арга хэмжээ акт	123
Хавсралт 16. Цэцэг сум Биотехникийн арга хэмжээ акт	124
Хавсралт 17. Дарви сум ангилан ялгах хогийн сав хүлээлгэн өгсөн акт.....	125
Хавсралт 18. ГИДЦГ-ын Б хэсэг ангилан ялгах хогийн сав хүлээлгэн өгсөн акт.....	126
Хавсралт 19. ГИДЦГ-т самбар хүлээлгэн өгсөн акт.....	127
Хавсралт 20. Үенч сум самбарын хуулга эх бэлтгэл хүлээлгэн өгсөн акт.....	128
Хавсралт 21. Цэцэг сумын Хажинга багийн Давааны эхийн ус булгийн акт.....	129
Хавсралт 22. Дарви сумын Дэлгэр багийн 108 рашаан булгийн акт.....	130
Хавсралт 23. Үенч сумын Хөх үзүүр багийн Хөх үзүүрийн булгийн акт.....	131
Хавсралт 24. Дарви сумын Дэлгэр багийн 108 рашаан булгийн акт.....	132
Хавсралт 25. Булган сумын Алгатолгой багийн Шанагын булгийн акт.....	133
Хавсралт 26. Манхан сумын Тахилт багийн Зах булгийн ар техникийн нөхөн сэргээлт акт.....	134
Хавсралт 27. Мөст сумын Цэцэггол багийн Цагаан хөтөл техникийн нөхөн сэргээлт акт	137
Хавсралт 28. Цэцэг сум гүний усны хяналтын цооног акт	140
Хавсралт 29. Аюултай хог хаягдал шилжүүлэх гэрээ.....	142

ОРШИЛ

Хөшөөтийн чулуун нүүрсний ордыг ашиглах төслийн 2025 оны Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг боловсруулахдаа 2012 оны 5 сард УИХ-р хэлэлцэн баталсан байгаль орчны багц хуулиуд болон БОАЖЯ-ны сайдын 2019 оны 10 сарын 29-ны өдрийн А-618 тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежмент төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-г үндэслэн боловсруулсан төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэх бөгөөд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгалийн нөөц баялгийг ашиглах явцад байгаль орчныг доройтохоос урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, үлдэгдэл нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах, нөхөн сэргээх, нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох, түүх соёлын өвийг хамгаалахтай холбогдсон арга хэмжээг тодорхойлон, шаардагдах хөрөнгө зардлыг тооцож, хариуцах этгээд, хэрэгжүүлэх хугацаа, баримтлах хууль, журам, аргачлал, стандартыг тодорхойлж тусгасан байхаар, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төсөл хэрэгжүүлэх явцад байгаль орчинд үүсэж болзошгүй сөрөг нөлөөлөл өөрчлөлтийг хянах зорилгоор /гадаргын ба газар доорх усны хяналт шинжилгээ, агаарын чанарын хяналт шинжилгээ, хөрсний судалгаа, ургамал, амьтны судалгаа/ зэргийг хийж мэргэжлийн байгууллага, итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлж төлөв байдлыг хянаж ажиллаж байна.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь тухайн уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, сэргийлэх, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн ажлуудыг төлөвлөлттэй, хяналттайгаар хэрэгжүүлэх үндсэн баримт бичиг бөгөөд жил бүр тодорхой төлөвлөгөө, арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлж, гүйцэтгэлийн тайланг холбогдох байгууллагад тайлагнадаг.

2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль хамгааллын хууль тогтоомж, салбарын бодлого, стандартыг баримтлан, тухайн жилийн нөхцөл байдал, уурхайн үйл ажиллагааны цар хүрээтэй уялдуулан боловсруулагдсан. Тус төлөвлөгөөнд байгаль орчны мониторинг, нөхөн сэргээлт, хог хаягдлын менежмент, ус, хөрс, агаарын чанарын хяналт, биологийн олон янз байдлыг хамгаалах, орчны мэдээллийн ил тод байдал зэрэг олон чиглэлээр хэрэгжүүлэх ажлууд тусгагдсан болно. Мөн байгууллага нь байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үүргээ хариуцлагатайгаар биелүүлэхийн зэрэгцээ хууль, дүрэм журмын хэрэгжилтийг хангах, орон нутгийн иргэд болон төрийн байгууллагуудтай уялдаа холбоотой ажиллахыг чухалчилж, БОМТ-ийн хэрэгжилтийг үр дүнтэй зохион байгуулахын төлөө анхаарал хандуулан ажиллаж Монгол улсын хууль тогтоомжийн дагуу байгаль хамгаалах чиглэлээр дараах ажлуудыг мэргэжлийн байгууллага болон компанийн дотоод нөөц бололцоогоор хийж гүйцэтгээд байна. Үүнд:

Хүснэгт 1. . Байгаль хамгаалах чиглэлээр хийгдсэн ажил

№	Хийгдсэн ажлын нэр	Хийгдсэн он	Байршил	Тоо, хэмжээ
1	Техникийн нөхөн сэргээлт	2018-2025	Дарви сум	94.8 га
			Цэцэг сум	
			Алтай сум	
			Үенч сум	
			Булган сум	
			Мөст сум	
2	Булгийн эх хашиж хамгаалах	2018-2025	Дарви сум	22 ширхэг
			Цэцэг сум	
			Алтай сум	
			Үенч сум	
			Булган сум	

3	Биотехникийн арга хэмжээ	2020-2025	Дарви сум	2870 пресс, 20 тонн хужир
			Цэцэг сум	
			Үенч сум	
4	Хогийн цэгийн техникийн нөхөн сэргээлт	2018-2024	Дарви сум	122.7 га
			Цэцэг сум	
			Алтай сум	
			Үенч сум	
			Булган сум	
5	Гүнийн худаг	2022-2023	Дарви сум	3 ширхэг
			Цэцэг сум	
6	Мод, суулгац	2016-2025	Дарви сум	115400 ширхэг
			Цэцэг сум	
			Алтай сум	
			Үенч сум	
			Булган сум	
			Жаргалант сум	
			Богд хан уул	
Өвөр хангай аймаг Хар хорим				
7	Хашиж хамгаалсан талбай	2018-2025	Дарви сум	575 га
			Булган сум	
			Цэцэг сум	
8	Хүлээлгэн өгсөн хашааны тор, шон, төмөр утас	2020-2021	Цэцэг сум	14000 метр тор, 3000 ширхэг шон, 23 боодол төмөр утас
			Үенч сум	
			ҮББГСГЗ	
9	Самбар, тэмдэг тэмдэглэгээ	2018-2025	Дарви сум	51 ширхэг
			Цэцэг сум	
			ҮББГСГЗ	
			Үенч сум	
			Говийн Б хэсгийн хамгаалалтын захиргаа	

Хүснэгт 2. Мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн судалгаа шинжилгээний ажил

№	Судалгаа шинжилгээний ажил	Хийж гүйцэтгэсэн компани	Гүйцэтгэсэн он
1	Хөшөөт тус нутгийн байгаль орчны суурь судалгаа	Эко Алтай ХХК	2007 он
2	Хөшөөтийн нүүрсний уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайд газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа	Геоценоз ХХК	2009-2025 он
		Гурван тайга ХХК,	
		Давхар Ертөнц ХХК	
		Аватар ХХК	
3	Хөшөөтийн нүүрсний уурхайн БОНБНУ	Бөхөн Чингэлэг ХХК	2008-2025 он
		УМСМ ХХК,	
		ОЙТ БҮС ХХК	
4	Байгаль орчны аудитыг	Цэхи консалтинг ХХК	2014-2024 он
		Мөнх Мизу ХХК	

		ЭБГ Консалтинг ХХК	
5	Хөшөөтийн уурхайн ажилтнуудын кемп болон оффисын “Цэвэрлэх байгууламжийн төсөл”-ийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ	Давхар Ертөнц ХХК	2020 он
6	Хөшөөтийн нүүрсний уурхай орчмын ургамалжилт, амьтны аймгийн зүйлийн судалгаа	Монгол улсын их сургууль (МУИС)-ийн Ховд аймаг дахь салбарын Биологийн тэнхим	2023 он
7	Агаарын чанарын хяналт шинжилгээ	ЦУОХШГазар	2016-2025 он
		Грийн ази консалтинг	
8	Хөшөөт голын усны сээр нуруугүйтэн амьтад болон татмын амьдрах орчны судалгаа	Грийн трендс ХХК	2025 он
9	“Ашиглалтын үеийн нэмэлт хайгуул болон нүүрсний чанарын лабораторид химийн бодис ашиглах” төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотгол	Ойт бүс ХХК	2025 он

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 Төслийн ерөнхий мэдээлэл

Төслийн нэр: Хөшөөтийн чулуун нүүрсний ордыг ил уурхайн аргаар ашиглах төсөл

Төсөл хэрэгжүүлэгч байгууллага: “МоЭнКо” ХХК


Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 4 дүгээр хороо, Сөүлийн гудамж 23, Түшиг төв, 3 давхар, Утас: (976)-7711-0567, (976)-9911-0170 Вэб хуудас: www.moenco.mn, E-mail:oyunchimeg.ja@mongolia-energy.com

Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээ:

- Улсын бүртгэлийн дугаар: 9019023025
- Улсын регистрийн дугаар: 5141583

Ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөл:Хөшөөтийн нүүрсний уурхай нь (MV-015289, MV-011888, MV-011887, MV-006525, MV-004322, MV-001640, MV-001414, MV-020299) тоот ашиглалтын 8 тусгай зөвшөөрлийн 1885,02 га талбайг хамран үйл ажиллагаагаа явуулдаг.

Төслийн талбайн байршил: Хөшөөтийн нүүрсний орд нь Ховд аймгийн Дарви сумын Мөрөн багийн нутагт Монгол Алтайн нурууны зүүн урд төгсгөлийн хойд хэсэгт оршино. Тус орд нь Улаанбаатар хотоос баруун тийш 1300 км, Ховд хотоос зүүн урагш 210 км, Дарви сумаас баруун урагш 50 км, Цэцэг сумаас хойш 29 км-ийн зайд байрладаг.



Зураг 1. Хөшөөтийн нүүрсний ордын байршлын зураг

Хүснэгт 3. Тусгай зөвшөөрлийн мэдээлэл

№	Тусгай зөвшөөрлийн дугаар	Талбай,га	Талбайн солбицлууд	
			Өргөрөг	Уртраг
1	MV-001414	28.8	93° 19' 29.56"	46° 47' 51.49"
			93° 19' 7.56"	46° 47' 51.49"
			93° 19' 7.56"	46° 48' 11.5"
			93° 19' 29.56"	46° 48' 11.5"
2	MV-001640	40.87	93° 19' 14.56"	46° 48' 21.5"
			93° 18' 49.57"	46° 48' 21.5"
			93° 18' 49.57"	46° 48' 46.49"
3	MV-004322	53.97	93° 19' 14.56"	46° 48' 46.49"
			93° 19' 39.55"	46° 48' 11.5"
			93° 19' 14.56"	46° 48' 11.5"
4	MV-006525	45.79	93° 19' 14.56"	46° 48' 44.5"
			93° 19' 39.57"	46° 48' 44.5"
			93° 19' 39.55"	46° 47' 31.49"
			93° 19' 14.56"	46° 47' 31.49"
5	MV-011887	203.48	93° 19' 14.56"	46° 47' 51.49"
			93° 19' 29.56"	46° 47' 51.49"
			93° 19' 29.56"	46° 48' 11.5"
			93° 19' 39.55"	46° 48' 11.5"
			93° 19' 7.56"	46° 48' 11.5"
			93° 19' 7.56"	46° 47' 51.49"
6	MV-011888	1296.31	93° 19' 14.56"	46° 47' 51.49"
			93° 19' 14.56"	46° 47' 31.49"
			93° 18' 9.56"	46° 47' 31.49"
			93° 18' 9.56"	46° 48' 21.5"
			93° 19' 14.56"	46° 48' 21.5"
			93° 19' 14.56"	46° 48' 11.5"
			93° 21' 59.57"	46° 50' 41.49"
			93° 21' 59.56"	46° 48' 11.5"
7	MV-015289	39.25	93° 19' 39.55"	46° 48' 11.5"
			93° 19' 39.57"	46° 48' 44.5"
			93° 19' 14.56"	46° 48' 44.5"
			93° 19' 14.56"	46° 48' 46.49"
8	MV-020299	176.55	93° 18' 49.57"	46° 48' 46.49"
			93° 18' 49.57"	46° 50' 41.49"
			93° 19' 54.55"	46° 47' 31.49"
			93° 19' 39.55"	46° 47' 31.49"
			93° 19' 39.55"	46° 48' 11.5"
			93° 19' 54.55"	46° 48' 11.5"
			93° 19' 45.89"	46° 48' 51.73"
			93° 20' 21.97"	46° 48' 35.75"
			93° 20' 41.67"	46° 48' 11.5"
8	MV-020299	176.55	93° 19' 39.55"	46° 48' 11.5"
			93° 19' 39.57"	46° 48' 64.5"
			93° 19' 14.55"	46° 48' 44.5"
			93° 19' 14.56"	46° 48' 46.49"
			93° 19' 49.57"	46° 48' 48.49"
8	MV-020299	176.55	93° 19' 49.57"	46° 49' 17.75"
			93° 19' 23.93"	46° 49' 1.78"

Хүснэгт 4. Төслийн техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд

Д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Төслийн нийт	Жилийн дундаж
1	Уулын цул	сая.м ³	521,260.4	34,750.7
2	Хөрс хуулалт	сая.м ³	451,163.7	30,077.6
3	Нийт нүүрс олборлолт	сая.тн	112.15	
	Нүүрс (Ч2)	сая.тн	17.22	1.15
	Нүүрс (Ч3)	сая.тн	23.67	1.58
	Нүүрс (Ч4)	сая.тн	71.27	4.75
4	Нүүрс борлуулалтын хэмжээ	сая.тн	95.52	
	Шууд борлуулах нүүрс (Ч4)	сая.тн	3.00	0.20
	Баяжуулсан нүүрс	сая.тн	75.30	5.02
	Экспортлох эрчим хүчний нүүрс (Ч2)	сая.тн	12.82	0.85
	Орон нутагт борлуулах нүүрс (Ч2)	сая.тн	4.40	0.29
5	Борлуулалтын орлого	тэрбум.төг	30,340.42	2,022.69
6	Төслийн хөрөнгө оруулалт			
	Анхны хөрөнгө оруулалт	тэрбум.төг		614.9
	Үлдэгдэл өртөг	тэрбум.төг		456.2
	Нэмэлт хөрөнгө оруулалт	тэрбум.төг		203.0
7	Нүүрс борлуулалтын үнэ			
	Нүүрсний үнэ /Орон нутаг/	мян.төг		18
	Нүүрсний үнэ /Баяжуулаагүй Ч4/	мян.төг		258
	Баяжуулсан нүүрсний үнэ /Ч3/	мян.төг		306
	Баяжуулсан нүүрсний үнэ /Ч4/	мян.төг		309
	Эрчим хүчний нүүрсний үнэ	мян.төг		97
8	Татварын өмнөх ашиг	тэрбум.төг	8,766.4	584.4
9	Ашгийн татвар	тэрбум.төг	2,198.3	169.1
10	Цэвэр ашиг	тэрбум.төг	6,568.1	437.9
11	Ашигт ажиллагааны түвшин			
	Татварын өмнөх ашгийн түвшин (ТӨА/БО)	хувь		28.9%
	Цэвэр ашгийн түвшин (ЦА/БО)	хувь		21.6%
10	Төслийн шалгуур үзүүлэлт			
	Анхны хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа	жил		7
	Өнөөгийн үнэ цэнэ /NPV, i=10/	тэрбум.төг		1119.5
	Өнөөгийн үнэ цэнэ /NPV, i=15/	тэрбум.төг		327.8
	Өгөөжийн дотоод норм /IRR/	хувь		23%
11	Нийгэм эдийн засагт оруулах хувь нэмэр			
	Улсын төсөвт оруулах татвар, хураамж	тэрбум.төг	6,540.1	503.1
	Нөөцийн ашигласны төлбөр - 5%	тэрбум.төг	3,906.9	300.5
	Ашгийн татвар	тэрбум.төг	2,198.3	169.1
	ЭМД, НДШ	тэрбум.төг	95.3	7.3
	Хүн амын орлогын албан татвар	тэрбум.төг	19.4	1.5
	Лицензийн төлбөр	тэрбум.төг	0.02	0.0
	Усны төлбөр	тэрбум.төг	1.7	0.1
	АМӨЯХ-ийн татвар	тэрбум.төг	1.1	0.1
	Газрын төлбөр	тэрбум.төг	5.6	0.4
	Гаалийн төлбөр	тэрбум.төг	136.7	10.5
	Агаарын бохирдол	тэрбум.төг	112.2	8.6
	Орон нутгийг хөгжүүлэх санд	тэрбум.төг	63.0	4.8
	Үндсэн хөрөнгө борлуулсны татвар	тэрбум.төг	-	-
12	Нийт татвар хураамжийн Борлуулалтын орлогод эзлэх хувь	%		22%

1.2 Ордын нөөц

АМГТХЭГ-ын даргын 2007 оны 06-р сарын 18-ны өдрийн шийдвэрээр MV-001414, MV-001640, MV-006525, MV-004322, MV-011887, MV-011888, 2009 оны 11-р сарын 23-ны өдрийн шийдвэрээр MV-015289, АМГ-ын кадастрын хэлтсийн даргын 2015 он 12 сарын 04 өдрийн шийдвэрээр MV-020299 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийг Улсын бүртгэлийн 9019023025 тоот гэрчилгээтэй МоЭнКо ХХК-д 30 жилийн хугацаатай тус тус олгосон байна.

Хөшөөтийн уурхайд МоЭнКо ХХК 2007-2014 онуудын хооронд өөрийн хөрөнгөөр хайгуулын ажлыг гүйцэтгэж ордын нөөцийн тооцооны тайланг 2015 оны 11-р сарын 13-ны өдөр Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж 2015 оны 11-р сарын 13, 2016 оны 3-р сарын 18-ны өдрийн Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүгнэлтүүд, 2015 оны 12-р сарын 14, 2016 оны 04-р сарын 19-ны өдрийн Ашигт малтмалын газрын даргын н/138, н/139, н/140, н/141, н/142, н/143, н/144, н/48, н/49 тоот тушаалуудаар Хөшөөтийн нүүрсний ордыг бодитой (В) зэргээр 87,988.56 мян.тн нүүрс, боломжтой (С) зэргээр 32,216.82 мян.тн нүүрс, нийт 120,205.36 мян.тн нүүрсний нөөцийг Монгол Улсын Ашигт малтмалын нөөцийн нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлсэн байна. Улмаар төсөл хэрэгжүүлэгч “МоЭнКо” ХХК нь 2016-2020 онд өөрийн эзэмшидэг Хөшөөтийн чулуун нүүрсний ордын Хойд Хөндлөнгийн талбайд, MV-001640, MV-004322, MV-011887, MV-020299 тусгай зөвшөөрлийн хүрэн дотор нарийвчилсан хайгуул явуулж, нөөц ба баялгийн тооцоог 2021 оны 01-р сарын 01-ны байдлаар шинэчлэн тооцсон.

Хүснэгт 5. Ордын нөөц (В+С)

Нөөцийн зэрэглэл	Нүүрсний ангилал	Нүүрсний нөөц (мян.тонн)	Чулуулгийн үнийг оруулсан нөөц (мян.тн)
	Ч2	15,429.32	21,580.43
В	Ч3	18,169.64	25,148.48
	Ч4	55,607.18	77,230.50
	нийт	89,206.15	123,959.40
	Ч2	4,371.64	6,098.21
С	Ч3	5,195.38	7,320.35
	Ч4	21,513.06	30,270.92
	нийт	31,080.08	43,689.48
	Ч2	19,800.96	27,678.64
В+С	Ч3	23,365.02	32,468.83
	Ч4	77,120.24	107,501.42
	БҮГД	120,286.22	167,648.88

1.3 Дэд бүтэц

Ховд аймаг Баян-Өлгий, Увс, Завхан, Говь-Алтай аймагтай өмнөд, баруун өмнөд хэсгээрээ БНХАУ-тай хиллэн оршдог. Хөшөөтийн уурхай нь Дарви сумын Мөрөн багийн нутагт байрлах ба сумын төвд 128 өрхийн 572 орчим хүн амьдардаг. Уурхай нь дэд бүтцийн хангамж үндсэндээ бүрэн хангагдсан. 2014 онд нүүрсийг хуурай аргаар баяжуулах үйлдвэрийг улсын комисст хүлээлгэн өгч одоогоор үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.

Уурхайн барилга байгууламж

Уурхайн захиргааны барилгууд, Хүндлэл кемп, Засварын газар, Уулын оффис, Гаалийн хяналтын талбай, хуурай баяжуулах үйлдвэр үйл ажиллагаа явуулж байна.

Үйлдвэрийн туслах барилга байгууламж

Хөшөөтийн нүүрс баяжуулах үйлдвэрийн дэргэд хяналт шинжилгээний лаборатори, үйлдвэрийн засвар механикийн хэсэг, үйлдвэрийн удирдлагын өрөө, үйлдвэрийн оффис зэргийг төлөвлөж барьсан.

Хяналт шинжилгээний лаборатори: Хөшөөтийн уурхайн лаборатори нь 2013 оны 3 сараас үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. Лаборатори нь 20 гаруй төрлийн 50 орчим тоног төхөөрөмжтэй.

Үйлдвэрийн ажилтнуудын оффис:

Энэ оффис нь баяжуулах үйлдвэрээс баруун урд зүгт үйлдвэрийн хашааны гадна талд 152 м² талбайг хамарсан 5 м-ийн өндөртэй сэндвичэн байгууламжид байрлана. Үйлдвэрийн оффис нь инженер, техникийн ажилчдын өрөө, хувцас солих өрөө, ариун цэврийн өрөө, сургалт, семинар, зааварчилгааны өрөөтэй. Тус үйлдвэрийн оффисыг 2015 оны 9 дүгээр сарын 1-нд ашиглалтанд оруулсан.

Үйлдвэрийн засварын хэсэг: Засварын хэсэг нь нүүрс баяжуулах үйлдвэр (НБҮ)-ийн тоног төхөөрөмжүүдэд урьдчилсан төлөвлөгөөний дагуу ээлжит засвар хийхийн зэрэгцээ, шинээр сууриллагдах тоног төхөөрөмжийг угсрах, аваарын үед шаардлагатай тоног төхөөрөмжүүдийн засвар, гагнуурын болон бусад ажлыг гүйцэтгэнэ.

Үйлдвэрийн удирдлагын өрөө: Орчин үеийн удирдах систем нь НБҮ-ийг удирдлага болон хяналтаар хангаж ажилладаг. Үйлдвэрийн удирдлагын өрөө нь НБҮ-ийн зүүн хойд талд байрлана. НБҮ нь автомат, хагас автомат, механик ажиллагаатай бөгөөд удирдлагын өрөөнд 3 камер, үйлдвэрийн хэсэгт 5 камерыг суурилуулсан.

Операторын хяналт нь үйлдвэрийн удирдлагын өрөөнд байрлах бөгөөд хяналтын системийн дэлгэцүүд нь үйлдвэрийн үе шат процесстой логик хамааралтай, дараалал бүхий хөдөлгөөнт дүрс, зураг болон хүснэгтэн мэдээллүүдийг агуулна. Эдгээр дэлгэцүүд нь тоног төхөөрөмжүүдийг удирдах, тэдгээрийн төлөв байдлыг хянахад хялбар бөгөөд, өргөн боломжийг олгоно. Мөн уг систем нь мэдээллийг хадгалж архивлах, төрөл бүрээр тайлан гаргах болон алдааны мэдэгдэл харуулах боломжтой. Системийн хүчин чадал найдвартай ажиллагаа нь сүлжээний төхөөрөмжүүдийн зөв сонголт, суурилуулалт кабелийн ажил болон тоног төхөөрөмжийн хамгаалалт найдвартай тэжээлийн эх үүсвэрээр хангагдсан.

Ус хангамж

Гидрогеологийн судалгааны ажлын хүрээнд 2007 онд Хөшөөтийн уурхайгаас 50 км радиустай талбайн хэмжээнд геофизикийн судалгаа явуулан, газрын доорх устай 5 талбайг ялган, 2015 онд Бооржийн голын адгийн хөндий болон Хөшөөтийн голын хөндийд тус тус ашиглалтын нөөцийг батлуулсан. Хөшөөтийн голын хөндийд 2008, 2011 онуудад өрөмдсөн 3 цооногт шавхалт туршилтын ажлыг гүйцэтгэн газрын доорх усны нөөцийг үйлдвэрлэлийн С зэргээр үнэлж 18.5 л/с буюу 1598.4 м³/хоногоор БОАЖЯамны Усны нөөцийн зөвлөлийн 2013 оны 10-р сарын 15-ны өдрийн 05 дугаар тогтоолоор баталсан. Хөшөөтийн уурхайн үйлдвэрлэлийн болон унд, ахуйн усны хэрэглээг усан орчинд үзүүлэх нөлөө, үнэлгээний хэсгээс дэлгэрүүлж үзнэ үү.

Хөшөөтийн уурхайн усан хангамжийг Хөшөөт голын хөндийд байрлах Well 2 худаг болон Хөндлөнгийн хагарлын дагуу өрөмдсөн шүүрүүлэн шавхах зориулалттай WDH-028 WDH-03 худгуудаас хангадаг.

Бооржийн голын адгийн хөндийн талбай нь уурхайгаас 45-60 км зайд орших ба газрын доорх усны урьдчилсан болон нарийвчилсан судалгааны ажил хийгдсэн. Энэ ажлаар Бооржийн голын адгийн хөндийн талбайн газрын доорх усыг үйлдвэрлэлийн С1 зэргээр 18765 м³/хоног буюу 217.2 л/сек ашиглалтын нөөцийг БОАЖ Яамны сайдын 2009 оны 12-р сарын 07-ны өдрийн 377 дугаар тушаалаар батлуулсан. Одоогоор энэ талбайгаас ус ашиглаагүй байна.

Ариун цэврийн байгууламж

“Хүндлэл” кемп нь 250-300 хүний бохир ус цэвэрлэх байгууламжтай. Бохир ус цэвэрлэх байгууламж нь байгаль орчинд ямар нэгэн хор нөлөөгүй.

Ахуйн бохир усыг урсахгүйгээр цооногтоо боловсруулах боломжтой ус цэвэршүүлэх төхөөрөмж юм. Цэвэрлэх байгууламж руу урсаж орсон бохир усыг хүчилтөрөгчгүй орчинд боловсруулсны дараа хөрсний боловсруулах төхөөрөмж рүү илгээгдэж хөрсний бичил биетээр

хүчилтөрөгчтэй орчинд амьдрах чадвартай задралыг явуулна. Тус байгууламжийг цахилгаангүй газарт суурилуулах боломжтой. Байгалийн шалгарсан цэвэршүүлэх чадварыг бүрэн ашигладаг систем учраас ердийн ажиллагааны аргатай харьцуулахад засвар үйлчилгээний зардал болон ажиллагааны ачаалал багатай. Цэвэрлэх процесст ашиглагддаг нэвчүүлэн цэвэршүүлэх материалтай хатуу хаалт болон ус нэвтрүүлдэггүй хучилгат бокс зэрэг хөрсний даралтанд нилээд уян хатан шинж чанартай бат бөх болно. Мөн хүчиллэг, шүлтлэг шинж чанарт тэсвэртэй бөгөөд зэврэлтээс хамгаалах шинж чанартай тул байнгын хэрэглээ болгох боломжтой.

Тус байгууламж нь дараах 3 хэсгээс бүрдэнэ.

- ✓ Анхны ялган боловсруулах хэсэг
- ✓ 2-р ялган боловсруулах хэсэг
- ✓ Шүүх хэсэг

Ялган боловсруулах танкны систем нь хөрсний байгалийн цэвэршүүлэх чадварыг дээд зэргээр ашигладаг ус дахин ашиглах боломжтойгоор цэвэршүүлэх систем юм. Ялган боловсруулах төхөөрөмжид оруулсан бохир усыг хүчилтөрөгчгүй орчинд боловсруулсны дараа хөрс боловсруулах төхөөрөмж рүү илгээх бөгөөд хөрсний бичил биетээр хүчилтөрөгчтэй орчинд амьдрах чадвартай задралыг явуулдаг.

Цахилгаан хангамж

Хөшөөтийн нүүрсний уурхайг 16 ширхэг дизель генератор болон Баруун бүсийн ЦДАШ-аас хангаж байна. Баруун бүсийн эрчим хүчний системээс цахилгаанаар хангахын тулд 110/35/10 кВ-ын "Манхан" дэд станцын 110 кВ-ын хуваарилах байгууламжийг өргөтгөж төслийн талбай хүртэл 35 кВ-ын шугам татсан.

Зам, харилцаа холбоо

"МоЭнКо" ХХК-ийн хувьд Хөшөөт-Булган Ярантын чиглэлд 311 км хатуу хучилттай замыг 2011 онд байгуулж ашиглалтанд оруулсан.

Уурхайн тосгонд Мобиком, Скайтел, Юнител болон Жи-Мобайлын сүлжээг ашигладаг ба ил уурхайд богино долгионы радио холбоо ашиглаж байна. Уурхайн оффис Мобикомын сүлжээг ашиглан интернэтэд холбогддог, уурхайн тосгонд сансарын антенн суурилуулж телевизийн сувгууд хүлээн авдаг.

Дулаан хангамж

Өвлийн улиралд барилга, байгууламжийг нүүрсээр галладаг усан халаалтын зуухаар халаадаг. Нүүрс баяжуулах үйлдвэр болон бусад туслах нэгжүүдийн уурын зуухыг үйлдвэрлэлийн талбайд байрлуулж, үйлдвэрийн барилга байгууламжийн дулаан хангах эх үүсвэр болгон ашиглана. Уурын зууханд шаардлагатай нүүрсийг баяжуулах үйлдвэрээс гарах эрчим хүчний нүүрсээр хангана.

1.4 Нүүрс олборлолт, ил уурхайн хүчин чадал

"Хөшөөт"-ийн ордыг ил аргаар ашиглах ТЭЗҮ-д тусгаснаар ил уурхайн олборлолтын хүчин чадал эхний жилд 1.6 сая.тн, хоёр дахь жилд 2.6 сая.тн, 3 дахь жилээс 3-4 сая.тн нүүрс олборлохоор төлөвлөсөн. Дээрх хүчин чадлаар ил уурхай нийт 25 жил ажиллана.

Ил уурхайгаас олборлох Ч2, Ч3, Ч4 ангиллын нийт 84.4 сая.тн үйлдвэрлэлийн нөөцийн нүүрсийг баяжуулах үйлдвэрт тэжээж "Хүнд орчны циклон + TBS сепаратор + Флотаци" -ийн технологиор баяжуулна. Баяжуулсан коксжих нүүрс, эрчим хүчний нүүрс, нунтаг нүүрс гэсэн 3 бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ.

Ордын уул-геологийн нөхцөлөөс хамааруулан уурхайн хөрс хуулалт, нүүрс олборлолтын ажлыг экскаватор-автосамосвалын хослолоор автотээвэртэй ашиглалтын системээр гүйцэтгэнэ.

1.5 Нүүрс баяжуулах технологи, тоног төхөөрөмж


Хөшөөтийн чулуун нүүрсний уурхай нь нүүрсийг механик бохирдлоос ангилан ялгах хуурай баяжуулах технологитой. Хөшөөтийн нүүрс баяжуулах үйлдвэр нь бэлтгэх хэсэг, ангилан баяжуулах хэсэг, гаалийн хяналтын гүний бүс гэсэн үндсэн 3 хэсгээс бүрдэнэ. Нүүрс баяжуулах үйлдвэрийн жилийн хүчин чадал: 2.8 сая. тн/жил (дундажаар) хоногт 2 ээлжээр, ээлжиндээ 11 цагаар ажилладаг.

Баяжуулах үйлдвэрт ил уурхайгаас ирсэн түүхий нүүрсийг үл хөдлөх шигшүүрийн тусламжтайгаар шигшинэ. 500 мм-ээс дооших ширхэглэлтэй нүүрс хүлээн авах бункерээр дамжин гинжит конвейерээр тээвэрлэгдэн шүдтэй давхар булт бутлуур руу орно. Нүүрс бэлтгэх ажлыг зогсолтгүй байлгах үүднээс нүүрс хүлээн авах бункерийн ойролцоо талбайд нүүрс хүлээн авах тэжээлийн талбай 2-ыг байгуулсан. Түүхий нүүрс хүлээн авах тэжээлийн талбай дээр утгуурт ачигчийг ашигладаг.

Бутлуураас 0-80 мм ширхэглэлтэй болтол бутлагдана. Бутлагдсан нүүрс туузан конвейроор тээвэрлэгдэн хуурай ангилах төхөрөөмж рүү ачаалагдана. Хуурай ангилах төхөрөөмжөөс коксжих нүүрс болон хаягдал гэсэн 2 бүтээгдэхүүн гарна.

Нүүрс баяжуулах тоног төхөөрөмж

Баяжуулах үйлдвэрийн тоног төхөрөөмжийг технологийн туршилтын үр дүн, үйлдвэрийн түүхий эдийн нөөц, тоног төхөрөөмжийн хүчин чадал, өртөг зардал, ашигт ажиллагааны түвшин, сэлбэг хэрэгслийн олдоц, бүс нутгийн дэд бүтэц гэх мэт хүчин зүйлүүдийг үндэслэн сонгосон. Засвар үйлчилгээ, сэлбэг материалын хангалт, нүүрс баяжуулах технологи ажиллагааг тасралтгүй найдвартай байлгах үүднээс тоног төхөрөөмжүүдийг нэг брэндийн ижил төрлийн тоног төхөрөөмжүүд байх нь давуу талтай гэж үзэн багц төхөрөөмжийн сонголтыг хийсэн байна.



Зураг 2. Тоног төхөрөөмжийн холболтын бүдүүвч

1. Үл хөдлөх шигүүр, 2. Хүлээн авах бункер, 3. Гинжит тэжээгүүр, 4. Булт бутлуур, 5. Бутлагдсан нүүрсний туузан конвейер, 6. Хуурай ангилах багц төхөрөөмж, 7. Бүтээгдэхүүний туузан конвейер, 8. Завсрын бүтээгдэхүүний туузан конвейер, 9. Хаягдлын туузан конвейер, 10. Төхөрөөмжийн хуваарилах конвейер

1.6 Өрөмдлөг, тэсэлгээний ажил

Хөшөөтийн ордын хөрсний дээд хэсэг нь суларч өгөршсөн байдаг ба үндсэн чулуулаг нь элсжин, элсэрхэг шаваржин, шаваржингаас голлон бүрддэг. Өгөршлийн бүсийн зузаан 3 м. Хөрсний ихэнх нь үндсэн чулуулаг бөгөөд гуу жалга хэсгээр дөрөвдөгчийн сэвсгэр хурдас дүүргэгч байдлаар хучдаг. Үндсэн чулуулгууд нь ихэвчлэн салаавчилсан тогтоцтой байдаг.

Тус ордын чулуулгийн физик-механикийн шинж чанар, уурхайн жилд гүйцэтгэх уулын ажлын хэмжээ зэргийг үндэслэн дунд зэргийн хатуулагтай чулуулаг өрөмдөх зориулалт бүхий өрмийн машин ажиллуулах нь тохиромжтой.

Хөрсний чулуулгийн нэг тэсэлгээний блокын өндөр 15 м, өргөн 12.5 м байна. Нэг удаагийн тэсэлгээний блокын эзлэхүүн төслийн техникийн даалгаврын дагуу 3 үе шаттайгаар өөрчлөгдөн нэмэгдэх тул ашиглалтын жилүүдэд өөр өөр хэмжээтэйгээр тогтоогдсон. Уурхай жилд нийт 324.902 мян.у.м өрөмдөж 4,805.5 тн тэсрэх бодис хэрэглэнэ. Тэсэлж бэлтгэсэн уулын цулын нормоор экскаваторын ажлыг 7-14 хоногийн бэлэн нөөцтэй байхаар тооцож уулын ажлыг зохион байгуулдаг. Уурхайн блок-д явуулах өрөмдлөг-тэсэлгээний ажлын хэмжээг тооцоолон, тус уурхайн тэсэлгээний ажлын механикжилтад зориулан цэнэглэгч болон түгжигч машинуудыг хэрэглэхээр тусгасан. Цэнэглэх, түгжих ажлын хэмжээ нь уурхайн 7 хоногийн нөөц бүхий ачих, тээвэрлэх тоног төхөөрөмжийн ажлын хэмжээнээс хамаарна. Нэг удаа блокийн цэнэглэх ажлын хэмжээ хөрсөн дээр 160 цооног байна. Цэнэглэгч машин нь өдөрт 18.0 тн цэнэглэдэг. 160 цооногт нийт 25.8 тн тэсрэх бодис орно. Дээрх цэнэглэгч машин нь 160 цооногийг 1 хоногт 2 цэнэглэлтээр цэнэглэхээр байна.

1.7 Уурхайн тээвэр

Уурхайн ашиглалтын технологийн дагуу гаргасан уулын цулыг тээвэрлэх ажлыг экскаватор-автомашинны хослолоор сонгогдсон тээврийн хэрэгслээр гүйцэтгэнэ. Календарчилсан төлөвлөгөөнд тусгагдсан хуулах хөрсийг гадаад овоолгод, олборлосон нүүрсийг уурхайн мөргөцгөөс баяжуулах үйлдвэр хүртэл дотоод технологийн тээврээр гүйцэтгэнэ.


1.8 Ил уурхайн үндсэн хэмжээс, загварчлал

Ил уурхайн үндсэн хэмжээсүүдийг одоогийн ашиглагдаж буй уурхайн хэмжээсүүдэд үндэслэн хөрс, нүүрсний тэсэлгээний доголын өндрийг 15м, эцсийн байрлал дахь доголуудын өндрийг 15м, уурхайн хажуугийн ерөнхий өнцгийг 35-37°-аар тус тус тооцжээ. Ил уурхайн үндсэн хэмжээсүүдийг доорх хүснэгтэд харуулав.

Хүснэгт 6. Ил уурхайн үндсэн хэмжээс

№	Ашиглалтын технологийн элементүүд	Хэмжих нэгж	Параметрууд
1	Хөрс, нүүрсний тэсэлгээний доголын өндөр	м	15
2	Эцсийн байрлал дахь доголуудын өндөр	м	15
3	Уурхайн хажуугийн өнцөг	Град	35-37
4	Ажлын бус доголын хажуугийн өнцөг	Град	65
5	Ажлын доголын хажуугийн өнцөг	Град	65
6	Аюулгүйн бермийн өргөн	м	10

Уурхайн ерөнхий хажуу налууугийн өнцгүүд, уурхайн ажлын бус доголын налууугийн өнцөг, бермийн өргөн, доголын өндрийн үзүүлэлтүүд нь 2021-2022 онуудад Бүгд найрамдах Хятад ард улсын “CNBM Геологийн инженер хайгуул судалгааны хүрээлэн” -тэй хамтарч гүйцэтгэсэн геотехникийн тайланг үндэслэн тодорхойлсон үзүүлэлтүүд болно. Энэхүү төсөлдөө уурхайн одоогийн байдал болон геотехникийн тайланг үндэслэн ашиглалтын системийн элементүүдийг тооцсон.



Зураг 3. Ил уурхайн ашиглалтын эцсийн байдал

1.9 Усан хангамж

Гидрогеологийн судалгааны ажлын хүрээнд 2007 онд Хөшөөтийн уурхайгаас 50 км радиустай талбайн хэмжээнд геофизикийн судалгаа явуулан, газрын доорх устай 5 талбайг ялган, 2015 онд Боорчийн голын адгийн хөндий болон Хөшөөтийн голын хөндийд тус тус ашиглалтын нөөцийг батлуулсан. Хөшөөтийн голын хөндийд 2008, 2011 онуудад өрөмдсөн 3 цооногт шавхалт туршилтын ажлыг гүйцэтгэн газрын доорх усны нөөцийг үйлдвэрлэлийн С зэргээр үнэлж 18.5 л/с буюу 1598.4 м³/хоногоор БОАЖЯамны Усны нөөцийн зөвлөлийн 2013 оны 10-р сарын 15-ны өдрийн 05 дугаар тогтоолоор баталсан. Хөшөөтийн уурхайн үйлдвэрлэлийн болон унд, ахуйн усны хэрэглээг усан орчинд үзүүлэх нөлөө, үнэлгээний хэсгээс дэлгэрүүлж үзнэ үү. Хөшөөтийн уурхайн усан хангамжийг Хөшөөт голын хөндийд байрлах Well 2 худаг болон Хөндлөнгийн хагарлын дагуу өрөмдсөн шүүрүүлэн шавхах зориулалттай WDH-02, WDH-03 худгуудаас хангадаг. МУ-ын Усны тухай хуулийн дагуу Монгол улсын ЗГ -ын хэрэгжүүлэгч агентлаг Усны газрын 2025 оны 8 дугаар сарын 28-ний өдрийн E-2508-000021 тоот Ус ашиглах дүгнэлт, Хүйсийн говь-Цэцэг нуурын сав газрын захиргааны 2025 оны 8 дугаар сарын 29-ны өдрийн А/13 тоот Ус ашиглах зөвшөөрөл, Хүйсийн говь-Цэцэг нуурын сав газрын захиргаа болон МоЭнКо ХХК-ийн хооронд байгуулсан 2025 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн №02/2025 тоот Ус ашиглах гэрээ, Ховд аймгийн Байгаль орчны газрын 2024 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн 2024/01 албан тоот Ус ашиглах эрхийн бичгийг 2027.8.14-г хүртэл 3 жилээр сунгасан зэрэг баримт бичгийг дээрх хуулийн хүрээнд бүрдүүлэн ажиллаж байна. Хөшөөтийн уурхайн ус ашиглалтын төлбөрийг Хүйсийн говь-Цэцэг нуурын сав газрын захиргаа болон МоЭнКо ХХК-ийн хооронд байгуулсан 2025.8.29-ний өдрийн 02/2025 дугаартай Ус ашиглах гэрээний дагуу унд ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар ашигладаг Well-2, Well-3 дугаартай худгийн тоолуурын заалтыг үндэслэн сард нэг удаа Ховд аймгийн төрийн сангийн 160000944 тоот дансанд төлдөг.

1.10 Ажиллах хүчний тухай мэдээлэл

Хөшөөтийн уурхайн хүрээнд 2025 оны 10 дугаар сарын 30-ны байдлаар нийтдээ 2430 ажиллагсад байгаа бөгөөд дараах компанийн ажилтнууд ажиллаж байна. Үүнд:

Хүснэгт 7. Ажиллах хүчний мэдээлэл

Хөшөөт төсөл ажиллах хүчний мэдээлэл-2025.10.30		
№	Байгууллагын нэр	Ажилтнуудын тоо
1	МоЭнКо ХХК Хөшөөтийн уурхай	466
2	МоЭнКо ХХК УБ оффис	
3	Эм И Си Транс	43
МоЭнКо ХХК-ийн туслан гүйцэтгэгч байгууллагууд		
1	Бумбат зүрх ХХК	57
2	Монруд ХХК	75
3	Эммед Партнер ХХК	6
4	Алтайн Зам ХК	571
5	Мезом ХХК	212
7	Нүүрс тээвэр 25 компани	1000
Төслийн нийт ажиллах хүч		2430

БҮЛЭГ 2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нийт зардал мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Биелэлтийн шалгуур	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр	Уурхайн технологийн замаас үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор зам талбайн усалгаа хийх, замын засвар, арчилгааг тогтмол хийлгэж хянаж байх.	Төслийн зам талбай	-	Тогтмол	Уурхайн олборлолтын зам талбайн тээвэрлэлтээс үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор тээврийн хэрэгслүүдийн хурдны хязгаарт зохицуулалт хийж хурдны хязгаарыг 5, 10, 30 км/ц хурдтай явах зохицуулалт хийсэн. Мөн хурдны дээд хязгаарыг заасан замын тэмдэг тэмдэглэгээг олборлолтын зам талбайд байрлуулсан. Уурхайн технологийн замын тоосжилтыг бууруулах зорилгоор туслан гүйцэтгэгч гэрээт компаниудын 20-40 тн-ын даацтай 5 усны машин ашигалтын 2 худгаас ус авч усалгаа хийж байна. 2025 оны 10 дүгээр сарын 30 өдрийн байдлаар 95,236.0 шоо метр ус зарцуулсан байна. Түүнчлэн олборлолтын зам талбайн туурин сул шороог 7 хоног бүр хусах 2 автогрейдер тогтмол ажиллуулж GPS-ээр хянан ажиллаж байна. Дэлгэрэнгүй мэдээллийг харна уу.	MNS 4585 :2016 Агаарын чанар,техникийн ерөнхий шаардлага Байгаль орчныг хамгаалах тухай хууль
2		Техник хэрэгслүүдийн эвдрэл гэмтлийг хянаж, техникийн хэвийн ажлын горимыг ханган ажиллах, тээврийн хэрэгслийн яндангаас ялгарах хорт утааг үйлдвэрлэгчээс гаргасан хэм хэмжээнд байлгах, үзлэг оношилгоонд хамруулах.	Төслийн талбайд ашиглагдаж байгаа хөнгөн тэрэгнүүд	1,090,000	Тогтмол	Хөшөөтийн уурхайд ажиллаж байгаа техник хэрэгслүүдийн эвдрэл, гэмтэлд мэргэжлийн засвар үйлчилгээний баг хяналт тавьж, шаардлагатай засвар үйлчилгээг тогтмол хийж ажиллаж байна. Үүнд: <ul style="list-style-type: none"> • Өдөр бүрийн ажил эхлэхийн өмнөх техникийн тойрох үзлэг • Улирал бүрийн үзлэг • Авто тээврийн улсын үзлэг МоЭнКо ХХК-ийн 64 тээврийн хэрэгслээс 30 хөнгөн тэрэг ашиглаж байна. 2025 онд 45 тээврийн хэрэгслийг авто тээврийн хяналтын улсын үзлэг оношилгоонд оруулсанаас техник хэрэгслүүдийн эвдрэл гэмтлийг хянаж, яндангаас ялгарах хорт утаа стандарт хэм хэмжээнд үл нийцсэн 3 тээврийн хэрэгслийг ашиглалтаас түр зогсоосон . Дэлгэрэнгүй мэдээллийг харна уу.	Агаарын тухай хууль, MNS 5014:2009 Дизель хөдөлгүүртэй автомашин Утааны тортогжилтын зөвшөөрөх дээд хэмжээ ба хэмжих арга
3	Гадаргын болон газрын доорх усны нөөц	Хүйсийн говь, Цэцэг нуурын сав газрын захиргаатай ус ашиглах гэрээ байгуулж, ус ашигласны төлбөр төлөх.	Усан хангамжийн эх үүсвэр, шүүрлийн ус, уурхай орчмын уст цэгүүд	23,946,736	Гэрээнд заасан хугацаа бүрт	Хүйсийн говь-Цэцэг нуурын сав газрын захиргаа болон МоЭнКо ХХК-ийн хооронд “Ус ашиглах гэрээ” 2025 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн №02/2025 тоот гэрээг байгуулсан. Ус ашигласны төлбөрийг гэрээнд заасны дагуу унд ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар ашигладаг Well-2, Well-3 дугаартай худгийн тоолуурын заалтыг үндэслэн сард нэг удаа Ховд аймгийн төрийн сангийн 160000944 тоот дансанд төлдөг. Мөн 2025 оны 08-р сарын 28-ны өдрийн E-2502-000021 дугаартай Ус ашиглуулах дүгнэлтийг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газраас авсан. Дэлгэрэнгүй мэдээллийг харна уу.	Ус ашиглуулах дүгнэлт гаргах үйлчилгээний хөлс, ус ашиглах эрхийн бичгийн загварыг шинэчлэн батлах тухай (БОАЖС-ын 2018 оны 10 сарын 2-ны өдрийн А/376 дугаар тушаал)

4		Аливаа газар хөндөх үйл ажиллагааны өмнө шимт хөрс болон шимэрхэг хөрсний гүнийг талбай тус бүрд тогтоож, тогтоосон хэмжээнд хуулж хадгалах. (шинээр хөрс хуулах бүрт)	Уурхай орчим	Үйл ажиллагааны зардлаас	Тогтмол	2025 оны 10 дугаар сарын байдлаар нийт 5.62 га газраас 1,505 м ³ шимт хөрс хуулсан байна. Уурхайн үйл ажиллагаа эхэлснээс хойш нийт 196,606.7 м ³ шимт хөрсийг MNS 5916:2008 стандартын дагуу хадгалж байна. Шимт хөрсний үржил шимийг урт хугацаанд хадгалах зорилгоор Ботууль, Ерхөг, Өлөнгө, Дааган сүүл зэрэг олон наст ургамлыг тарьж, ургуулах ажлыг зохион байгуулан, усалгаа арчилгааг тогтмол хэрэгжүүлж байна. Дэлгэрэнгүй мэдээллийг харна уу.	Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт MNS 5859:2008 “Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх хэмжээ” Байгаль орчны аудитын үл нийцэл
5	Хөрсөн бүрхэвч	Асгаралттай холбоотой үүссэн бохирдсон хөрсийг хуулж авах, саармагжуулах	Засварын газар	Үйл ажиллагааны зардлаас	Тогтмол	Компанийн засварын газар болон оффисийн барилга байгууламжийг шинэ суурьшлын бүсрүү шилжүүлэхтэй холбогдуулан тухайн шинэ суурьшлын бүсийн төлөвлөлт зохион байгуулалтын дагуу “Аюултай хог хаягдлыг түр хадгалах цэг”-ийг байгуулж таних тэмдэг тэмдэглэгээ байрлуулах ажлыг төлөвлөж шат дараатайгаар хэрэгжүүлж байна. Асгаралтаас үүдэлтэй бохирдсон хөрсийг EM-1 бодисоор саармагжуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаж байна. Дэлгэрэнгүй мэдээллийг харна уу.	
6	Хуурай баяжуулах үйлдвэр болон гаалийн хяналтын ачиж буулгах талбайд тоосжилт бий болох	Хуурай баяжуулах үйлдвэрийн тэжээлийн талбай, Гаалийн хяналтын талбайн ачиж буулгах үйл ажиллагаанаас үүсэх нүүрсний нарийн ширхэгт тоосонцрын дэгдэлтийг бууруулах зорилгоор мананжуулагч машинаар усалгаа хийх.	Хуурай баяжуулах үйлдвэрийн тэжээлийн талбай, Нүүрс ачиж, буулгах талбай	ажиллагааны зардлаас	Тогтмол	Хуурай баяжуулах үйлдвэр, гаалийн хяналтын талбай дахь нүүрс ачиж буулгах процессоос үүсэх тоосны хэмжээг бууруулах сөрөг нөлөөллийг багасгах үүднээс 4 мананжуулагч машинаар мананжуулах усалгааг тогтмол авч хэрэгжүүлж байна. Дэлгэрэнгүй мэдээллийг харна уу.	MNS 4585:2016 Агаарын чанар, Техникийн ерөнхий шаардлага, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Агаарын тухай хууль,
Сөрөг нөлөөллийг бууруулах нийт зардал, мян.төг						25,036,736	


СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2.1 Уурхайн технологийн замаас үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор технологийн замын усалгааг тогтмол хийх:

Уурхайн технологийн замууд болон ажилчдын кемпээс уурхайн оффис чиглэлийн замуудад тоосжилтыг бууруулах, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор зам усалгааны ажлыг туслан гүйцэтгэгч гэрээт компаниудын нийт 5 усны машин, 4 мананжуулагч машин ашиглан тоосжилтын эсрэг арга хэмжээ авч ажилласан.

Дулааны улиралд усалгааг өдөр бүр тогтмол, хүйтний улиралд шаардлагатай тохиолдолд хийж гүйцэтгэдэг. Уурхайн хэмжээнд тогтмол ашиглагдаж буй технологийн замын нийт урт нь 17.45 км, замын дундаж өргөн 20 метр байна.

Замаар тээвэрлэлт ихтэй үед усалгааны давтамжийг нэмэгдүүлж, тоосжилтын түвшинг бууруулах, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, орчны агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгахад чиглэсэн арга хэмжээг тогтмол хэрэгжүүлж ажилласан.



Зураг 4. Тоосжилтийн эсрэг зам усалгаа

2.2 Техник хэрэгслүүдийн эвдрэл гэмтлийг хянаж, техникийн хэвийн ажлын горимыг ханган:

Хөшөөт төсөлд ашиглагдаж буй тээврийн хэрэгслүүдийн техникийн бэлэн байдлыг хангах, үйлдвэрлэгчийн гаргасан стандартын дагуу яндангаас ялгарах хийн хэм хэмжээг нормд байлгах зорилгоор компанийн мэргэжлийн засвар үйлчилгээний баг байнгын хяналт тавьж, шаардлагатай засвар, үйлчилгээний ажлыг тогтмол гүйцэтгэн ажиллаж байна.

Тогтмол хэрэгжүүлж буй үзлэг, хяналтын ажлууд:

- Өдөр бүр ажил эхлэхийн өмнөх техникийн тойрох үзлэг
- Улирал бүр тээврийн хэрэгслийн иж бүрэн үзлэг
- Авто тээврийн улсын үзлэгт төлөвлөгөөний дагуу хамруулах

2025 оны 5 дугаар сард зохион байгуулагдсан автотээврийн улсын хяналтын үзлэгт компанийн нийт 45 тээврийн хэрэгсэл хамрагдсанаас 42 хэрэгсэл тэнцсэн, 3 хэрэгсэлд шаардлагатай засвар үйлчилгээ хийгдэж байна.

Хүснэгт 8. Техникууд авто тээврийн үзлэгт хамрагдсан байдал

Компани нэр	Авто тээврийн улсын үзлэгт хамрагдсан тээврийн хэрэгслийн тоо	Тэнцсэн тээврийн хэрэгслийн тоо	Тэнцээгүй тээврийн хэрэгслийн тоо	Яндангаас ялгарах утаа их байсан тээврийн хэрэгслийн тоо
МоЭнКо ХХК	45	42	3	0
Алтайн зам ХК	101	101	0	0
Мезом ХХК	106	106	0	0



Зураг 5. Авто тээврийн үзлэг явагдах үеийн зураг

2.3 Хүйсийн говь, Цэцэг нуурын сав газрын захиргаатай ус ашиглах гэрээ байгуулж, ус ашигласны төлбөр төлөх:

Хөшөөтийн уурхайн усан хангамжийг бүрдүүлэх зорилгоор 2008 онд “Гоби Эксплорэйшн” ХХК, 2011 онд Эй Ай Ди Ди ХХК-иуд Хөшөөтийн голын хөндийд өрөмдлөгийн ажил гүйцэтгэж, нийт 3 ашиглалтын худаг 2012 оноос ашиглагдаж эхэлсэн. Мөн 2019 онд өрөмдсөн WDH-02, WDH-03 цоонгуудыг шүүрлийн ус шавхах, WELL-1, WELL-2 худгуудыг уурхайн нийт хэрэгцээнд ашиглаж байна.

Усны тухай хуулийн дагуу шаардлагатай баримт бичгүүд бүрдүүлэгдсэн, үүнд:

- Усны газрын 2025.08.28-ны №Е-2508-000021 тоот *Ус ашиглах дүгнэлт*,
- Хүйсийн говь–Цэцэг нуурын сав газрын захиргааны 2025.08.29-ний А/13 тоот *Ус ашиглах зөвшөөрөл*,
- Сав газрын захиргаа болон МоЭнКо ХХК-ийн хооронд байгуулсан 2025.08.29-ний №02/2025 тоот *Ус ашиглах гэрээ*,
- Ховд аймгийн БОГ-ын 2024.09.12-ны 2024/01 тоот *Ус ашиглах эрхийн бичиг* (2026.09.18 хүртэл 1 жилээр сунгасан).

Ус ашиглалтын төлбөрийг 2025.08.29-ний Ус ашиглах гэрээний дагуу худгийн тоолуурын заалтаар сар бүр тооцож, Ховд аймгийн төрийн сангийн дансанд төлж байна. Хөшөөтийн уурхайн 2025 оны гүний усны хэрэглээ сар бүрийн ус ашиглалтын тайланд тусгагдсан бөгөөд дэлгэрэнгүй мэдээллийг доорх графикаас харна уу.

График 1. Хөшөөтийн уурхайн 2025 онд ашигласан гүний усны хэмжээ Well-2 худаг /2025.01.01-2025.10.31 -ийн байдал/



График 2. Хөшөөтийн уурхайн 2025 онд ашигласан гүний усны хэмжээ Well-1 худаг /2025.01.01-2025.10.31 -ийн байдал/





График 3. Хөшөөтийн уурхайн 2025 онд шүүрлийн усыг шавхан зайлуулсан хэмжээ




Усны горимын ажиглалт

МоЭнКо ХХК нь жил бүр Газрын доорх ус болон гадаргын усанд мониторингийн судалгааны ажлыг хийж гүйцэтгэж байна.

Мониторингийн ажиглалтыг доорх 4 төрлөөр явуулдаг.

Үүнд:

1. Газар доорх усны түвшний мониторинг
2. Гадаргын усны урсгалын мониторинг
3. Гадаргын усны ундаргын мониторинг
4. Газар доорх болон гадаргын усны чанарын мониторинг



Зураг 6. Мониторингийн цэгүүдийн байршил

Газар доорхи усны түвшний мониторинг

Ашиглалтын худаг болох Well2 дугаартай цоонгогт 2018 онд мөн 2023 оноос WDH02 болон WDH03 цоонгуудад, 2024 онд Well1 дугаартай худагт Solinst Level logger-Edge 3001 маркийн автомат түвшин хэмжигчийг тус тус суурилуулсан бөгөөд тухайн 4-н ширхэг түвшин хэмжигч нь 30 минутын давтамжаар тохируулж цоонгийн түвшин ба температурын хэмжилтийг хийж өөр дээрээ хадгалдаг. Жилийн 4 улиралд тасралтгүй хэмжилтийг гүйцэтгэдэг, тухайн түвшин хэмжигчийн хэмжилтийг улиралд 1 удаа авдаг.



Зураг 7. Автомат түвшин хэмжигч

График 4. 2025 оны Well-1 худгийн усны түвшиний хэмжээ




График 5. 2025 оны Well-2 худгийн усны түвшиний хэмжээ



График 6. 2025 оны BHD-3 цоонгийн усны түвшиний хэмжээ



График 6. 2025 оны Well-1 худгийн усны түвшиний хэмжээ





График 7. 2025 оны WDH02 худгийн усны түвшиний хэмжээ




График 8. 2025 оны WDH03 худгийн усны түвшиний хэмжээ



Гадаргын усны урсгалын мониторинг

Гадаргын усны хяналт шинжилгээг Хөшөөтийн голын дагуу 3 цэгт, мөн тахилтын булгийн нийлбэр урсац дээр 3 хоногт нэг удаа хэмжилтийг хийдэг. Гадаргын усны мониторинг хэмжилт (Урсац м³/с, Хурд м/с, Түвшин / м, Өргөн / м)

График 9. Тахилтын булгийн ундрагын хэмжээ



Усны чанарын мониторинг

Хөшөөтийн уурхай, Булган, Үенчийн гаалийн хяналтын талбай орчимоос Гол, Булаг, Худаг Шүүрэл гэх мэт 12 цэгээс улирал бүр дээжлэлтийн ажил хийгддэг. Энэ нь Хөшөөтийн уурхайн олборлолтын явцад гадаргын болон газар доорхи усны өөрчлөлт сөрөг нөлөөлөлийг хянах зорилгоор усны чанарын мониторингийн тогтмол явуулсаар ирсэн.

Хүснэгт 9. Тухайн жилд хийгдэх усны хиймийн шинжилгээний төрөл, тоо ширхэг

№	Шинжилгээний нэр төрөл	1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар	6 сар	7 сар	8 сар	9 сар	10 сар	11 сар	12 сар
1	Хүнд металл		√			√			√			√	
2	Цэвэр усны ерөнхий хими	√	√	√	√	√	√	√	√	√	√	√	√
3	Бохир усны хими		√			√			√			√	
4	Цацрагийн шинжилгээ		√			√			√			√	



Зураг 8. Well-2 худаг, суурилуулсан усны тоолуур



Зураг 9. WDH-03 шавхалтын худаг, суурилуулсан усны тоолуур

Хөшөөтийн голын хөндийн цооног, булгийн усны химийн шинжилгээг 2012 оноос эхлэн улирал бүр ХАНЛАБ болон ГеоАналитик, Усны газрын төв лабораторид тогтмол хийж байна. Шинжилгээний бүх үзүүлэлтүүд MNS 900:2018 стандартын шаардлага хангаж, унданд тохиромжтой, гидрокарбонат-кальцийн найрлагатай, цэнгэг, зөөлөвтөр ус гэж дүгнэлт гарсан.

2025 онд усны дээжийг дээрх гурван лабораторид өгч, үр дүнг тайланд хавсаргасан. Ус ашиглалтыг хянах зорилгоор Well-2 худгийн гадна, дотор талд 2021 онд Hikvision камер, Well-1 худагт 2024 онд МНК иж бүрэн камер суурилуулсан. Ингэснээр усыг зөв зориулалтаар ашиглаж буй эсэхийг хянах, журналтай тулган баталгаажуулах боломж бүрдүүлэн ажиллаж байн. Мөн Хүйсийн Говь-Цэцэг нуурын сав газрын захиргаатай байгуулсан ус ашиглалтын гэрээний дагуу камерын хяналтыг хэрэгжүүлж байна.



Зураг 10. Худагт суурилуулсан ус ашиглалтын хяналтын камер



Зураг 11. Ус зөвөрлөх машиныг зориулалтаар нь ялгасан байдал

Ашигласан усны хэмжээ

БОМТ-ний тайлант хугацаанд 2025 оны 10 сарын 30-ны өдрийн байдлаар үйлдвэрлэлийн усны нийт хэрэглээ 95,236.0 м³, хамгийн хуурайшилттай үе болох 4-10 дугаар саруудад замын усалгааг идэвхтэй хийсэн бөгөөд энэ хугацаанд өдөрт дунджаар 270 м³ ус хэрэглэсэн байна.

Унд-ахуйн усны жилийн хэрэглээг ажиллах хүчний тоотой харьцуулан тооцоход 2025 онд нэг ажилтан хоногт дунджаар 326 литр ус хэрэглэсэн тооцоо гарсан.

Хүснэгт 10. Унд-ахуйн ус ашиглалт (Нэг хүний хоногийн хэрэглээг 2025 оны 10 сарын 30 өдрийн байдлаар тооцсон байдал)

Огноо	2025 он									
	1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар	6 сар	7 сар	8 сар	9 сар	10 сар
Нийт хүний тоо	243	157	189	206	201	187	38	159	210	213
Сарын хэрэглээ, м3/сар	1,893	1,752	1,744	1,744	1,805	1,817	1,353	668	1,790	1,778

Хоногийн хэрэглээ, м3/хоног	61	60	56	62	58	61	44	22	60	57
Нэг хүний хэрэглээ, л/хоног*хүн	251	385	298	302	290	324	1,149	136	284	269

Хүснэгт 11. Хөшөөтийн уурхайн 2025 оны жилийн ашигласан усны хэмжээ, 10 дугаар сарын 31 -ны байдлаар

№	Огноо	Унд, ахуйн усны хэрэглээ, м3		МоЭнКо ХХК-ийн үйлдвэрлэлийн усны нийт хэрэглээ, м3				Алтайн зам компанийн үйлдвэрлэлийн ус, м3	Мезом компанийн үйлдвэрлэлийн ус, м3	Унд, ахуйн усны хоногийн дундаж хэрэглээ, м3	Үйлдвэрлэлийн усны хоногийн дундаж хэрэглээ, м3	Сарын ундны усны нийт хэрэглээ, м3	Сарын үйлдвэрлэлийн усны нийт хэрэглээ, м3	Сарын нийт хэрэглээ, м3	Ундны усны тоолуурын сүүлийн заалт	Үйлдвэрлэлийн усны тоолуурын сүүлийн заалт	Ашиглаж буй цооногийн дугаар
		МоЭнКо	Алтайн зам	Зам талбайн тоосжилт, бусад	Онцгой байдал, гал	Ногоон байгууламж	Эрэл хайгуул өрөмдлөг										
1	2025.1.31	1,893	-	1,453	-	-	-	937	-	61	77	1,893	2,390	4,283	29,838	209,277	Well-2
2	2025.2.28	1,752	-	378	1	-	-	277	-	60	23	1,752	656	2,408	31,590	209,933	Well-2
3	2025.3.31	1,744	-	1,409	5	-	-	-	-	56	46	1,744	1,414	3,158	33,322	211,341	Well-2
4	2025.4.30	1,865	-	3,711	77	-	-	-	1,028	62	155	1,865	4,816	6,681	35,206	216,157	Well-2
5	2025.5.31	1,805	-	3,897	70	-	-	3,674	60	58	248	1,805	7,701	9,506	37,008	223,843	Well-2
6	2025.6.30	1,817	-	5,079	20	-	78	3,112	68	61	270	1,817	8,357	10,174	37,361/10,813	225,523/6319	Well-2
7	2025.7.31	1,353	-	1,921	20	-	-	3,641	51	44	182	1,353	5,633	6,986	12,166	11,952	Well-2
8	2025.8.31	668	-	1,227	5	-	-	942	223	22	77	668	2,397	3,065	12,834	14,349	Well-2
9	2025.09.30	1,790	184	4,377	103	-	-	4,794	215	60	306	1,974	9,489	11,463	14,808	23,838	Well-2
10	2025.10.31	1,778	1,019	2,228	26	-	33	2,525	-	57	155	2,797	4,812	7,609	17,605	28,650	Well-2
11	2025.11.30	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	Well-2
12	2025.12.31	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	Well-2
	Нийт хэрэглээ	16,465	1,203	25,680	327	-	111	19,902	1,645			17,668	47,665	65,333			

Хүснэгт 12. Хөшөөтийн уурхайн 2025 оны жилийн ашигласан усны хэмжээ Well-1 худаг, 2025.01.01-2025.10.31 -ийн байдлаар

№	Огноо	Үйлдвэрлэлийн усны нийт хэрэглээ		Алтайн зам компанийн үйлдвэрлэлийн ус	Мезом компанийн үйлдвэрлэлийн ус	Үйлдвэрлэлийн усны хоногийн дундаж хэрэглээ, м3	Сарын үйлдвэрлэлийн усны нийт хэрэглээ, м3	Ашиглаж буй цооногийн дугаар
		Зам талбайн тоосжилт, бусад	Эрэл хайгуул оромдлог					
1	2025.2.28	14				0	14	Well-1
2	2025.4.30	1,286			2,378	118	3,664	Well-1
3	2025.5.31	2,051		989	4,745	251	7,786	Well-1
4	2025.6.30	1,974		3,524	4,724	330	10,223	Well-1
5	2025.7.31	519		2,381	3,768	215	6,667	Well-1
6	2025.8.31	73		167	222	15	462	Well-1
7	2025.09.30	1,162		4,535	4,486	328	10,183	Well-1
8	2025.10.31	631		2,884	1,797	171	5,312	Well-1
11	Нийт хэрэглээ	7,709	-	14,481	22,120	119	44,310	Well-1

Хөшөөтийн уурхайн 2025 оны жилийн ашигласан шүүрлийн усны хэмжээ, 09 дүгээр сарын 30-ны байдлаар

№	Огноо	МоЭнКо ХХК-ийн шүүрлийн усны хэрэглээ, м3	Мезом компанийн шүүрлийн усны хэрэглээ, м3	Алтайн зам компанийн шүүрлийн усны хэрэглээ, м3	Сарын нийт хэрэглээ, м3	МоЭнКо ХХК-ийн шүүрлийн усны хоногийн дундаж хэрэглээ, м3/хоног	Мезом компанийн шүүрлийн усны хоногийн дундаж хэрэглээ, м3/хоног	Алтайн зам компанийн шүүрлийн усны хоногийн дундаж хэрэглээ, м3/хоног	Ус авч буй PIT
1	2025.09.30	-	1,197		1,197	-	40	-	Phase, RL1952
2	2025.10.31	-	5,330		5,330	-	172	-	Phase, RL1952
3	Нийт хэрэглээ	-	6,527		6,527	-	-	-	

2025 оны 10 сарын 31-ний байдлаар Хөшөөтийн уурхай унд-ахуйн хэрэгцээнд 17,688 м³ ус ашиглаж, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн дагуу 1,558,318 төгрөг төлсөн.

Үйлдвэрлэлийн зориулалтаар 91,975.11 м³ гүний ус хэрэглэж 17,341,228 төгрөг, мөн 6,527 м³ шүүрлийн усыг шавхан зайлуулж зам талбайн тоосжилт, ногоон байгууламжийн усалгаа, галын аюулын сургалт, өрөмдлөгийн ажилд ашигласны төлбөрт 4,144,906.08 төгрөг төлсөн.

Ингэснээр МоЭнКо ХХК нь 2025 онд ус ашиглалттай холбоотой нийт 23,946,736 төгрөгийн төлбөрийг холбогдох журмын дагуу төлсөн байна.

2.4 Үржил шимт хөрсийг стандартын дагуу (шинээр хөрс хуулах бүрт) хуулж, хадгалах үйл ажиллагаанд хяналт тавих:

Шинээр баригдаж байгаа хуурай баяжуулах үйлдвэрийн чиглэлийн авто замын ажил эхлэх үед газар хөндөх, шимт хөрсийг хуулах ажлын зөвлөмж өгч ажилласан. 2025 оны уулын ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 2025 оны 10 сарын 30-ний өдрийн байдлаар уурхайн отвалын үйл ажиллагааны зориулалттай ашиглах 5.62 га талбайгаас 1505 м³ шимт хөрсийг шинээр хуулж хадгалсан. Уурхайн үйл ажиллагаа эхлэснээс хойш нийт 196,606 м³ шимт хөрсийг MNS 5916:2008 стандартын дагуу хадгалж байна.



Зураг 12. Шинэ баяжуулах үйлдвэрийн тээвэрлэлт хийх зориулалттай замын шимт хөрс хуулалт хийж байгаа байдал

2.5 Асгаралттай холбоотой үүссэн бохирдсон хөрсийг хуулж авах, саармагжуулах:

Манай компанийн засварын газар болон оффисийн барилга байгууламжийг шинэ суурьшлын бүсрүү шилжүүлэхтэй холбогдуулан тухайн шинэ суурьшлын бүсийн төлөвлөлт зохион байгуулалтын дагуу Аюултай хог хаягдлыг түр хадгалах цэгийг байгуулж таних тэмдэг тэмдэглэгээ байрлуулах ажлыг төлөвлөж шат дараатайгаар хэрэгжүүлж байна. Асгаралтаас үүдэлтэй бохирдсон хөрсийг EM-1 бодисоор саармагжуулах арга хэмжээгч авч хэрэгжүүлэн ажиллаж байна.



Зураг 13. Хөрс саармагжуулж туршилтын ажил

2.6 Хуурай баяжуулах үйлдвэр болон гаалийн хяналтын ачиж буулгах талбайд үүсэх тоосжилтыг бууруулах:

Хуурай баяжуулах үйлдвэрийн тэжээлийн талбайд үүсэх тоосжилт бий болохоос сэргийлж, Гаалийн хяналтын талбайн ачиж буулгах үйл ажиллагаанаас үүсэх нүүрсний нарийн ширхэгт тоосонцрын дэгдэлтийг бууруулах зорилгоор мананжуулагч машинаар усалгаа хийж байна.

Нүүрс баяжуулах үйлдвэрийн талбайд нүүрс буулгах, нүүрсийг шигших, бутлах, агаарын үлээлэгтэй ширээгээр баяжуулах, баяжуулсан нүүрсийг ачих, хаягдалыг ачих үйл ажиллагаануудаас тоосжилт үүсдэг. Үүсэх тоосны хэмжээг бага байлгах сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор мананжуулах усалгааг 4 мананжуулагч машинаар өдөр, шөнийн ээлжээр 24 цагийн турш хийж байна.



Зураг 14. Мананжуулагч машинаар уурхайн үйл ажиллагаанаас гарч буй тоосыг бууруулах зорилгоор өдөр бүр усалгаа хийж байгаа нь

БҮЛЭГ 3. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Нөхөн сэргээлтийн зориулалт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Нийт зардал мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Биелэлтийн шалгуур	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Техникийн нөхөн сэргээлт	Одоогоор нөхөн сэргээлт хийх талбай байхгүй.	Үйл ажиллагааны зардлаас	Тухай бүр	Одоогоор биологийн нөхөн сэргээлт хийх талбай байхгүй. Дэлгэрэнгүй мэдээллийг харна уу.	Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт стандарт MNS_5915_2008 MNS_5917_2008 MNS_5918_2008
2	Биологийн нөхөн сэргээлт	Шимт хөрсний шинэ овоолгийн үржил шимийг алдагдуулахгүй хадгалалтыг уртасгахын тулд олон наст ургамлын үрээр тариалалт хийх	-	Жил бүр	- Шимт хөрсний шинэ овоолгын үржил шимийг алдагдуулахгүй, чанарыг урт хугацаанд хадгалах зорилгоор олон наст ургамлын үрээр тариалалт хийж байна. 2025 оны 10 дугаар сарын байдлаар нийт 5,62 га талбайгаас 1,505 м³ шимт хөрс хуулсан бөгөөд уурхайн үйл ажиллагаа эхэлснээс хойш нийт 196,606.7 м³ шимт хөрснийг холбогдох стандартын дагуу хуулж, үржил шимийг тогтвортой хадгалах зорилгоор Ботууль, Ерхөг, Өлөнгө, Дааган сүүл зэрэг олон наст ургамлыг тарьж ургуулах ажлыг зохион байгуулан, усалгаа арчилгааг тогтмол хэрэгжүүлж байна. Дэлгэрэнгүй мэдээллийг харна уу.	Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт MNS_5916_2008
3	Шимт хөрсний овоолгыг хучих	Шимт хөрсний шржил шимийг алдагдуулахгүй байх, тарьсан олон настын үрийг шувуу идэх, салхинд хийсэхээс хамгаалах	-	Жил бүр	- Шимт хөрсний үржил шимийг хамгаалж, тарьсан олон наст ургамлын үрийг шувуу, салхи зэрэг сөрөг нөлөөллөөс хамгаалахын тулд үрийг зохих гүнд суулгаж, шимт хөрсөөр хучсаж, тогтмол усалгаа арчилгааг тогтмол хийж хэрэгжүүлсэн. Дэлгэрэнгүй мэдээллийг харна уу.	
4	Орчны ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх	Уурхайн орчмын ногоон байгууламжыг нэмэгдүүлэх, нөхөн тариалалт хийх	-	Тухайн жилд	2025 оны хавар, намрын мод тариалалтаар Хүндлэл кемпийн эргэн тойрон болон засварын газрууд орчимд тарьсан моднуудад нөхөн тариалалт хийж ажилласан. Дэлгэрэнгүй мэдээллийг харна уу.	MNS 6774:2019 Том мод, суулгацыг шилжүүлэн суулгах, арчлах. Техникийн шаардлага
Нийт зардал, мян.төг						

НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

3.1 Техникийн нөхөн сэргээлт:

Одоогоор уурхайн ашиглалт явагдаж буй талбайд техникийн нөхөн сэргээлт хийх шаардлагатай газар байхгүй байна. Иймд нөлөөллийн бүсийн сумдын нутагт дүйцүүлэн хамгаалах чиглэлээр аймгийн Байгаль орчны газраас ирүүлсэн талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хэрэгжүүлж ажилласан..

3.2 Биологийн нөхөн сэргээлт:

Шимт хөрсний шинэ овоолгын үржил шимийг алдагдуулахгүй, чанарыг урт хугацаанд хадгалах зорилгоор олон наст ургамлын үрээр тариалалт хийж байна. 2025 оны 10 дугаар сарын байдлаар нийт 5.62 га талбайгаас 1,505 м³ шимт хөрс хуулсан бөгөөд уурхайн үйл ажиллагаа эхэлснээс хойш нийт 196,606.7 м³ шимт хөрсийг холбогдох стандартын дагуу хадгалж байна. Мөн шимт хөрсний үржил шимийг тогтвортой хадгалах зорилгоор Ботууль, Ерхөг, Өлөнгө, Дааган сүүл зэрэг олон наст ургамлыг тарьж ургуулах ажлыг зохион байгуулан, усалгаа арчилгааг тогтмол хэрэгжүүлж байна.

3.3 Шимт хөрсний үржил шимийг алдагдуулахгүй байх, тарьсан олон настын үрийг шувуу идэх, салхинд хийсэхээс хамгаалах:

Шимт хөрсний үржил шимийг хамгаалж, тарьсан олон наст ургамлын үрийг шувуу, салхи зэрэг сөрөг нөлөөллөөс хамгаалахын тулд үрийг зохих гүнд суулгаж, шимт хөрсөөр хучсаж, тогтмол усалгаа арчилгааг тогтмол хийж хэрэгжүүлсэн.

3.4 Уурхайн орчмын ногоон байгууламжыг нэмэгдүүлэх, нөхөн тариалалт хийх:

Засварын газар, Хүндлэл кемпийн эргэн тойронд тарьсан 1,000 ширхэг модны усалгаа, арчилгааг тогтмол хийж 2025 оны намрын мод тариалтаар нөхөн тариалалт хийж модны ургалт, амьдрах орчны нөхцлийг сайжруулж байна. Мөн ажилчдын амрах байр орчимд олон наст зүлэг, цэцгийн үрийг тарьж, усалгаа, арчилгааг тогтмол хэрэгжүүлснээр талбайн ногоон бүрхэвчийг нэмэгдүүлж, хөрсний элэгдэл, тоосжилтыг бууруулахад хувь нэмэр оруулж байна. Энэхүү арга хэмжээ нь ажилчдын амрах орчинд ая тухтай, эко орчин бүрдүүлэх, мөн байгаль орчныг хамгаалах чиглэлээрх хэрэгжүүлж буй компанийн арга хэмжээний нэг хэсэг юм.





Зураг 15. Шимт хөрсний талбайд болон модны тариалалт усалгаа хийж байгаа нь

БҮЛЭГ 4. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭХ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Биелэлтийн шалгуур	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлт	Аймгийн Байгаль орчны газраас зааж өгсөн газарт техникийн нөхөн сэргээлт хийх /13.5 га/	Ховд аймгийн Манхан, Мөст сумдын нутагт 19.38 га	38,736,250	Нэг удаа	Аймгийн Байгаль орчны газрын 2024.12.30-ны өдрийн 411 тоот албан бичгийн дагуу МоЭнКо ХХК нь 2025 оны БОМТ-нд Мөст сумын Цэцэг гол багийн “Цагаан хөтөл” (4.38 га) болон Манхан сумын “Зах булгийн ар” (10 га) талбайд техникийн нөхөн сэргээлт хийх ажлыг тусган, БОУАӨЯ-аар батлуулсан. Нөхөн сэргээлтийн өмнө эвдэрсэн газрын хэмжилт, зураглал, техникийн тооцооллыг хийж, 2025.09.04-12-нд “Цагаан хөтөл”-ийн 4.38 га, 2025.09.12-25-нд “Зах булгийн ар”-ын 15 га талбайд нийт 21 хоногийн хугацаанд нөхөн сэргээлт хийж, сумдын удирдлага болон байгаль орчны ажлын хэсэгт хүлээлгэн өгсөн. Ажлын гүйцэтгэлд ковш-1, дозер-1, трайлер-1, экскаватор-1, суудлын автомашин-1 зэрэг нийт 5 техник ашиглагдсан. Дэлгэрэнгүй мэдээллийг харна уу.	Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт стандарт MNS_5914_2008
2	Дүйцүүлэн хамгаалах нэмэлт ажил	Нөлөөллийн бүсийн сумдад булгийн эх хашиж хамгаалах	Ховд аймгийн Дарви, Цэцэг, Булган, Үенч сумд	47,100,578	Нэг удаа	2025 оны БОМТ-д нөлөөллийн бүсийн дөрвөн суманд тус бүр нэг булгийн эхийг хашиж хамгаалан орон нутгийн захиргаанд хүлээлгэн өгөхөөр төлөвлөсөн. Уг төлөвлөгөөний хүрээнд Дарви сумын Дэлгэр багийн нутаг дахь “108 рашааны” эх, Булган сумын Баянгол багийн нутаг дахь “Цагаан овооны” булгийн эх, Үенч сумын “Хөх үзүүрийн” булгийн эх, Цэцэг сумын Хажинга багийн нутаг дахь “Усны эхийн” булгийн эхийг тус бүр хашиж хамгаалах ажлыг гүйцэтгэн, холбогдох сумдын албан тушаалтнуудад хүлээлгэн өгсөн. Булгийн эхийг хашиж хамгаалахад нийт 650 метр сүлжмэл төмөр тор, 840 ширхэг 3 метрийн урт төмөр шон ашигласан. Дэлгэрэнгүй мэдээллийг харна уу.	Сумдаас ирүүлсэн санал
3		Дарви сумын Мөрөн багийн нутаг Хойд голын тариалангийн 100 га талбайг хашиж хамгаалах	Дарви сум Мөрөн баг	72,149,112	Нэг удаа	Дарви сумын Мөрөн багийн нутагт байрлах Хойд голын тариалангийн талбайн 100 га газрыг 2025 оны 10 дугаар сарын 20-наас 11 дүгээр сарын 14-ний хооронд хамгаалалтын тор татаж хамгаалан, сумын орон нутгийн захиргаанд хүлээлгэн өглөө. Уг ажлын хүрээнд нийт 3000 метр сүлжмэл төмөр тор, 1110 ширхэг 2 метрийн өндөртэй төмөр шон, 10,000 метр пансаа төмөр утас, 8 тонн цемент, 3000 метр өргөст төмөр утас ашиглан хамгаалалтын ажил гүйцэтгэсэн. Дэлгэрэнгүй мэдээллийг харна уу.	Дарви сумаас ирүүлсэн санал

4	Дүйцүүлэн хамгаалах урт хугацааны төлөвлөгөө	Сутай хайрхан УТХГ-ын мөстлөг, цасны судалгаагаар авиралт хийх	Сутай хайрхан уул	818,181.82	Тогтмол	Уурхайн үйл ажиллагаанаас үүсэж буй тоосжилт нь Сутай хайрхан уулын мөстлөгийн хайлалтын эрчимд нөлөөлж буй эсэхийг тодорхойлох зорилгоор 2023 оноос хойш Хүрээлэн буй орчин, Цаг уур, Усны шинжилгээний газар (ХГЦНСГЗ)-тай хамтран мониторингийн судалгааг тогтмол хэрэгжүүлж байна. Энэхүү судалгааны хүрээнд мөнх цасны хил орчимд нарийн ширхэгт тоосонцор очиж байгаа эсэхийг тодорхойлох зорилгоор Dusttruck багажаар PM2.5 болон PM10 үзүүлэлтээр тоосонцрын хэмжилт хийдэг. Мөн цасны хил ухарч байгаа эсэхийг баримтжуулан, өмнөх хугацааны мэдээлэлтэй харьцуулалт хийж дүгнэлт гаргадаг. 2025 оны ээлжит мониторингийн судалгааг 2025 оны 9 дүгээр сарын 24-26-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулан хэрэгжүүллээ. Дэлгэрэнгүй мэдээллийг харна уу.	Сумдаас ирүүлсэн санал
5	Тэрбум мод	Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд ойжуулалтын ажлыг хэрэгжүүлэх	Шинэ Хархорум хот төсөл	Зардлыг БОМТ-ний зардалд оруулахгүй. Төслийн тусгай санхүүжилт	Намрын мод тариалалтаар	“Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газраас 2025 оны 1 дүгээр сарын 3-ны өдрийн ТГ/02 тоот албан чиглэлээр өгсөн үүргийн дагуу Өвөрхангай аймгийн Хархорин хотын нутагт 10,000 ширхэг мод тарих ажлыг хэрэгжүүлж байна. Уг ажлын хүрээнд намрын мод тарилтаар 10,000 ширхэг модыг ургуулан хүлээлгэн өгөх “Их сумт хайрхан” ХХК -ийг сонгон шалгаруулж, 3 жилийн хугацаатай хамтран ажиллах гэрээ байгуулсан бөгөөд мод тарих ажлыг албан ёсоор эхлүүлээд байна. Дэлгэрэнгүй мэдээллийг харна уу.	Тэрбум мод үндэсний хөдөлгөөн
Нийт зардал, мян.төг				158,804,122			

4.1 Дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлт:

Ховд аймгийн Байгаль орчны газрын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 411 тоот албан бичгийн дагуу МоЭнКо ХХК нь 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөндөө Мөст сумын Цагаан хөтөл (4.38 га) болон Манхан сумын Зах булгийн ар (15 га) талбайд техникийн нөхөн сэргээлт хийх ажлыг тусган хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Дээрх ажлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөний хүрээнд боловсруулж, БОУАӨЯ-аар батлуулан хэрэгжилтийг зохион байгуулсан.

2025 онд нөхөн сэргээлтийн ажлыг дараах хугацаанд гүйцэтгэв:

- Мөст сумын Цагаан хөтөл – 4.38 га
2025.09.04–2025.09.12-ний хооронд хийж гүйцэтгэсэн.
- Манхан сумын Зах булгийн ар – 15 га
2025.09.12–2025.09.25-ний хооронд хийж гүйцэтгэсэн.

Ингэснээр нийт 21 хоногийн хугацаанд 19.38 га талбайн техникийн нөхөн сэргээлтийг бүрэн гүйцэтгэж, ажлыг сумдын удирдлага болон байгаль орчны ажлын хэсэгт үзүүлж хүлээлгэн өгсөн болно.



Манхан суманд хийгдэх нөхөн сэргээлтийн талбай талбайн зураг




Зураг 16. Мөст суманд хийгдэх нөхөн сэргээлтийн талбайн зураг

4.2 Булгийн эх хашиж хамгаалах:

2025 онд БОМТ-д нөлөөллийн бүсийн дөрвөн суманд, Дарви сумын Дэлгэр багийн “108 рашаан”, Булган сумын Баянгол багийн “Цагаан овоо”, Үенч сумын “Хөх үзүүр” болон Цэцэг сумын Хажинга багийн “Усны эх” булгийн эхийг хашиж хамгаалах төлөвлөгөөний хүрээнд гүйцэтгэж, холбогдох сумдын албан тушаалтнуудад хүлээлгэн өгсөн.

Тодруулбал: Дарви сумын Дэлгэр багийн нутаг дахь 108 рашааны эхийг 2025.08.30-9.6 ны өдрүүдэд нийт 7 хоногийн хугацаанд 300м урт тороор 3м ын хэмжээтэй рам зангидаж, холбож гагнан шонг газарт суулгахгүйгээр тулгуур хийж, тойруулан торлож хамгаалан сум орон нутагт нь акт үйлдэж хүлээлгэн өгсөн.



Зураг 17. Булгийн эхийн хамгаалалтын талбайд дрон зураг авалт, газар хэмжилт хийж, хашилтын төлөвлөлтийн зураглал боловсруулав

Булган сумын Баянгол багийн нутаг Цагаан овооны булгийн эхийг байгальд ээлтэй аргаар буюу шон төмрийг мөн газарт суулгахгүйгээр тулгуур хөл хийж хашиж хамгаалах ажлыг 2025.11.25-11.27 өдрүүдэд хийж гүйцэтгэсэн.



Зураг 18. Булган сумын булгийн эхийг хашиж хамгаалах ажлын байршил

Үенч сумын Хөх үзүүр багийн Хөх үзүүрийн булгийн эхийг хашиж хамгаалах ажлыг 2025.11.22-11.25 өдрүүдэд хийж гүйцэтгэсэн.



Зураг 19. Үенч сумын Хөх үзүүрийн булгийн эх

Цэцэг сумын Хажинга багийн нутаг Давааны ус булгийн эхийг хашиж хамгаалах ажлыг 2025.11.18-11.21 өдрүүдэд хийж гүйцэтгэсэн.



Зураг 20. Цэцэг сумын Хажинга багийн нутаг Давааны ус булгийн эх

Хүснэгт 13. Булгийн эх хаших газрын байршил болон талбайн хэмжээ

№	Сумын нэр	Багийн нэр	Булгийн нэр	Координат	Хаших талбайн хэмжээ
1	Дарви	Дэлгэр	108 рашаан	46°47'49.89"N, 93°37'34.98"E	500 м
2	Үенч	Хөх үзүүр	Хөх үзүүрийн булаг	46°13'30.31"N, 91°52'36.35"E	100 м
3	Цэцэг	Хажинга баг	Давааны усны булаг	46°45'9.42"N, 91°17'58.26"E	70 м
4	Булган	Баянгол	Цагаан овоо	46°24'13.97"N, 91°12'20.17"E	100 м
Нийт хаших талбай					770 м

4.3 Дарви сумын Мөрөн багийн нутаг Хойд голын тариалангийн 100 га талбайг хашиж хамгаалах:

Дарви сумын Мөрөн багийн нутагт байрлах Хойд голын тариалангийн талбайн 100 га газарт тор татаж хамгаалах ажлыг 2025 оны 10 дугаар сарын 25-наас 11 дүгээр сарын 26-ны хооронд зохион байгуулсан. Тус ажлын хүрээнд тариалангийн талбайг гадны нөлөөллөөс хамгаалах зорилгоор хамгаалалтын торыг татаж, бэхэлгээний ажил бүрэн хийгдсэн. Орон нутгийн төрийн захиргааны холбогдох албан тушаалтнуудад акт үйлдэж хүлээлгэн өгсөн.

Энэхүү ажил нь тариалангийн талбайн хөрс, ургамал бүрхэвчийг хамгаалах, мал болон бусад гадны нөлөөнөөс урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлсэн.




Зураг 21. Дарви сум хойд гол 100 га талбайн торлох ажлын зураг

4.4 Сутай хайрхан УТХГ-ын мөстлөг, цасны судалгаагаар авиралт хийх:

Уурхайн үйл ажиллагаанаас үүсэх тоосжилт нь Сутай хайрхан уулын мөстлөгийн хайлалтын эрчимд нөлөөлж буй эсэхийг тодорхойлох зорилгоор 2023 оноос эхлэн Хүйсийн говь Цэцэг нуурын сав газрын захиргаатай (ХГЦНСГЗ) хамтран мониторингийн судалгааг тогтмол хэрэгжүүлж байна. Судалгааны хүрээнд мөнх цасны хил орчимд нарийн ширхэгт тоосонцор очиж буй эсэхийг тогтоох зорилгоор Dusttruck багажаар PM2.5 болон PM10 тоосонцрын хэмжилт хийж, үр дүнг бүртгэн авч байна.

Мөн мөнх цасны хил ухралтын байдлыг газар дээр нь баримтжуулж, өмнөх хугацааны мэдээлэлтэй харьцуулан өөрчлөлтийн дүн шинжилгээ хийдэг.

2025 оны ээлжит мониторингийн судалгааг 2025 оны 9 дүгээр сарын 24-26-ны өдрүүдэд зохион байгуулж, төлөвлөгөөний дагуу амжилттай гүйцэтгэн, шаардлагатай мэдээлэл, хэмжилтийн багц мэдээллийг бүрэн цуглууллаа.



Зураг 22. Сутай хайрхан УТХГ-ын мөстлөг, цасны судалгаагаар авиралт

4.5 Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд ойжуулалтын ажлыг хэрэгжүүлэх:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын 2025 оны 1 дүгээр сарын 3-ны өдрийн ТГ/02 тоот албан чиглэлээр өгсөн үүргийн дагуу “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд Өвөрхангай аймгийн Хархорин хотын нутагт 10,000 ширхэг мод тарих ажлыг зохион байгуулсан.

Намрын улирлын мод тарилтаар 10,000 ширхэг модыг тариалж ургалт, арчлалт хамгаалалтыг бүрэн хариуцахаар “Их сумт хайрхан” ХХК-тай 3 жилийн хугацаатай хамтран ажиллах гэрээ хийж ажилласан.



Зураг 23. Өвөрхангай аймгийн Хархорин хотын нутагт 10,000 ширхэг мод тарих ажил

БҮЛЭГ 5. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Нөлөөлөлд өртөх иргэд	Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Нийт зардал мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Биелэлтийн шалгуур	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Малчин өрх	Нүүлгэн шилжүүлэлтийн 2-р ээлжийн ажил болох уурхайн нөлөөллийн бүсийн өвөлжөө хаваржааны нүүлгэн шилжүүлэлтийн ажлыг үргэлжлүүлэх	Нөлөөллийн сумдын малчин өрх	Төслийн тусгай санхүүжилт, Орон нутгийн хөгжлийн сан	1 удаа	Ховд аймагтай байгуулах ХАГ-г 2025 оны 11 сард албажиж, гэрээнд тоосжилтод өртсөн малчин өрхүүдийн судалгааг хөрш уурхайн төлөөлөл, мэргэжлийн байгууллагууд болон нөлөөллийн сумдын оролцоотой ажлын хэсгээр дахин тогтоох, үүний үндсэн дээр нүүлгэн шилжүүлэлт болон тоосжилтын нөхөн олговор олгохоор тусгасан. Манай байгууллага ажлын хэсэгт орох нэрсийг албажуулан хүргүүлсэн. Ажлын хэсэг байгуулагдаж судалгаа шинэчлэгдсэний дараа 2025 оны нэг удаагийн нөхөн олговрыг 2026 онд олгоно.	Байгаль орчин нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээ, Ховд аймаг болон МоЭнКо ХХК хоорондын хамтран ажиллах гэрээ
Нийт зардал мян.төг				0			


БҮЛЭГ 6. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Нөлөөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Нийт зардал мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Биелэлтийн шалгуур	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Түүхийн дурсгалт газрууд	Говийн их дархан цаазат газрын “Б” хэсгийн орчны бүсийн Алтай, Үенч, Булган сумдаас дархан цаазат газарт нэвтрэн ордог 5 цэг дээр иргэдийн экологийн боловсролыг дээшлүүлэх, анхааруулах самбар байршуулах	Говийн Их дархан цаазат газрын Б хэсгийн хамгаалалтын бүс нутаг	7,179,000	Нэг удаа	2025 оны БО-ны менежментийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэхээр ГИДЦГ-ын Б хэсгийн хамгаалалтын захиргаанаас ТХГН-ын гүнрүү нэвтэрч ордог Алтай, Үенч, Булган сумдын 5 байршилд, анхааруулга, мэдээллийн самбарыг хийж байршуулж өгөх хүсэлт ирүүлсэний дагуу 1.20м*1.23м харьцаатай 2 талдаа хэвлэлтэй мэдээллийн самбарыг хийж байршуулан, ТХГНХЗ-нд акт үйлдэж хүлээлгэн өгсөн. Мөн 2018-2019 онуудад Үенч суманд хүлээлгэн өгч байсан Харуул овооны танилцууллага болон тэрбум мод, хог хаягдлын цэгт байрлуулж байсан анхаарууллага самбаруудын стикер хуулгыг дахин шинэчилж самбарууд дээр байршуулж ажилласан. Дэлгэрэнгүй мэдээллийг харна уу.	БОНБУТ хууль, Соёлын өвийн тухай хууль
2	Түүхийн дурсгалт газрууд	Архелогийн судалгаагаар тогтоогдсон уурхай орчмын хиригсүүр болон булшнуудыг фото зургаар баримтжуулж бүртгэх	Уурхай орчим	Үйл ажиллагааны зардлаас	Тухай бүр	Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөөний хүрээнд 2010 онд Монгол улсын ШУА-ийн Археологийн авран хамгаалах хээрийн шинжилгээний багаар судалгаа хийлгэж Хөшөөтийн уурхай орчмын бүсэд 114 хөшөө дурсгал, хиригсүүрүүдийн бүртгэл үүсгэсэн байдаг. Жил бүр тухайн археологийн хөшөө дурсгал, хиригсүүрүүдийн бүрэн бүтэн байдлыг хянах зорилгоор фото зураг дарж баримтжуулж авдаг. 2025 оны хувьд мөн адил бүртгэгдсэн хөшөө дурсгал, хиригсүүрүүдийн бүрэн бүтэн байдлыг өмнөх оны зурагтай харьцуулан баримтжуулж ажилласан. Дэлгэрэнгүй мэдээллийг харна уу.	
Нийт зардал мян.төг				7,179,000			

6.1 Говийн их дархан цаазат газрын “Б” хэсгийн орчны бүсийн Алтай, Үенч, Булган сумдаас дархан цаазат газарт нэвтрэн ордог 5 цэг дээр иргэдийн экологийн боловсролыг дээшлүүлэх, анхааруулах самбар байршуулах:

Говийн их дархан цаазат газрын Б хэсгийн орчны бүсийн Алтай, Үенч, Булган сумдаас дархан цаазат газарт нэвтрэн ордог нийт 5 цэг дээр иргэдийн экологийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор анхааруулах самбар 5 ширхэгийг хийж байршууллаа. Мөн 2021 онд Үенч сумын иргэдийн саналын дагуу байршуулсан Харуул-овооны мэдээллийн самбар, чиглэл заасан самбар болон “Байгалиа хайрлаж хамгаалай” зэрэг танин мэдэхүй, сурталчилгааны самбаруудын мэдээллийг шинэчилж, засварлан сэргээж байршуулсан.


Энэхүү ажил нь орчны бүсээр зорчин өнгөрч буй иргэдийн байгаль хамгааллын ойлголт, хариуцлагыг нэмэгдүүлэх, хамгаалалтын дэглэмийг мөрдүүлэхэд чухал хувь нэмэр оруулсан.



Зураг 24. Говийн их дархан цаазат газрын “Б” хэсгийн орчны бүсийн, самбар

6.2 Археологийн судалгаагаар тогтоогдсон уурхай орчмын хиргисүүр болон булшнуудыг фото зургаар баримтжуулж бүртгэх:

Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөөний хүрээнд 2010 онд Монгол Улсын Шинжлэх ухааны академийн Археологийн авран хамгаалах хээрийн шинжилгээний баг Хөшөөтийн уурхайн орчмын бүс нутагт судалгаа хийж, нийт 114 ширхэг түүх, соёлын дурсгалт хөшөө, хиргисүүрийг илрүүлэн бүртгэлжүүлсэн байдаг. Уг бүртгэлийн дагуу жил бүр эдгээр дурсгалуудад байнгын хяналт шалгалт хийж, бүрэн бүтэн байдал, эвдрэл гэмтлийн төлөв, хадгалалтын түвшинг фото зургаар баримтжуулан хадгалдаг. Энэхүү хяналт нь түүх, соёлын өвийг хамгаалах, болзошгүй эвдрэл гэмтлээс урьдчилан сэргийлэхэд зорилгоор тогтмол хийгддэг арга хэмжээ юм. 2025 онд тус ажлын хүрээнд 60–63 дугаар бүртгэлтэй хөшөө дурсгал болон хиргисүүрүүдийн байршил, хэлбэр, бүрэн бүтэн байдлыг газар дээр нь шалгаж, өмнөх жилүүдийн баримт зургатай харьцуулан өөрчлөлт, эвдрэл, элэгдэл гарсан эсэхийг үнэлэн баримтжууллаа.



Зураг 25. 60-63 дүгээр хиргисүүрийн бүрэн бүтэн байдлыг зургаар баримжуулсан байдал


БҮЛЭГ 7. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Болзошгүй аюул, осол сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Нийт зардал мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Биелэлтийн шалгуур
1	Аюултай бодисын асгаралт	Химийн бодисын MSDS-д заасны дагуу хадгалах, асгаралт үүссэн онцгой үед хэрэглэх шингээгч материалыг зохих газруудад бэлэн байлгах,	Засварын газар, Лабораторийн агуулах	1,514,700	Жилд 1 удаа	Химийн бодисын MSDS-д заасны дагуу хадгалах, асгаралт үүссэн онцгой үед хэрэглэх шингээгч материалыг зохих газруудад бэлэн байлгах. Химийн бодисын агуулахад асгаралт үүссэн онцгой үед хэрэглэх сэргийлэх хамгаалах иж бүрдэл болон химийн бодисын агуулахад гарч болох эрсдлээс урьдчилан сэргийлэх үүднээс онцгой үед ашиглах дараах хэрэслүүдийг байрлуулсан. Үүнд: <ul style="list-style-type: none"> - Асгаралт үүссэн үед ашиглах тосгуур - Асгаралт үүссэн талбайг хязгаарлагч хөвөн - Үүссэн асгаралтыг шингээгч алчуур - Нүд угаагч шингэн - Галын хор /ABC4 нунтаг/ - Анхны тусламжийн хайрцаг - Тэмдэг тэмдэглэгээ, мэдээлэл гэх мэт 2025 онд нэмэлтээр 10 иж бүрдэлийн худалдан авалтыг хийж нөөц бүрдүүлсэн. Дэлгэрэнгүй мэдээллийг харна уу
2	Аливаа халдварт өвчин бохирдолоос сэргийлэх	Ариутгал халдваргүйтгэл хийлгэх	Уурхайн бүх ажил, амралтын байруудад	9,886,458	Улиралд 1 удаа	“Ховд Жүли” ХХК 2025 оны 11 дүгээр сарын 7-ны өдрийн байдлаар 1 болон 3 дугаар улирлын төлөвлөгөөний дагуу нийт 13,802.29 м ² талбайд ариутгал, халдваргүйтгэл, шавьж болон мэрэгч устгалын ажлыг гэрээт байгууллагаар гүйцэтгүүлж, хяналт тавин ажиллалаа. Ажлын хүрээнд нийтийн бие засах газар, хогийн цэг, ахуйн болон үйлдвэрлэлийн бүсийн объектуудыг хамруулсан бөгөөд зөвшөөрөгдсөн бодисыг журмын дагуу хэрэглэсэн болохыг акт, гэрэл зургаар баримтжуулсан. Мөн 4 дүгээр улирлын ариутгал халдваргүйтгэлийг өмнөх улирлуудад хийсэн талбайнуудад давтан хэрэгжүүлж, халдвар, шавьж, мэрэгчийн тархалтаас урьдчилан сэргийлэв. Дэлгэрэнгүй мэдээллийг харна уу
3	Химийн бодис ашиглах тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулах	Химийн хорт болон аюултай бодисын тооллого хийх, лабораторийн тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах.	Нүүрсний чанарын лаборатори	Үйл ажиллагааны зардлаас	Улирал тутам	Хөшөөтийн уурхайн өрөм болон лабораторит ашиглагдах тусгай зөвшөөрөл бүхий 18 нэр төрлийн химийн бодисын тусгай зөвшөөрлийн хугацаа 2025.12.31 ээр дуусгавар болж байгаатай холбоотой тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах ажлуудыг шат дараатай хэрэгжүүлж байна. БОУАӨЯ-нд үнэлгээ хийлгэх хүсэлт өгсөний дагуу 2025.10.06-ны 10/5084 тоот ерөнхий үнэлгээний дүгнэлт гарсан. БОУАӨЯ-аас ирүүлсэн чиглэлд БОННУ-ний тайланг 2026 оны 2 р улиралд багтаан эрх бүхий мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж тайлан мэдээг ирүүлэх чиглэл өгсөн тул тусгай зөвшөөрөлтэй, эрх бүхий Ойт бүс ХХК-тай гэрээ байгуулан хамтран ажиллаж байна. Дэлгэрэнгүй мэдээллийг харна уу
4	Гал түймэр	Гал түймэр гамшигаас хамгаалах, эрэн хайх, аврах ажиллагааны онол практик хосолсон сургалт	Уурхайн талбай дахь бүх барилга байгууламжууд	7,307,440	Жилд 1 удаа	Сургалтыг Онцгой байдлын Ерөнхий газрын дэргэдэх Уул уурхайн аврах 09 дүгээр ангийн 6 алба хаагч 2025 оны 11 дүгээр сарын 20–21-ний өдрүүдэд Хөшөөт уурхайн байршилд зохион байгуулж, Мо Эн Ко ХХК-ийн сайн дурын бүлгэмийн 20 гишүүн хамрагдав. Дэлгэрэнгүй мэдээллийг харна уу.
Нийт зардал мян.төг				28,708,598		

7.1 Химийн бодисын MSDS-д заасны дагуу хадгалах, асгаралт үүссэн онцгой үед хэрэглэх, шингээгч материалыг зохих газруудад бэлэн байлгах:

Химийн бодисын MSDS-д заасны дагуу хадгалах, асгаралт үүссэн онцгой үед хэрэглэх шингээгч материалыг шаардлагатай газруудад бэлэн байлгах. Химийн бодисын агуулахад асгаралт үүссэн онцгой үед хэрэглэх сэргийлэх хамгаалах иж бүрдэл болон химийн бодисын агуулахад гарч болох эрсдлээс урьдчилан сэргийлэх үүднээс онцгой үед ашиглах дараах хэрэслүүдийг байрлуулсан. Үүнд:

- Асгаралт үүссэн үед ашиглах тосгуур
- Асгаралт үүссэн талбайг хязгаарлагч хөвөн
- Үүссэн асгаралтыг шингээгч алчуур
- Нүд угаагч шингэн
- Галын хор /ABC4 нунтаг/
- Анхны тусламжийн хайрцаг
- Тэмдэг тэмдэглэгээ, мэдээлэл гэх мэт



Зураг 26. Асгаралтаас сэргийлэх иж бүрдэл болон анхны тусламжийн хйарцаг байрлуулсан байдал


Лабораторийн итгэмжлэлийн тухай: Хөшөөт Лаборатори нь анх 2018 онд MNS ISO / IEC 17025:2007 “Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхид тавих ерөнхий шаардлага” итгэмжлэгдсэн. (2018-2020)

2023 онд MNS ISO / IEC 17025:2018 “Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхид тавих ерөнхий шаардлага” итгэмжлэгдсэн. (2023-2025)

2025 онд MNS ISO / IEC 17025:2018 “Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхид тавих ерөнхий шаардлага” давтан итгэмжлэгдсэн. (2025-2029)

Лабораторийн дотоод сургалт: Лаборатори нь жилийн эхэнд нийт ажилтны дотоод сургалтын төлөвлөгөөг гарган хуваарийн дагуу нийт ажилтнуудад хувиарын дагуу ажилтнуудад сард нэг сургалт зохион байгуулдаг.

Тус сургалтуудад химийн бодистой харьцах аюулгүй ажиллагаа, шинжилгээ болон дээж бэлтгэлийн стандарт ажлыг зааврууд, тоног төхөөрөмжтэй харьцах, лабораторид ажиллах аюулгүй ажиллагааны дүрэм, заавар зэрэг багтдаг.



Зураг 27. Лабораторийн дотоод зохион байгуулалт

KHL		Лабораторийн албаны ажилчдын 2025 оны дотоод сургалтын төлөвлөгөө																														
Огноо	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25	26	27	28	29	30	31	
January					L-1			L-4				L-1			L-4				L-1			L-4				L-1						
February		L-2			L-5				L-2			L-5			L-2				L-5			L-2				L-5						
March			L-1L1						L-1L1						L-1L1										L-1L1							
April				L-6						L-6									L-6													
May																																
June																																
July																																
August																																
September										L-9							L-9															
October										L-7				L-7								L-7									L-7	
November			L-1L1		L-8					L-1L2		L-8				L-1L2					L-8											
December		L-3			L-10				L-3			L-10				L-3				L-10												
АЛБАН ТУШААЛ		Shift-I					Shift-II					Shift-III					Shift-IV															
ХИМИН ОПЕРАТОР	Дэлгэрэн ОЮУНИМБГ					Билэс БАТ-ЭРДЭН					Гэлтэнэр САРАХАА					Ветеран БАРИЦАГ																
ХИМИН ОПЕРАТОР	Батзориг УЯНГА					Гэлтэнэр НЭРТҮЙ					Данкхабар СУМ-ОЧИР					Мэгэвэр Төмөрдор																
ХИМИН ОПЕРАТОР	Гэлтэнэр ЖСОНБАЯР					Баттула ЭНЭ-УНДРАЛ					Сүхэвэр НЭМ-ОЧИР					Вет-Эрдэнэ ГЭМЦОЖ																
ХИМИН ОПЕРАТОР	ДАВАА ОРГИЛ					Зодогчурва ЭНХӨЛӨД					Огтогчурва ЦЭЦЭЖИРГАЛ					Хорой АМАРАА																
ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЗАСВАРИН	Баттула ЛУАГВААТАР					Элвэр БАРСҮН					Билэс ПҮРЭВЭЛ					Баттула НЭРТҮЙ																
ДЭЭН БЭЛТГЭГЧ	Энхбаттар УУГАНБАЯР					Ветчүүк ТҮМЭНХАСАН					Риндорв ОУЛБАЯР					Атаргайн ГЭМЦАА																
ДЭЭН БЭЛТГЭГЧ	Ливаа ПҮРЭВЭЛЭМ					Билэвүүк СОНАДРАЛ					Билэвэр НЭМДЭВЭЛ					ДАВАА ГЭМЦӨД																
ДЭЭН БЭЛТГЭГЧ	Волор-Эрдэнэ БАЛНУК					Тунхандраг БАТ-ЭРДЭН					Гясуу САМЧИРБОЛД					Энхбаттар ДАВААДОЖ																
ДЭЭН БЭЛТГЭГЧ	Нийслэл ХАНГАЛ					Цэдэндорв ДАВААДОЖ					Лундч БААТАР					Ветер НАРИАНДАХ																
	Боловруулсан: Лабораторийн супервайзор: <i>[Signature]</i> А. Сүхэвэр Билэс: Лабораторийн эрхлэгч: <i>[Signature]</i> И. Цэдэндорв																															
	Subject of training Lesson-1 KHL-IP-TP Training of Sample Preparation Lesson-2 KHL-IP-TP Training of Total Moisture Lesson-3 KHL-IP-TP Training of Flow and Sink Analysis Lesson-4 KHL-IP-TP Training of Proximate Analysis Lesson-5 KHL-IP-TP Training of Calorific Value Lesson-6 KHL-IP-TP Training of Total Sulphur Lesson-7 KHL-IP-TP Training of Xy Indices Lesson-8 KHL-IP-TP Training of Fluorine Lesson-9 KHL-IP-TP Training of Crucible Swelling Number Lesson-10 KHL-IP-TP Training of Fluorine Lesson-11,2 KHL-IP-TP Training of Chemicals																															

7.2 Аливаа халдварт өвчин бохирдлоос сэргийлэх зорилгоор ариутгал халдавгүйжүүлэлт хийх:

Ариутгал халдавгүйжүүлэлтийг хүний эрүүл мэнд болон хүнсний бүтээгдэхүүнд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор мэргэжлийн байгууллагаар хийлгэдэг. 2025.04.23 нд “Ноён худаг” ББН-ийн халдваргүйтгэлийн баг ирж шавжгүйтгэл, мэрэгчгүйтгэл, халдваргүйтгэл хийсэн. Үүнд:

- Ажилчдын амрах байр Хүндэлэл кемпийн өрөө тасалгаануудад
- Уурхайн оффис
- Засварын газар
- Кемдийн гал тогоо
- Спорт заал
- Гэрүүд

2025 оны 11 дүгээр сарын 7-ны өдрийн байдлаар 1 болон 3 дугаар улирлын төлөвлөгөөний дагуу нийт 13,802.29 м² талбайд нийт 3 удаа “Ноён худаг” ББН, Номт титэм ХХК-иудаар ариутгал, халдавгүйтгэл, шавьж болон мэрэгч устгалын ажлыг гэрээт байгууллагаар гүйцэтгүүлж, хяналт тавин ажиллалаа. Ажлын хүрээнд нийтийн бие засах газар, хогийн цэг, ахуйн болон үйлдвэрлэлийн бүсийн объектуудыг хамруулсан бөгөөд зөвшөөрөгдсөн бодисыг журмын дагуу хэрэглэсэн болохыг акт, гэрэл зургаар баримтжуулсан. Мөн 4 дүгээр улирлын ариутгал халдавгүйтгэлийг өмнөх улирлуудад хийсэн талбайнуудад давтан хэрэгжүүлж, халдвар, шавьж, мэрэгчийн тархалтаас урьдчилан сэргийлэв.



Зураг 28. Хүндлэл кемп, оффис, засварын газруудад ариутгал халдавгүйжүүлэлт хийж байгаа нь

7.3 Химийн хорт болон аюултай бодисын тооллого хийх:

Ашиглах зөвшөөрөл бүхий 18 нэр төрлийн химийн бодисын тооллогыг сар тутам хийж бүртгэл хөтлөн ажиллаж байна. Хөшөөтийн уурхайн лабораторит хэрэглэдэг химийн бодисын ашиглалт, зарцуулалтын тайланг 2025.01.01-2025 оны 10 сарын 31-ний байдлаар нэгтгэн гаргасаныг дараах хүснэгтээс харна уу.

Хүснэгт 14. 2025 оны химийн бодис ашигласан мэдээ

№	Ашиглах зориулалт	Химийн бодисын нэр		Томъёо	CAS дугаар	Өмнөх оны үлдэгдэл	Тухайн онд ирсэн хэмжээ	Нийт	Ашигласан хэмжээ	Үлдэгдэл нөөц	Хэмжих нэгж
		Монгол	English								
1	Нүүрсний баяжуулалтанд	Перхлорэтилен	Perchloroethylene	C ₂ Cl ₄	127-18-4	1809.5	1969.0	3778.5	57	2193.0	л
2	Нүүрсний баяжуулалтанд	Цагаан спирт	White spirit	-	8052-41-3	654.5	750.0	1404.5	898.5	506.0	л
3	Нүүрсний баяжуулалтанд	Хлорт цайр	Zinc chloride	ZnCl ₂	7646-85-7	942.7	0.0	942.7	862.7	80.0	л
4	Хүхэр тодорхойлох	Магнийн перхлорат	Magnesium perchlorate	Mg(ClO ₄) ₂	10034-81-8	2.4	0.0	2.37	0.20	2.2	кг
5	Дулаан тодорхойлох	Бензойны хүчил	Benzoic acid	C ₆ H ₅ COOH	65-85-0	0.2	0.0	0.18	0.159	0.00	кг
6	G-индекс тодорхойлох	Антрацит	Antracite	-	8029-10-5	121.0	100.0	221	117.0	104.0	Кг
7	Фторын шинжилгээнд	Натрийн гидроксид	Sodium hydroxide	NaOH	1310-73-2	13.0	0.0	12.995	0.79	12.2	Кг
8	Фторын шинжилгээнд	Тринатрийн цитрат	Trisodium citrate	Na ₃ C ₆ H ₅ O ₇	6132-04-3	10.69	0.0	10.69	1.19	9.50	Кг
9	Фторын шинжилгээнд	Калийн нитрат	Potassium nitrate	KNO ₃	7757-79-1	17.3	0.0	17.304	0.30	17.0	Кг
10	Фторын шинжилгээнд	Азотын хүчил	Nitric acid	HNO ₃	7697-37-2	16.1	0.0	16.05	0.010	16.0	л
11	Фторын шинжилгээнд	Бромокрисол ногоон индикатор	Bromocresol green indicator	C ₂₁ H ₁₄ Br ₄ O ₅ S	76-60-8	0.5	0.0	0.45	0.006	0.4	кг
12	Фторын шинжилгээнд	Этилийн спирт	Ethanol	C ₂ H ₅ OH	64-17-5	13.2	0.0	13.15	0.010	13.1	л
13	Фторын шинжилгээнд	Натрийн фторид	Sodium fluoride	NaF	7681-49-4	11.5	0.0	11.506	0.011	11.5	кг
14	Фторын шинжилгээнд	Лимоны хүчил (талст)	Crystalline citric acid	C ₆ H ₈ O ₇	77-92-9	4.5	0.0	4.536	0.036	4.5	кг
15	Фторын шинжилгээнд	Хүхрийн хүчил	Sulfuric Acid	H ₂ SO ₄	7664-93-9	0.9	0.0	0.9	0.0	0.9	л
16	Дулаан, фтор, хүхэр тодорхойлох	Хүчилтөрөгч	Oxygen	O ₂	7782-44-7	-	-	-	-	-	баллон
17	Хөөлтийн зэрэг тодорхойлох	Пропан	Propane	C ₃ H ₈	74-98-6	-	-	-	-	-	баллон
18	Фторын шинжилгээнд	Кварцын элс	Quartz sand	SiO ₂	14808-60-7	2.2	2.5	4.65	1.78	2.9	кг

7.4 Гал түймэр гамшигаас хамгаалах, эрэн хайх, аврах ажиллагааны онол практик хосолсон сургалт:

Уурхайн ажилтнуудад Гамшигаас хамгаалах тухай болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулиудын хэрэгжилтийг хангах, ажилтнуудын мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор онол-практик хосолсон сургалтыг батлагдсан сургалт, дадлагын хөтөлбөрийн дагуу зохион байгууллаа.

Сургалтын үеэр дараах чиглэлүүдээр мэдлэг олгов. Үүнд:

- Ажлын байрны аюулыг илрүүлэх, мэдээлэх арга
- Аюулын дүн шинжилгээ хийх
- Ажлын байрны нөхцөл, тоостой тэмцэх арга хэмжээ
- Эрүүл мэндэд хор нөлөө, урьдчилан сэргийлэлт
- Болзошгүй гамшиг, ослын эрсдэлийг бууруулах арга
- Аюул, осолд дөхсөн тохиолдлын хяналт
- Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилт

Сургалтыг Онцгой байдлын Ерөнхий газрын дэргэдэх Уул уурхайн аврах 09 дүгээр ангийн 6 алба хаагч 2025 оны 11 дүгээр сарын 20–21-ний өдрүүдэд Хөшөөт уурхайн байршилд зохион байгуулж, Мо Эн Ко ХХК-ийн сайн дурын бүлгэмийн 20 гишүүн хамрагдав.



Зураг 29. Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх аврах 9-р ангиас сургалт.

БҮЛЭГ 8. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн нхамрах хүрээ	Нийт зардал мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа	Биелэлтийн шалгуур	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ахуйн	Уурхайн ойр орчмын уст цэгүүд, төслийн зам талбайд хийсч тарсан хог хаягдлын цэвэрлэгээ зохион байгуулах	Төслийн талбай	Үйл ажиллагааны зардлаас	сард 2 удаа	Хөшөөтийн гол, Түвшин буйрын рашаан, Тахилтын булгийн эх болон уст цэгүүдийн ойр орчмын хог хаягдлыг 14 хоног бүр тогтмол цэвэрлэн ажиллав. Цэвэрлэгээний үеэр нийт 500 гаруй шуудай, ойролцоогоор 20 тонн хог хаягдлыг цуглуулж, уурхайн нэгдсэн хогийн цэгт хүргэж ажилласан. Дэлгэрэнгүй мэдээллийг харна уу.	Хог хаягдлын тухай хууль
2		Хог хаягдал ангилан ялгаж түр хадгалах талбай байгуулах.	Засварын газар	-	5 сард	Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах үүднээс оффисын болон кемпийн өрөөнүүдэд 4 төрлөөр ангилан ялгах зориулалт бүхий хогийн сав байрлуулж ангилан ялгаж байна. Үүнд -PLASTIC Хуванцар, Гялгар уут /ус, ундааны сав, бүх төрлийн гялгар уут/ -PAPER Цаас /бичгийн цаас, кардон бүх төрлийн цаасны хаягдал/ -NON RECYCLABLE Бусад хог /дахин ашиглах боломжгүй бусад хаягдал/ -CLASS CANS Шил болон лааз / хор саармагжуулах бүтээгдэхүүний шил, ундааны лааз/. Мөн засварын газарт 60*25м харьцаатай цемент, хайрган суурьтай хог хаягдал ангилан ялгах, түр хадгалах зориулалт бүхий тасалгаатай талбай байгуулахаар зураг төсөл гарган. Дэлгэрэнгүй мэдээллийг харна уу.	
3	Үйлдвэрийн	Гэрээт байгууллагаар нүүрс тээврийн 311 км зам дагуух хог хаягдлын цэвэрлэгээг хийлгэх, гэрээ байгуулах	Нүүрс тээврийн зам дагуу	21,818,818.81	3-12 сар	Нүүрс тээврийн 311 км зам дагуух хог хаягдлыг цэвэрлэх, ангилан ялгах, хогийн нэгдсэн цэг рүү тээвэрлэх үйл ажиллагааг сард 2-3 удаа хийхээр Ховд аймгийн Цэцэг сумын цэвэрлэгээ үйлчилгээний “Мянган сүтэйн буян” ОНӨААТҮГ- тай 2024 оны 9 сараас гэрээ байгуулан тайлан мэдээг нэгтгэн ажиллаж байна. Дэлгэрэнгүй мэдээллийг харна уу.	
4	Аюултай	Уурхайн эмнэлгийн гаралтай хог хаягдлыг Цэцэг сумын эмнэлэгт хүргүүлж журмын дагуу устгах	Уурхайн талбай	1,200,000	Тухай бүр	Уурхайн эмнэлгийн гаралтай хог хаягдлыг Цэцэг сумын эмнэлэгт хүргүүлж журмын дагуу устгах Уурхайн эмнэлгийн үйл ажиллагаанаас гарсан эмнэлгийн аюултай хог хаягдлыг Цэцэг сумын хүн эмнэлэгтэй байгуулсан гэрээний дагуу Цэцэг суманд хүргэж устгуулж байна. 2025 оны 12 сарын байдлаар 221.5 кг эмнэлгийн гаралтай хог хаягдлыг устгуулсан байна. Үүнд: <ul style="list-style-type: none"> ➤ Халдвартай хог хаягдал- 148 кг ➤ Хурц үзүүртэй иртэй хог хаягдал- 73.5 кг Дэлгэрэнгүй мэдээллийг харна уу. 	
5		Хог хаягдал шатаах зуух авах	Уурхайн хэмжээнд		6 сард	2025 оны БОМТ-ны хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд заасны дагуу уурхайн үйл ажиллагаанаас гарч буй ахуйн гаралтай хог хаягдлыг устгах зорилгоор Нүүдэлчин Эко Ресурс ХХК-ээс нийлүүлэхээр төлөвлөн худалдан авах гэрээ байгуулан ажиллаж байсан боловч боломжгүй болсон тул уг худалдан авалтыг 2026 оны	

						төсөвт суулган хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн Дэлгэрэнгүй мэдээллийг харна уу.	устгах журам,
6		Засварын газраас гарах ашигласан тосыг хуримтлуулж хадгалахад хяналт тавих, бүртгэл хөглөх, тусгай зөвшөөрөлтэй ААН-д акт үйлдэж шилжүүлэх, аюултай хог хаягдлын тайлан мэдээг улирал тутам БО-ны газарт хүргүүлэх	Уурхайн талбай	Үйл ажиллагааны зардлаас	Тогтмол	<p>Засварын газраас гарах ашигласан тосыг хуримтлуулж хадгалахад хяналт тавих Засварын газраас гарч буй ашигласан тосыг 20 тоннын багтаамжтай 2 ёмкост хадгалаж хяналт тавьж ажиллаж байна. Засварын газар Хуурай баяжуулах үйлдвэр, зэрэг ажлын талбайд ажлын байрны үзлэг хийж орчны цэвэрлэгээ хийлгэж, хог хаягдлыг ангилан ялгаж, аюултай хог засварын газар байрлах аюултай хог хаягдал түр хадгалах талбайд байрлуулан бүртгэн авч ажилласан.</p> <p>Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ● Аккумулятор жижиг, том нийт 52 ширхэг ● Ашигласан тос масло 10.37 тонн ● Тос маслын шүүр 341 ширхэг ● Агаар шүүгч 180 ширхэг ● Ашигласан дугуй 268 ширхэг Дэлгэрэнгүй мэдээллийг харна уу.	
Нийт зардал, мян.төг						23,018,819	

8.1 Уурхайн ойр орчмын уст цэгүүд, төслийн зам талбайд хийсч тарсан хог хаягдлын цэвэрлэгээ зохион байгуулах:

Хөшөөтийн гол, Түвшин буйрын рашаан, Тахилтын булгийн эх болон уст цэгүүдийн ойр орчмын хог хаягдлыг 14 хоног бүр тогтмол цэвэрлэн ажиллав. Цэвэрлэгээний үеэр нийт 500 гаруй шуудай, ойролцоогоор 20 тонн хог хаягдлыг цуглуулж, уурхайн нэгдсэн хогийн цэгт хүргэж ажилласан.



Зураг 30. Тахилтын булаг болон Түвшин буйрын рашааны ойр орчмыг цэвэрлэгээ

Кемп болон Оффисын чиглэлийн зам дагуу хог хаягдлыг цэвэрлэх ажлыг зохион байгуулж, хэрэгжүүлсэн. Мөн Дарви сумын Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 1/192 тоот албан тоотын дагуу МоЭнКо ХХК болон гэрээт туслан гүйцэтгэгч ХХК-иудын нийт ажилтанууд Хөшөөтийн хөндий, уурхайн орчимд 901 га талбайд бүх нийтийн хог цэвэрлэгээний ажлыг 2025 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр зохион байгууллаа. Тус ажлыг 5 ААН-ийн нийт 130 орчим хүний бүрэлдэхүүнтэйгээр цэвэрлэгээг хийж гүйцэтгэн 720 гаруй шуудай буюу 40 гаруй тн хог цэвэрлэж уурхайн нэгдсэн хогийн цэгт хүргэж ажилласан.

- Нийт цэвэрлэгээнд 5 компанийн 130 орчим ажилтан оролцосон.
- Ажилласан техник: Ковш-2ш, Автосамосвал(МТ-86) 1ш, бонго-2 ш, пикап-7ш ажилласан.





Зураг 31. Хог цэвэрлэгээ хийх үеийн зураг

8.2 Хог хаягдал ангилан ялгаж түр хадгалах талбай байгуулах.

Усны хуванцар савыг цуглуулах, тээвэрлэх, дахин ашиглах эрх бүхий мэргэжлийн байгууллагад нийлүүлэх, преслэх, Оффис болон Кемп зэрэг ажлын болон амралтын газар хуримтлагдсан ундаа, усны хуванцар сав, чанар болон лабораторийн албанаас гарсан дээжийн уут зэргийг преслэж нийт 31 пресс буюу 2.6 тонн хуванцар сав болон дээжийн уутыг преслэх ажлыг хийж гүйцэтгэсэн.



Зураг 32. Хуванцар сав преслэгч ажлуулж байгаа байдал

8.3 Гэрээт байгууллагаар нүүрс тээврийн 311 км зам дагуух хог хаягдлын цэвэрлэгээг хийлгэх, гэрээ байгуулах

Мянган Сутайн Буян ОНӨААТҮГ-тай гэрээ байгуулж Хөшөөт уурхайн нүүрс ачилтын цэгээс Булган сумын гүүр хүртэлх 305 км замын хоёр талын 50 метрийн ойр орчмын хог хаягдлыг сар бүр 2 удаа цэвэрлэх ажлыг хийж гүйцэтгүүлсэн.

Гэрээний хэрэгжилтийн хүрээнд 2025 оны байдлаар нийт 10 удаагийн цэвэрлэгээ зохион байгуулж, зам дагуух хог хаягдлыг бүрэн цуглуулан ангилж, 203 машин хог буюу нийт 963 тонн хог хаягдлыг зөвшөөрөгдсөн хогийн цэгт хүргэн устгуулсан байна.



Зураг 33 Нүүрс тээврийн зам дагуу цэвэрлэгээ хийж байгаа нь

8.4 Уурхайн эмнэлгийн гаралтай хог хаягдлыг Цэцэг сумын эмнэлэгт хүргүүлж журмын дагуу устгах:

Уурхайн эмнэлгийн үйл ажиллагаанаас гарсан эмнэлгийн аюултай хог хаягдлыг Цэцэг сумын Эрүүл мэндийн төвтэй байгуулсан гэрээний дагуу Цэцэг суманд хүргэж устгуулж байна. 2025 оны 12 сарын байдлаар 273.5 кг эмнэлгийн гаралтай хог хаягдлыг устгуулсан байна. Үүнд:

- Халдвартай хог хаягдал- 186 кг
- Хурц үзүүртэй иртэй хог хаягдал- 87.5 кг

Хүснэгт 15. Эмнэлгийн үйл ажиллагаанаас гарсан эмнэлгийн аюултай хог хаягдал

№	Бүртгэл хийх хугацаа	Эмнэлгийн хог хаягдал/ кг	
		Халдвартай хог хаягдал / кг /	Хурц үзүүртэй хог хаягдал / кг /
1	2025.01 сар	8	4
2	2025.02 сар	36	11.5
3	2025.03 сар	18	9
4	2025.04 сар	22	9.5
5	2025.05 сар	12	9
6	2025.06 сар	15	8
7	2025.07 сар	10	6
8	2025.08 сар	5	2.5
9	2025.09 сар	18	9.5
10	2025.10 сар	18	8.5
11	2025.11 сар	15	6
12	2025.12 сар	9	4
Нийт дүн /ш/		186	87.5

8.5 Хог хаягдал шатаах зуух авах:

2025 оны БОМТ-ны хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд заасны дагуу уурхайн үйл ажиллагаанаас гарч буй ахуйн гаралтай хог хаягдлыг устгах зорилгоор Нүүдэлчин Эко Ресурс ХХК-ээс нийлүүлэхээр төлөвлөн худалдан авах гэрээ байгуулан ажиллаж байсан боловч боломжгүй болсон тул уг худалдан авалтыг 2026 оны төсөвт суулган хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн.

Жижиг 700кг

1. Байгаль орчинд ээлтэй, агаарын бохирдол болон хөрсний бохирдлыг бууруулж шатаалтаас үүсэх утаа болон угаарын хийг 99% шатаадаг гол онцлогтой.
2. Тус зуух нь 700кг багтаамжтай бөгөөд тухайн хогоо 30 минут дотор шатаана.
3. Бүрэн шаталтай тул үнс маш бага гарч 700кг хогноос 18 кг үнс гарна.
4. Асалтыг дамжих 1 санстай 10 цаг ажиллах хүчин чадалтай бөгөөд 2 цаг амраан үргэлжлүүлэн ажилласнаар 24 цаг ч үргэлжлүүлэн ажиллуулах боломжтой.
5. Хог шатаах зуух нь 3 ширхэг дугуйтай бөгөөд богино зайд зөөвөрлөхөд хялбар.

**20,000,000.007 /батарейтай/
17,000,000.007 /батарейгүй /**

1. 46x26x26см хэмжээтэй 220в гаралтай 5 кВт-ийн хүчин чадалтай зөөврийн цахилгаан цэнэг хурьгууртай.
2. Асалтыг дамжих 250ватт хүчин чадалтай 1 ширхэг санстай бөгөөд дахин 1 ширхэг сансний эзлэвэстэй.

MEC

MONGOLIA ENERGY CORPORATION

М о н К о Х Х К

ХУДАЛДАХ ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ
SALES AND PURCHASE AGREEMENT

No: MoEnCo0XXX-2025

Улаанбаатар: 2025 оны 11-р сарын 06

Ulaanbaatar: 2025/11/06

Гарчиг: Хог шатаах зуух	Title: Incineration furnace
Худалдан авагч: МоЭнКо ХХК Регистрийн дугаар: 5141583	Buyer: MoEnCo LLC Company certificate: 5141583
Худалдагч: "Нүүдэлчин Эко Ресурс" ХХК Регистрийн дугаар: 6991033	Seller: Nuudelchin Eco Resource LLC Company certificate: 6991033
Нэг талаас "МоЭнКо" ХХК-г төлөөлж Дэд захирал Жамсрангийн Оюунчимэг (нашид "Захиалагч" гэх), нөгөө талаас "Нүүдэлчин Эко Ресурс" ХХК-г төлөөлж Гүйцэтгэх захирал Баярцогийн Дэлгэрдавай (нашид "Гүйцэтгэгч" гэх) хамтад нь "Талууд" гэх/ нар Монгол Улсын Иргэний хуулийн 343-358 дугаар зүйлүүдийг удирдлага болон дараах нөхцөлийн талаар харилцан тохиролцож байгуулав.	The present contract is, on the basis of Article 343-358, Civil Code Mongolia made by and between Oyunchimeg Jamsran, De Director, representing MoEnCo LLC (hereinafter referred as 'Client and Delgerdalai Bayartsog, Executive Director presenting "Nuudel Eco Resource" LLC (hereinafter referred as 'Contractor') together Parties agreed on the following terms and conditions.

Зураг 34. Шатаах зууны танилцуулга болон худалдан авах гэрээ

8.6 Засварын газраас гарах ашигласан тосыг хуримтлуулж хадгалахад хяналт тавих, бүртгэл хөтлөх, тусгай зөвшөөрөлтэй ААН-д акт үйлдэж шилжүүлэх, аюултай хог хаягдлын тайлан мэдээг улирал тутам БО-ны газарт хүргүүлэх:

Засварын газраас гарсан ашигласан тосыг хуримтлуулж, хадгалах зорилгоор 20 тонн багтаамжтай хоёр ёмкос байрлуулан, тогтмол хяналт тавин ажиллаж байна. Мөн засварын газар, хуурай баяжуулах үйлдвэр зэрэг ажлын талбайд үзлэг хийж, орчны цэвэрлэгээ зохион байгуулан, хог хаягдлыг ангилан ялгалт хийж, аюултай хог хаягдлыг засварын газарт байрлах түр хадгалах талбайд байршуулж, бүртгэл мэдээллийг хөтөлөн ажилласан. Үүнд:

- Аккумулятор жижиг, том нийт 52 ширхэг
- Ашигласан тос масло 10.37 тонн
- Тос маслын шүүр 341 ширхэг
- Агаар шүүгч 180 ширхэг
- Ашигласан дугуй 268 ширхэг





Зураг 35. Ашиглалтаас гарсан аккумулятор, агаар шүүгч, тос маслоны шүүр, ашигласан тосыг түр хадгалах талбайд барлуулсан байдал

Аюултай хог хаягдал үүсгэгчийн тайлангийн маягт

1 Тайлангийн жил: 2 | 0 | 2 | 5

2 Бүртгэлийн дугаар: У | | | | | | | | | |

3 Аж ахуйн нэгжийн нэр: МоЭнКоХХК

4 Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн дугаар: 9 0 | 1 | 9 0 | 2 | 3 | 0 | 2 | 5

5 Аж ахуйн нэгжийн регистрийн дугаар: 5 1 | 4 | 1 5 | 8 | 3 |

6 Аж ахуйн нэгжийн хаяг: Аймаг/хот: Ховд
Смд дүүрэг: Дарви
Баг/хороо: Мөрөн
Гудамж/дугаар:

6 Өмчийн хэлбэр: Төрийн өмч Үеийн Гаднын хөрөнгө оруулалттай

7 Үүсгэсэн аюултай хог хаягдлын мэдээлэл/шардлагатай бол нэмэлт хуудас хэрэглэнэ/

№	Код	Аюултай хог хаягдлын нэр	Үүссэн хэмжээ / хэмжээ нэгж сар												Нийт дүн
			1 сар Тоош	2 сар Тоош	3 сар Тоош	4 сар Тоош	5 сар Тоош	6 сар Тоош	7 сар Тоош	8 сар Тоош	9 сар Тоош	10 сар Тоош	11 сар Тоош	12 сар Тоош	
1	1 6 0 6 0 1	* Аккумулятор / ширлэг	4	3	6	4	2	0	3	4	6	8	12		52
2	1 3 0 2 0 1	* Ашигласан тос масол лиер	0.9	0.7	1.1	1.3	0.6	0.7	0.6	0.8	1	2.2	0.47		10.37
3	1 6 0 1 1 8	* Ашигласан дугуй ширлэг	32	24	41	52	14	10	8	13	9	42	23		268
4	1 6 0 1 0 4	* Маслолын шүүр/ ширлэг	42	35	24	56	28	27	21	26	31	42	14		341
5	1 5 0 1 0 9	* Маслолын сав	30	32	37	42	28	31	23	34	36	46	21		360
6	1 5 0 1 0 9	* Хявийн бодисын баглаа боорол	40.26	36.54	31.5	44.09	241.5	38.64	10.5	2.46	6.82	6.13	8.45		456.89
7	1 5 0 1 0 9	* Хявийн бодисын сав ширлэг	49	48	51	62	65	59	25	8	16	12	8		403
8	1 5 0 1 0 9	* Гялын торны баглан	11	7	8	10	9	0	0	12	15	21	9		102
9	1 8 0 1 0 3	* Эмнэлгийн хаягдал	8	10	12	22	6	15	10	5	18	18	15	9	148
		Халтвартай кг халтваргүй	4	3.5	6	12.5	3	8	6	2.5	9.5	8.5	6	4	73.5
10	1 6 0 1 1 8	* Машинны агаар шүүгч	9	17	29	32	10	5	11	15	10	31	11		180

8 Аюултай хог хаягдла тээвэрлүүлсэн тээвэрлэгчийн мэдээлэл

Тээвэрлэгч аж ахуйн нэгжийн нэр		Бүртгэлийн дугаар			


9 Аюултай хог хаягдла устгуулсан бийгууллагын мэдээлэл

№	Аж ахуйн нэгжийн нэр	Бүртгэлийн дугаар	Үүссэн хэмжээ	Хямаж хэмжээ
1	У			
2	У			
3	У			

10 Үүсгэсэн аюултай хог хаягдла дотооддоо дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа явуулдаг бол

№	Код	Хэмжээ	М.жж	Устгасан боловсруулсан арга
1				
2				
3				
4				
5				
6				
7				

Зураг 36. Аюултай хог хаягдлын бүртгэлийн маягт



Зураг 37. Аюултай хог хаягдлын талбайн ерөнхий зураг, байгууллах газрын хөрс хуулалт ажил хийгдэж байгаа байдал

БҮЛЭГ 9. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Нийт зардал мян.төг	Биелэлтийн шалгуур	Баримтлах стандарт, арга, аргачлал
Гадаргын ба газар доорхи усны хяналт шинжилгээ						
1	Хөшөөтийн уурхай орчмын уст цэгүүд болон Үенч голын ус, ҮГХТ, Булган голын уснаас дээж авч химийн ерөнхий шинжилгээг итгэмжлэгдсэн лабораториор шинжлүүлэх	Хөшөөтийн уурхай орчмын уст цэгүүд болон Үенч Булган сум	Сар бүр	5,240,200	2025 оны 3, 6, 9 дүгээр саруудад уст цэгүүдээс дээж авч MNAS үндэсний итгэмжлэлийн төв рүү хүргүүлж усны ерөнхий химийн шинжилгээнд хамруулсан. <ul style="list-style-type: none"> ✓ Уурхайн худаг /ерөнхий хими, хүнд металл/ ✓ Хөшөөт гол /ерөнхий хими, хүнд металл / ✓ Түвшин буйрын рашаан /ерөнхий хими, хүнд металл/ ✓ Тахилтын булаг /ерөнхий хими, хүнд металл / ✓ Шүүрлийн ус Phase-3 /ерөнхий хими, хүнд металл / ✓ Шүүрлийн ус (WDH-02) цооног /ерөнхий хими, хүнд металл/ ✓ Үенч сумын төвийн худаг /ерөнхий хими, хүнд металл/ ✓ Үенч голын ус /ерөнхий хими, хүнд металл/ ✓ Булган голын ус /ерөнхий хими, хүнд металл/ Шинжилгээнд хамрагдсан дээрхи уст цэгүүдэд химийн үндсэн үзүүлэлтүүд нь “Ундны усны стандарт MNS0900:2018”-ын шаардлага хангаж байна. Дээжийн хариуг хавсралтаас харна уу.	MNS0900:2010 MNS4586:1998
2	Хөшөөтийн уурхай орчмын уст цэгүүд болон ҮГХТ, Үенч голын уснаас дээж авч хүнд металлын шинжилгээг итгэмжлэгдсэн лабораториор шинжлүүлэх	Хөшөөтийн уурхай орчмын уст цэгүүдээс дээж авч итгэмжлэгдсэн лабораторит шинжилгээнд хамруулах	Улирал		MNS0900:2010 MNS4586:1998	
3	Хөшөөтийн уурхай орчмын уст цэгүүдээс дээж авч цацрагийн шинжилгээг итгэмжлэгдсэн лабораториор шинжлүүлэх	Хөшөөтийн уурхай орчмын уст цэгүүд болон Үенч, Булган сум	Улиралд		Уурхайн орчмын уст цэг болон Булган гол, Үенч гол, Үенч сумын төвийн худаг зэрэг 12 цэгээс усны дээж авч цацрагийн шинжилгээнд 2025 онд өгсөн усны дээжүүдийг ХАНЛАБ болон ГеоАналитик, Усны газрын усны хяналтын төв лабораторид шинжлүүлж ажилласан. Дээжийн хариуг хавсралтаас харна уу.	MNS0900:2010 MNS4586:1998
4	Бохир усны химийн шинжилгээ	Хөшөөтийн уурхайн цэвэрлэх байгууламж	Улиралд		2025 онд 3, 6 саруудад уурхайн цэвэрлэх байгууламжаас бохир усны дээж авч Усны газрын дэргэдэх Усны төв лабораторид MNS 4943:2015 ерөнхий шаардлага стандартын үзүүлэлтүүдээр шинжилгээ хийлгэсэн. Дээжийг хавсралтаас харна уу.	
5	Үенч Бодонч, Булган голын мониторингийн судалгаа	ҮББГСГЗ	Жилд 1 удаа	1,839,487	Үенч Бодонч Булган голын сав газрын захиргаа, МоЭнКо ХХК-н хамтран сүүлийн 4 жил тогтмол тус судалгааг хийж байна. Энэ ажлын хүрээнд 2025 оны 7 сарын 22-ноос 7 сарын 26-ны хооронд Ховд аймгийн Үенч сумын нутаг Улиаст, Ховд аймгийн Булган сумын нутаг Дээд нарийн, Доод нарийн, Баян-Өлгий аймгийн Булган сумын нутаг Шүвтэр, Ёлт, Сайханы гол, Хөх гол, Хөх нуур, Сэрүүн нуур, Хэцүү сай, Түргэн, Сөнхөл гэсэн чиглэлд явж усны тоо бүртгэлийн ажлыг хийж гүйцэтгэсэн. Нийт гол-27, нуур-2, булаг-4 бүртгэж физик, химийн хэмжилтүүд хийсэн. Дэлгэрэнгүй мэдээллийг харна уу.	Усны тухай хууль
6	Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор хөв байгуулах	Цэцэг сум, Хажинга баг Дунд амны Хажуу булаг	Багц	-	2025 онд БОМТ-ны ОХШХ-ийн хүрээнд бэлчээрийн усан хангамжийг сайжруулах зорилгоор малчид болон зэрлэг амьтдад зориулсан хөв байгуулах ажил төлөвлөгдсөн. Хөв байгуулах байршлыг Цэцэг сумын	Усны тухай хууль

					Хажинга багийн “Хажуу” булгийг түшиглэн сонгож, зураг төсөл боловсруулан орон нутгийн удирдлагуудад танилцуулсан. Дэлхийн зах зээлд нүүрсний үнийн уналтаас шалтгаалан уурхайн үйл ажиллагаа 2025 оны 7 дугаар сарын 10-наас 9 дүгээр сарын 1-ний хооронд түр зогссон, мөн хөв байгуулах гүйцэтгэгч ААН-ыг сонгон шалгаруулах үйл явц удааширсан зэрэг шалтгааны улмаас тус ажлыг гүйцэтгэх боломж бүрдээгүй. ➤ Иймээс уг асуудлаар Цэцэг сумын ЗДТГ болон Хажинга багийн засаг даргатай уулзалт зохион байгуулж, хөв байгуулах ажлыг 2026 оны хоёрдугаар улиралд хэрэгжүүлэхээр тохиролцсон. Дэлгэрэнгүй мэдээллийг харна уу.	
	Нийт				7,079,687	
Агаарын чанарын хяналт шинжилгээ						
7	Мэргэжлийн байгууллагаар уурхай орчмын агаарын төлөв байдлын судалгааны ажил хийлгэх	Мониторингийн цэгүүд	Хагас жил	28,000,000	Грейн Ази Консалтинг ХХК-тай 2025 оны 9 дугаар сарын 9-ны өдрийн MoEnCo0123/2025 тоот хамтран ажиллах гэрээ байгуулан жилд 1 удаа агаарын төлөв байдал чанарын болон тоосны судалгаа шинжилгээг 2025 оны 9 дүгээр сарын 26-29 – ний хооронд хийж гүйцэтгэж судалгааны үр дүнг харьцуулсан тайланг гаргасан. Дэлгэрэнгүй мэдээллийг харна	MNS4585:2007 Агаарын чанар, техникийн ерөний шаардлага
8	Уурхай орчмын агаарын тоосонцорын /PM10, PM2.5/ хэмжилтийг хийлгэх	Мониторингийн цэгүүд	14 хоног 1 удаа	Үйл ажиллагааны зардлаас	Уурхай орчмын агаарын чанарын хяналтын 10 цэгт таних тэмдэг тэмдэглэгээ байрлуулсан. Хөшөөтийн уурхай орчмын тоосны хэмжилтийг хяналтын 10 цэгт /pm2.5, pm10/ АНУ-д үйлдвэрлэгдсэн “DustTrak II Aerosol Monitor” 2 ширхэг багажаар 14 хоногт 1 удаагийн давтамжтай хийж мэдээллийн сан үүсгэн тухайн жилийн байгаль орчны менежмент төлөвлөгөөний биелэлтийн тайланд тусган ажиллаж байна. “DustTrak II Aerosol Monitor” багаж нь АНУ-д үйлдвэрлэсэн багаж юм ажиллагаа нь бодит хугацаан дахь аэрозолын масс концентрацийг лазер сарнилын фотометрийн аргаар 10 микроноос бага хэмжээтэй PM2.5, PM10 тоосонцруудыг нэгэн зэрэг шууд хэмждэг автомат багаж юм. Дэлгэрэнгүй мэдээллийг харна уу.	MNS4585:2007 Агаарын чанар, техникийн ерөний шаардлага
9	Dust track багажны үйлдвэрийн тохиргоо хийлгэх	Мониторингийн цэгүүд	Багц	6,332,777.20	“DustTrak II Aerosol Monitor” багажний үйлдвэрийн тохиргоог АНУ-ын TSI-н үйлдвэрт 2 жилд 1 удаа хийлгэдэг. Үйлдвэрийн тохиргоог энэ жил бас хийлгэсэн байгаа. Дэлгэрэнгүй мэдээллийг харна уу.	
	Нийт				34,639,149	
Хөрсний судалгаа шинжилгээ						
10	Уурхай орчмын хөрсний мониторингийн цэгээс дээж авч хими, физик, хүнд металлын шинжилгээнд хамруулах	Хөшөөтийн уурхай орчмын мониторингийн цэгүүдээс	Улиралд	8,640,000	Уурхай орчмын хөрсний хяналтын 16 цэг, Үенч гаалийн хяналтын талбайн 6 цэгээс дээж авч улиралд 1 удаа Улаанбаатар хот “Классик лэнд” ХХК-ийн “Дээж” хөрс судлал, усны сорилтын итгэмжлэгдсэн лабораторид химийн үндсэн шинж, механик бүрэлдэхүүн, хүнд металлын агууламжийг тогтмол шинжлүүлж ажилласан. Дэлгэрэнгүй мэдээллийг харна уу.	MNS 3298:1990 Байгаль хамгаалал. Хөрс. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд, MNS 5850:2019 Хөрс

11	Уурхай орчмын хөрсний мониторингийн цэгээс дээж авч цацрагийн шинжилгээ хийлгэх	Хөшөөтийн уурхай орчмын мониторингийн цэгүүдээс	Жилд 1 удаа	720,000	Уурхайн орчмын 16 цэгээс хөрсний дээж авч цацрагийн шинжилгээнд Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторид (ХАБҮЛЛ) шинжилүүлж ажилласан. Дэлгэрэнгүй мэдээллийг харна уу.	бохирдуулагч бодис элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
Нийт				9,360,000		
Ургамал, Амьтны аймгийн судалгаа						
12	Усны амьтад болон голын татмын ургамал, шавьжийн судалгаа мэргэжлийн байгууллагаар хийлгэх	Хөшөөтийн гол	1 удаа	28,331,818	Уурхайн үйл ажиллагаа Хөшөөт голын усны чанар болон орчны бүрэлдэхүүнд ямар нөлөө үзүүлж буйг үнэлэх зорилгоор голын дагуух хэд хэдэн цэгийг сонгон судалгааг 2025 оны 09 сарын 08-наас 10-ны өдрүүдэд Байгаль орчны судалгаа, үнэлгээний Грийнтрэндс ХХК хийж гүйцэтгэв. Судалгаагаар усны сээр нуруугүйтэн амьтад, татмын ургамлын зүйлийн бүрдэл, тархалт, арвийг тодорхойлж, усны чанар ба бохирдлын түвшний үнэлгээ хийв. Судалгааны хамгийн ойр цэг нь уурхайгаас 1.2 км зайтай бөгөөд талбайн байршлын тойм зургийг доор харуулав. Дэлгэрэнгүй мэдээллийг харна уу.	БОНБҮТ ХУУЛЬ, Аудитын зөвлөмж
13	Цаг хүндэрсэн үед уурхайн нөлөөллийн бүс дэх зэрлэг ан амьтанд биотехникийн арга хэмжээ авах	Нөлөөллийн бүсийн сумд	1 удаа	21,000,000	<p>2025 оны 2-р сард МоЭнКо ХХК нь аймгийн хэд хэдэн суманд байгаль хамгаалах биотехникийн арга хэмжээг хэрэгжүүлэв.</p> <p>Дарви сумын Сутай хайрхан уулын тусгай хамгаалалттай газар (Баясгалантын ам, Бургастайн ам, Музан) болон Цэцэг сумын Мянган угалзтын нуруу (Хөх хөндийн эх, Босгийн хөтөл, Сөрт) орчимд тус бүр 200 боодол өвс, 1 тонн хужир байршуулж, янгир ямаа, аргаль угалзын өвөлжилтийг дэмжлээ.</p> <p>Үенч-Бодонч-Булган голын сав газрын захиргаа, мэргэжилтнүүд болон байгаль хамгаалагчид хамтран зэрлэг амьтдын өвөлжилтийг дэмжих зорилгоор 200 боодол өвс, 1 тонн хужир байршууллаа. Биотехникийн арга хэмжээг Баянсудал багийн Доод Нарийн эх, Дээд Нарийн болон Баянгол багийн Улиаст орчимд хэрэгжүүлэв.</p> <p>Мөнххайрхан уулын байгалийн цогцолбор газар болон Говийн их Дархан цаазат газрын “Б” хэсгийн нутагт 200 боодол өвс, 1 тонн хужир тавьж, зэрлэг амьтдын хоол тэжээлийн хангамжийг сайжруулах арга хэмжээ авсан.</p> <p>Алтай сумын нутаг дахь ГИДЦГ-ын “Б” хэсэгт 200 боодол өвс, 1 тонн хужир байршуулж, үүнээс 100 боодол өвс, 0.3 тонн хужирыг Тахийн усан орчимд тавьж өвөлжилтийн нөхцөлийг сайжруулсан. Дэлгэрэнгүй мэдээллийг харна уу.</p>	Амьтны тухай хууль
Нийт				49,331,818		
ОХШХ-н нийт зардал, төг				100,410,654		

9.1 Гадаргын ба газар доорхи усны хяналт шинжилгээ

9.1.1 - 9.1.3 Хөшөөтийн уурхай орчмын уст цэгүүд болон Үенч голын ус, ҮГХТ, Булган голын уснаас дээж авч химийн ерөнхий, хүнд металл, цацрагийн шинжилгээг итгэмжлэгдсэн лабораториор шинжлүүлэх:

Хөшөөтийн уурхай орчмын уст цэгүүдийн усыг химийн ерөнхий шинжилгээнд мэргэжлийн лабораториор шинжлүүлэх 2025 оны 1, 2, 3, 4 дүгээр улирлын усны дээжийг Хөшөөтийн уурхай орчмын уст цэгүүдээс дээж авч Усны хяналтын төв лабораторид усны химийн ерөнхий агууламж, хүнд металлын агууламж зэргийг тодорхойлуулсан. Шинжилгээ асван цэгүүдийн нэршлийг дурдвал: үүнд

- ✓ Түвшин буйрийн рашаан
- ✓ Тахилтын булаг
- ✓ Хөшөөтийн гол
- ✓ Уурхайн худаг
- ✓ Well 1 цооног
- ✓ Үенчийн гаалийн хяналтын бүс
- ✓ Үенчийн худаг
- ✓ Булган гол

Шинжилгээнд хамрагдсан дээрхи уст цэгүүдэд химийн үндсэн үзүүлэлтүүд нь “Ундны усны стандарт MNS0900:2018”-ын шаардлага хангаж байна. Дээжийн хариуг хавсралтаас харна уу.



Зураг 38. Уст цэгүүдийн усыг химийн ерөнхий шинжилгээ

9.1.4 Бохир усны химийн шинжилгээ

2025 онд 3, 6 саруудад уурхайн цэвэрлэх байгууламжаас бохир усны дээж авч Усны газрын дэргэдэх Усны төв лабораторид MNS 4943:2015 ерөнхий шаардлага стандартын үзүүлэлтүүдээр шинжилгээ хийлгэсэн.



Зураг 39. Бохир ус соруулах болон шинжилгээ авч буй байдал

9.1.5 Үенч, Бодонч, Булган голын мониторингийн судалгаа:

Үенч Бодонч Булган голын сав газрын захиргаа, МоЭнКо ХХК-н хамтран сүүлийн 4 жил тогтмол тус судалгааг хийж байна. Энэ ажлын хүрээнд 2025 оны 7 сарын 22-ноос 7 сарын 26-ны хооронд Ховд аймгийн Үенч сумын нутаг Улиаст, Ховд аймгийн Булган сумын нутаг Дээд нарийн, Доод нарийн, Баян-Өлгий аймгийн Булган сумын нутаг Шүвтэр, Ёлт, Сайханы гол, Хөх гол, Хөх нуур, Сэрүүн нуур, Хэцүү сай, Түргэн, Сөнхөл гэсэн чиглэлд явж усны тоо бүртгэлийн ажлыг хийж гүйцэтгэсэн. Нийт гол-27, нуур-2, булаг-4 бүртгэж физик, химийн хэмжилтүүд хийсэн.




Зураг 40. Үенч Бодонч Булган голын сав газрын мониторинг

9.1.6 Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор хөв байгуулах:

2025 онд БОМТ-ны ОХШХ-ийн хүрээнд бэлчээрийн усан хангамжийг сайжруулах зорилгоор малчид болон зэрлэг амьтдад зориулсан хөв байгуулах ажил төлөвлөгдсөн. Хөв байгуулах байршлыг Цэцэг сумын Хажинга багийн “Хажуу” булгийг түшиглэн сонгож, зураг төсөл боловсруулан орон нутгийн удирдлагуудад танилцуулсан. Дэлхийн зах зээлд нүүрсний үнийн уналтаас шалтгаалан уурхайн үйл ажиллагаа 2025 оны 7 дугаар сарын 10-наас 9 дүгээр

сарын 1-ний хооронд түр зогссон, мөн хөв байгуулах гүйцэтгэгч ААН-ыг сонгон шалгаруулах үйл явц удааширсан зэрэг шалтгааны улмаас тус ажлыг гүйцэтгэх боломж бүрдээгүй.

Иймээс уг асуудлаар Цэцэг сумын ЗДТГ болон Хажинга багийн засаг даргатай уулзалт зохион байгуулж, хөв байгуулах ажлыг 2026 оны хоёрдугаар улиралд хэрэгжүүлэхээр тохиролцсон.



Зураг 41. Хөв байгуулах ажлын төлөвлөлтийн зураг

9.2 Агаарын чанарын хяналт шинжилгээ

9.2.1 Мэргэжлийн байгууллагаар уурхай орчмын агаарын төлөв байдлын судалгааны ажил хийлгэх:

Грейн Ази Консалтинг ХХК-тай 2025 оны 9 дугаар сарын 9-ны өдрийн MoEnCo0123/2025 тоот хамтран ажиллах гэрээ байгуулан жилд 1 удаа агаарын төлөв байдал чанарын болон тоосны судалгаа шинжилгээг 2025 оны 9 дүгээр сарын 26-29 – ний хооронд хийж гүйцэтгэж судалгааны үр дүнг харьцуулсан тайланг гаргасан. Судалгааны ажлын дүгнэлтээр уурхайн бүсэд хэмжсэн хий төлөвт бохирдуулагчдын агууламж Монгол улсын агаарын чанарын техникийн ерөнхий шаардлага MNS4548:2025-д заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээний хязгаарт байгаа бол тоос тоосонцрын агууламж уурхайн оффис болон уурхайн хойд чиглэлд сонгосон цэгүүд дээр зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давсан бохирдолтой, дуу шуугианы түвшин уурхайн оффис орчим зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс их, тоос тоосонцрын гол эх үүсвэр нь хуурай баяжуулах үйлдвэр болон хүнд даацын тээврийн замууд бөгөөд хүчтэй салхи шуурга тоосжилтын нөлөөллийг улам бүр нэмэгдүүлж байна.

Агаарын чанарын мониторингийн цэгийн байршил ерөнхийдөө тохиромжтой бөгөөд уурхай дотоод хяналтын хэмжилтийг гүйцэтгэх төлөвлөгөө боловсруулан ажиллах хэрэгтэй. Хөшөөтийн уурхай орчмын салхины горимыг авч үзвэл баруун өмнө болон өмнө зүгийн салхи зонхилох тул Хөшөөтийн гол, Хөшөөтийн хөндий, Мөрөн баг, Хүндлэл кемп орчмын

мониторингийг цэгт сар бүр хугацаат ажиглалтын горимоор буюу 02, 08, 14, 20 цагуудад хэмжилт хийж хоногийн дундаж стандарттай харьцуулан дүгнэх хэрэгтэй. Бусад мониторингийн цэгүүдэд улиралд нэг удаа хугацаат ажиглалтын горимоор хэмжилтийг гүйцэтгэх шаардлагатай ба уурхайгаас өмнө чиглэлд байрлах цэгүүд дээр хэмжилт хийхдээ хойд зүгийн салхитай өдрүүдэд хэмжилтийг гүйцэтгэвэл тохиромжтой.

Уурхайн үйл ажиллагаанаас үүссэн тоос тоосонцрын хоногийн дундаж агууламж 50 мкг/м^3 болж буурах зайг уурхайн нөлөөллийн бүс гэж үзвэл судалгааны хугацаанд уурхайн идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй бүсээс хойд болон зүүн хойд чиглэлт **4 км, бусад чиглэлд 1 км хүртэлх зайд** тоосжилтын нөлөөлөл илрэх ба Хөшөөтийн хөндий орчим гол нөлөөлөл нь илэрч байна.

Тархалтын зураглалын үр дүнг хэмжилтийн үр дүнтэй харьцуулахад хэмжилтийн үр дүн зарим хугацаанд өндөр байгаа нь уурхайгаас хойд чиглэлд байрлах мониторингийн цэгүүд дээр **Зүүн Хөшөөтийн уурхайн тоосны нөлөөлөл** байгааг харуулж байна.

Хөшөөтийн уурхайн онцлог нь өндөр уулсын бүсэд байрлах тул уурхайн үйл ажиллагаанаас үүссэн тоос тоосонцор нь уул хөндийн салхины нөлөөгөөр тархах нөхцөлтэй байна. Мөн судалгааны хугацаанд ажиглагдсан нэг зүйл нь уурхайн бүсэд үүссэн тоос тоосонцор босоо чиглэлдээ тархан агаар мандлын тогтвортой үе давхаргад хуримтлагдаж алс зайд зөөвөрлөгдөж болзошгүй байна. Иймд уурхайн үйл ажиллагаанаас үүсэх тоосжилтыг бууруулах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх шаардлагатай.

Уурхайн бүс дэх агаар бохирдуулах эх үүсвэрийг нөлөөллийн хэмжээгээр нь үнэлэхэд технологийг замууд, баяжуулах үйлдвэрийн ажиллагаа, нүүрс ачиж буулгах гаалийн талбай, элэгдэл эвдрэлд орсон хөрсний салхины элэгдлээр үүсэх тоос тоосонцор гол эх үүсвэр болж байна. Иймд тоосжилтыг бууруулах менежментийг боловсруулахдаа замаас үүсэх тоосыг бууруулах, элэгдэл эвдрэлд илүү ихээр өртдөг нүүрс хүлээн авах бункерийн талбай зэрэгт түйрэн үүсэхээс сэргийлсэн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

Уурхайн тоосны тархалтын тооцоолол судалгаанд цаг агаарын үндсэн параметрууд зайлшгүй шаардлагатай байдаг. Учир нь салхины хурд, чиглэл нь газрын гадаргын хотгор гүдгэрийн байдлаас ихээхэн хамаарах тул төслийн талбайг төлөөлөх байршилд цаг уурын станц байгуулах хэрэгтэй.

Усан халаалтын зуухнуудын хаягдал утааны найрлага дахь хий төлөвт бохирдуулагчдын агууламж “Халаалтын ба гэрийн зуухны яндангаар гарах утааны найрлага дахь агаар бохирдуулагч бодисын хүлцэх дээд хэмжээ ба хэмжих арга” MNS5457:2005 стандартад зөвшөөрөгдөх дээд хэмжээний хязгаарт, бамбар утааны дагуу хэмжсэн хий төлөвт бохирдуулагчдын агууламж Монгол улсын агаарын чанарын техникийн ерөнхий шаардлага MNS4548:2025-д заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээний хязгаарт байлаа.

Загварчлалын тооцооллоор усан халаалтын зуухнуудын хаягдал утаанаас орчны агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл харьцангуй бага байсан ба энэ нь халаалтын зуухнуудын хүчин чадал бага, том зуухнууд нь үнс барих төхөөрөмжөөр тоноглогдсон зэрэгтэй холбоотой байна.

Уурхайн тоосжилтыг бууруулах олон арга байдаг. Эдгээрээс хамгийн түгээмэл хэрэглэгддэг арга нь усалгаа боловч усны нөөцийн асуудал болон эрс тэс цаг агаарын нөхцөлөөс шалтгаалан хязгаарлагдмал ашиглагддаг. Сүүлийн үеийн судалгаанаас харахад ил уурхайн тоосжилтыг бууруулахад Канад улсын abcdust компанийн DMS-DS төрлийн бодисыг өргөн ашиглаж байна. Энэ бодис нь 0.25 микрон нанополлимер болон спиртийн холимгоос бүрдсэн гадаргуугийн идэвхт бодис бөгөөд тоос тоосонцрын дэгдэлтийг 95-98%-ийг бууруулах ба усаар чийгшсэн замтай харьцуулахад тоормосны барих зайг 35-82%-иар сайжруулдаг. Энэ бодисыг усалгааны машинуудын саванд хольж хэрэглэж болох ба усны зарцуулалтыг 90% хүртэл бууруулж, замын засвар үйлчилгээтэй холбоотой зардлыг бууруулна гэж дүгнэж, зөвлөмж ирүүлсэн.



Зураг 42. Уурхайн Усан халаалтын зуухнуудын бамбар утааны дагуух хэмжилт





Зураг 43. Агаарын чанарын хяналтын цэгүүдийн байршил

9.2.2 Уурхай орчмын агаарын тоосонцорын /PM10, PM2.5/ хэмжилтийг хийх:

Уурхай орчмын агаарын чанарын хяналтын 10 цэгт таних тэмдэг тэмдэглэгээ байрлуулсан. Хөшөөтийн уурхай орчмын тоосны хэмжилтийг хяналтын 10 цэгт /pm2.5, pm10/ АНУ-д үйлдвэрлэгдсэн “DustTrak II Aerosol Monitor” 2 ширхэг багажаар 14 хоногт 1 удаагийн давтамжтай хийж мэдээллийн сан үүсгэн тухайн жилийн байгаль орчны менежмент төлөвлөгөөний биелэлтийн тайланд тусган ажиллаж байна. “DustTrak II Aerosol Monitor” багаж нь АНУ-д үйлдвэрлэсэн багаж юм ажиллагаа нь бодит хугацаан дахь аэрозолын масс концентрацийг лазер сарнилын фотометрийн аргаар 10 микроноос бага хэмжээтэй PM2.5, PM10 тоосонцруудыг нэгэн зэрэг шууд хэмждэг автомат багаж юм.



Зураг 44. Уурхай орчмын агаарын тоосоны хэмжилт

9.2.3 Dust track багажны үйлдвэрийн тохиргоо хийлгэх:

“DustTrak II Aerosol Monitor” багажний үйлдвэрийн тохиргоог АНУ-ын TSI-н үйлдвэрт 2 жилд 1 удаа хийлгэдэг. Үйлдвэрийн тохиргоог энэ жил бас хийлгэсэн байгаа.



TSI Incorporated
 500 Cardigan Road
 Shoreview, MN 55126
 USA
 EIN 41-0843524

Tel: (800)680-1220
Fax: (651)490-3824
Web: www.TSI.com
Email: answers@TSI.com

Page 1 of 1
 12/04/2025
 13:10:23

Int'l RG Delivery Note

Shipping Address	Information
MoEnCo LLC 3rd Floor Tushig Center Seoul street 23 Sukhbaatar District 4th Khoroo 14250 Ulaanbaatar Mongolia	 Document Number 81578679 Document Date 12/03/2025 Purchase Order No. PO001-2025 Purchase Order Date 09/17/2025 Sales Order Number 1270424 Sales Order Date 09/17/2025 Customer Number 5477515 Incoterms 2020 CPT: Line Item Consignee's Premises Ship Date 12/04/2025 BOL/Tracking # 467764030265 Ship Via FedEx Int'l Economy
Contact Information	
Munkhsaikhan Gundsambuu Tel: 99059693 Fax: 77110570	
Sold To Address	
MoEnCo LLC 3rd Floor Tushig Center Seoul street 23 Sukhbaatar District 4th Khoroo 14250 Ulaanbaatar Mongolia	

Item	Material/Description	Cntry/Orig	Quantity	Notes
Purchase Order No.				
1	8530 DustTrak II Desktop *** Contains Lithium Ion Batteries, Packed with Equipment *** Serial numbers: (8530175122) RMA: 300724378	US	1 EA	
These items are controlled by the U.S. Government and authorized for export only to the country of ultimate destination for use by the ultimate consignee or end-user(s) herein identified. They may not be resold, transferred, or otherwise disposed of, to any other country or to any person other than the authorized ultimate consignee or end-user(s), either in their original form or after being incorporated into other items, without first obtaining approval from the U.S. Government or as otherwise authorized by U.S. law and regulations.				

Зураг 45. “DustTrak II Aerosol Monitor” багажний үйлдвэрийн тохиргоо хийлгэсэн гэрчилгээ

9.3 Хөрсний судалгаа шинжилгээ

9.3.1 Уурхай орчмын хөрсний мониторингийн цэгээс дээж авч хими, физик, хүнд металлын шинжилгээнд хамруулах:

Уурхай орчмын хөрсний хяналтын 16 цэг, Үенч гаалийн хяналтын талбайн 6 цэгээс дээж авч улиралд 1 удаа Улаанбаатар хот “Классик лэнд” ХХК-ийн “Дээж” хөрс судлал, усны сорилтын итгэмжлэгдсэн лабораторид химийн үндсэн шинж, механик бүрэлдэхүүн, хүнд металлын агууламжийг тогтмол шинжлүүлж ажилласан.

9.3.2 Уурхай орчмын хөрсний мониторингийн цэгээс дээж авч цацрагийн шинжилгээ хийлгэх:

Уурхайн орчмын 16 цэгээс хөрсний дээж авч цацрагийн шинжилгээнд Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторид (ХАБҮЛЛ) шинжилүүлж ажилласан.




Зураг 46. Хөрсний дээж

9.4 Ургамал, Амьтны аймгийн судалгааны дүгнэл, санал

9.4.1 Усны амьтад болон голын татмын ургамал, шавьжийн судалгаа мэргэжлийн байгууллагаар хийлгэх:

Уурхайн үйл ажиллагаа Хөшөөт голын усны чанар болон орчны бүрэлдэхүүнд ямар нөлөө үзүүлж буйг үнэлэх зорилгоор голын дагуух хэд хэдэн цэгийг сонгон судалгааг 2025 оны 09 сарын 08-наас 10-ны өдрүүдэд Байгаль орчны судалгаа, үнэлгээний Грийнтрендс ХХК хийж гүйцэтгэв. Судалгаагаар усны сээр нуруугүйтэн амьтад, татмын ургамлын зүйлийн бүрдэл, тархалт, арвыг тодорхойлж, усны чанар ба бохирдлын түвшний үнэлгээ хийв. Судалгааны

хамгийн ойр цэг нь уурхайгаас 1.2 км зайтай бөгөөд талбайн байршлын тойм зургийг доор харуулав.



Зураг 47. Судалгааны талбайн байршлын зураг

Дүгнэлт, санал

2025 онд хээрийн судалгааг нийт 5 цэгт хийж гүйцэтгэлээ. Судалгааны үр дүнд 13 овог, 34 төрөл, 42 зүйлийн гуурст дээд ургамал бүртгэгдсэн. 5 болон 4-р цэгүүд нь үетэн-алаг өвс зонхилсон хадархаг уулын дунд өндөрлөг хэв шинжтэй байсан бол 1–3-р цэгүүд нь шарилж, харгана давамгайлсан голын садарга, сайрын хэв шинжтэй байв. Судалгааны явцад нэн ховор болон ховор ургамлын зүйл илрээгүй бөгөөд нийт 14 эндемик болон субэндемик зүйл (үүнээс 4 нь эндемик, 10 нь субэндемик) тэмдэглэгдсэн байна. Хөшөөт голын орчим, ялангуяа 4-р цэгийн бүсэд уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй тоосонцор салхины нөлөөгөөр хуримтлагдан, хөрс болон ургамлын гадаргуу дээр бараан өнгийн нимгэн давхарга үүссэн нь ажиглагдсан. Иймд цаашид агаарын чанар, хөрсний бүтэц болон ургамлын бүрхэвчийн өөрчлөлтөд хяналт тавих зорилгоор тогтмол мониторингийн судалгааг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай байна.



Farinopsis salesoviana- Залесовын зэдгэлж

Salicornia altaica- Алтайн хэрс

Potentilla bifurca- Иймт Гичгэнэ

Ascellia flexuosa- Тачир акселли

Зураг 48. Судалгааны үр дүнгээр илэрсэн ургамалын төрөл зүйл

Дүгнэлт, санал

Хөшөөт голын усны экосистемд хийсэн судалгаагаар 2 хүрээ, 3 анги, 8 баг, 13 овгийн 14 төрлийн ёроолын макро-сээр нуруугүйтэн амьтад бүртгэгдсэн байна. Судалгааны үр дүнгээр 1–3-р цэгийн ус цэвэр, уурхайн нөлөөлөлд өртөөгүй болох нь тогтоогдсон бол 4–5-р цэгүүдэд ёроолын амьтдын төрөл, нягтшил буурч, ЕРТ шавж байхгүй болсон нь усны булинггаржилт, тоосжилтын нөлөөг харуулж байна. Түүнчлэн татмын бүсэд 6 багийн 18 овогт хамаарах 26 төрлийн 33 зүйл шавж илрүүлэгдсэн бөгөөд зарим нь зөвхөн Монгол Алтайд тархдаг эндемик зүйл байв. Судалгаагаар уурхайн үйл ажиллагаанаас шалтгаалсан тунадас, нарийн ширхэгт тоосны нөлөөгөөр усны экосистемийн бүтэц, төрөл зүйлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орж байгаа нь ажиглагдсан. Иймээс Хөшөөтийн уурхай нь Хөшөөт голын усны чанар болон биологийн олон янз байдлыг тогтмол мониторингийн судалгаагаар хянах, доройтлоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай гэж дүгнэв. Мөн усанд хөнгөн цагаан (Al), төмрийн (Fe) агууламж хүлцэх хэмжээнээс давсан тул анхаарч, бууруулах арга хэмжээ авах хэрэгтэй.



Судалгааны 5-р цэгт давамгайл тоогоор тохиолдсон *Gammarus lacustris* (Sars, 1863) зүйл хавч хэлбэртэн



Apatania sp. (Trichoptera, Apatanidae) зүйлийн хоовгон (1,2,3,5-р цэг)

Зураг 49. Судалгааны үр дүнгээр илэрсэн макро-сээрнуруугүйтэн

9.4.2 Цаг хүндэрсэн үед уурхайн нөлөөллийн бүс дэх зэрлэг ан амьтанд биотехникийн арга хэмжээ авах:

Тус ажлын хүрээнд Булган, Үенч, Алтай, Цэцэг, Дарви сумдын нутагт биотехникийн арга хэмжээ авч, нийт 1000 ширхэг пресс өвс, 5 тонн хужрыг сумдын ЗДТГ, Үенч–Бодонч–Булган голын сав газрын захиргаа, Говийн их Дархан цаазат газрын Б хэсэг, Мянгат угалзат байгалийн цогцолбор газрын захиргаагаар хамтран хэрэгжүүлсэн.

Дарви сумын Мөрөн багийн Засаг дарга, сумын Байгаль хамгаалагч хамтарч нартай 2025 оны 2 дугаар сарын 19-ны өдөр Дарви сумын Сутай хайрхан уул тусгай хамгаалалттай газар нутгаар янгир ямааны бэлчээр болох Баясгалантын ам, Бургастайн ам, Музан гэх газруудад өвс 200 пресс, хужир 1 тонныг тавьж биотехникийн арга хэмжээ авч ажилласан. Үүнд:

- Сутай хайрхан уул улсын тусгай хамгаалалттай газар нутаг Баясгалантын ам 80 пресс өвс, 0.3 тонн хужир
- Сутай хайрхан уул улсын тусгай хамгаалалттай газар нутаг Бургастайн ам 80 пресс өвс, 0.3 тонн хужир
- Сутай хайрхан уул улсын тусгай хамгаалалттай газар нутаг Музан 40 пресс өвс, 0.4 тонн хужир



Зураг 50. Дарви сум зэрлэг ан амьтад биотехникийн арга хэмжээ

Цэцэг сумын Баян овоо багийн Мянган угалзтын нурууны байгалийн цогцолбор газрын Аргаль, Угалз нутагладаг Хөх хөндийн эх, Босгийн хөтөл, Сөрт гэх газруудад тусгай хамгаалалтын захиргааны байгаль хамгаалагч нартай хамтарч өвс 200 пресс, хужир 1 тонныг 2025 оны 2 дугаар сарын 18 -ны өдөр тавьж биотехникийн арга хэмжээ авч ажилласан. Үүнд:

- Мянган угалзатын нурууны Аргаль нутагладаг Хөх хөндийн эх нэртэй газарт 80 пресс өвс, 0.4 тонн хужир
- Мянган угалзатын нурууны Аргаль нутагладаг Босгийн хөтөл, нэртэй газарт 80 пресс өвс, 0.3 тонн хужир
- Мянган угалзатын нурууны Аргаль нутагладаг Сөрт, нэртэй газарт 40 пресс өвс, 0.3 тонн хужир



Зураг 51. Цэцэг сум зэрлэг ан амьтад биотехникийн арга хэмжээ

2025 оны 2 дугаар сарын 17-ны өдөр Мөнххайрхан уулын байгалийн цогцолбор газар болон Говийн их Дархан цаазат газрын Б хэсгийн нутагт биотехникийн арга хэмжээ авч хэрэгжүүлсэн. Тус арга хэмжээг Үенч сумын Засаг даргын Тамгын газрын Байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч, мөн Говийн их Дархан цаазат газрын Б хэсгийн байгаль хамгаалагч нартай хамтран 200 пресс өвс 1 тонн хужир тавьж биотехникийн арга хэмжээ авч ажилласан.

Үүнд:

- Мөнххайрхан уул улсын тусгай хамгаалалттай газар нутаг Нарийны цахир дэвсэг 80 ш пресс өвс, 0.4 тонн хужир
- Мөнххайрхан уул улсын тусгай хамгаалалттай газар нутаг Харгайтын өвөр цахир 80 ш пресс өвс, 0.3 тонн хужир
- ГИДЦГазрын Б хэсгийн нутаг Мэргэн хайрхан 40 ш пресс өвс, 0.3 тонн хужир



Зураг 52. Үенч сум зэрлэг ан амьтад биотехникийн арга хэмжээ

2025 оны 2 дугаар сарын 15-нд Говийн их Дархан цаазат газрын Б хэсгийн нутагт биотехникийн арга хэмжээ хэрэгжүүлэв. Алтай сумын ЗДТГазрын Байгаль орчны хяналтын улсын байцаагч, сумын байгаль хамгаалагч, ГИДЦГ-ын байгаль хамгаалагч нар хамтран ажиллаж, нийт 200 боодол өвс, 1 тонн хужир бүхий тэжээлийг зэрлэг амьтад зориулан байршуулсан. Тухайлбал Тахийн усан орчимд 100 боодол өвс, 0.3 тонн хужир тавьж, биотехникийн арга хэмжээ авч ажилласан.





Зураг 53. Алтай сум зэрлэг ан амьтад биотехникийн арга хэмжээ

Мөнххайрхан уулын байгалийн цогцолборт газрын нутагт 2025 оны 2 дугаар сарын 16-ны өдөр биотехникийн арга хэмжээ хэрэгжүүлэв. Уг ажлыг Үенч–Бодонч–Булган голын сав газрын захиргааны дарга, мэргэжилтнүүд болон байгаль хамгаалагчид хамтран зохион байгуулж, зэрлэг амьтдын өвөлжилтийг дэмжих зорилгоор 200 боодол өвс (пресс), 1 тонн хужир байршуулсан. Биотехникийн арга хэмжээг тус сумын Баянсудал багийн Доод Нарийн эх, Дээд Нарийн, мөн Баянгол багийн Улиаст зэрэг байршилд хэрэгжүүлсэн. Үүнд:

- Мөнххайрхан уулын байгалийн цогцолбор газрын нутаг Доод нарийн эх 50 ш пресс өвс, 0,3 тонн хужир
- Мөнхайрхан уулын байгалийн цогцолборт газар нутаг Дээд нарийн 70 ш пресс, 0,3 тонн хужир
- Мөнххайрхан уулын байгалийн цогцолборт газрын нутаг Улиаст 80 ш пресс, 0,3 тоон хужир



Зураг 54. Булган сум зэрлэг ан амьтад биотехникийн арга хэмжээ

**БҮЛЭГ 10. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА
ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар	Биелэлтийн шалгуур
			2025 он					
			Сар	Сар	Сар			
1	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө ба түүний биелэлтийн тайланг боловсруулах	0		0	0	Байгаль орчны орлогч менежер Б.Ганболд	Хэрэгжилт 90 %-с доошгүй байх	Тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтийн тайланг боловсруулан хуулийн хугацаанд БОУАӨЯ-ны мэдээллийн санд оруулсан. Дэлгэрэнгүй мэдээллийг харна уу.
2	Уурхайд ашиглагдаж байгаа Химийн бодисын БОННУ-нд нэмэлт тодотгол /Хуулийн хугацаа дуусч байгаа/	38,000,000	0	4	6	Байгаль орчны орлогч менежер Б.Ганболд	БОНБУТ хууль	Байгаль орчны үнэлгээний чиглэлээр тусгай зөвшөөрөлтэй "Ойт бүс" ХХК-тай гэрээ байгуулан хамтран ажиллаж, Хөшөөтийн уурхайн өрөм болон лабораторид ашиглагдах химийн бодисын БОННУ- ний ажлыг гүйцэтгүүлж байна. БОУАӨЯ-нд химийн бодис ашиглахтай холбоотой байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийлгэх хүсэлт хүргүүлсэн. Энэхүү хүсэлтийн дагуу БОУАӨЯ-аас 2025 оны 10 дугаар сарын 6-ны өдөр 10/5084 дугаар бүхий Ерөнхий үнэлгээний дүгнэлт гаргасан. БОУАӨЯ-аас ирүүлсэн уг дүгнэлтэд, Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний (БОННУ) тайланг 2026 оны хоёрдугаар улиралд багтаан эрх бүхий, тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж, холбогдох тайлан, мэдээг агентлагт хүргүүлэх чиглэл өгсөн. Дэлгэрэнгүй мэдээллийг харна уу.
3	Уурхайн газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийлгэх.	59,090,910	0	5	10	Байгаль орчны орлогч менежер Б.Ганболд	Газрын тухай хууль, Газрын төлөв байдал, чанарын улсын хянан батллагаа хийх журам	Хянан баталгааны ажилд шаардлагатай мэргэжлийн байгууллагыг сонгон шалгаруулж, тусгай зөвшөөрөлтэй "Аватар ХХК"-тай гэрээ байгуулан хянан баталгааны ажлыг хийж гүйцэтгэсэн. Дэлгэрэнгүй мэдээллийг харна уу.
Нийт зардал, мян.төг							97,090,910	

10.1 Байгаль орчны менежментийн төлөвлөгөө ба түүний биелэлтийн тайланг боловсруулах

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалын дагуу байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын 4.1-д зааснаар, төсөл хэрэгжүүлэгч нь тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг биелүүлж, түүний үр дүнг тусгасан биелэлтийн тайланг 11 дүгээр сарын 1-ний өдөр багтаан, журмын 3-р хавсралтын дагуу боловсруулж, харьяалагдах аймаг, нийслэлийн байгаль орчны газарт 3-аас доошгүй хэвлэмэл хувь болон цахим хэлбэрээр хүргүүлэх үүрэгтэй. Үүний дагуу, 2025 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан-г боловсруулж, БОУАӨЯ-ны мэдээллийн санд цахимаар урьдчилан илгээж, мөн аймгийн байгаль орчны газарт хэвлэмэл хувилбараар хүргүүлэн ажиллаж байна.

10.2 Уурхайд ашиглагдаж байгаа Химийн бодисын БОННУ-нд нэмэлт тодотгол хийлгэх

МоЭнКо ХХК-ийн Хөшөөтийн чулуун нүүрсний уурхайн хайгуулын өрөм болон нүүрсний чанарын лабораторийн үйл ажиллагаанд ашиглагддаг тусгай зөвшөөрөлтэй 18 нэр төрлийн химийн бодисын тусгай зөвшөөрлийн хугацаа 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болох тул тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахтай холбоотой ажлуудыг холбогдох хууль, дүрэм, журмын дагуу шат дараатайгаар хэрэгжүүлж байна.

Тодруулбал: Тус ажлын хүрээнд МоЭнКо ХХК нь БОУАӨЯ-нд химийн бодис ашиглахтай холбоотой байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийлгэх хүсэлт хүргүүлсэн. Энэхүү хүсэлтийн дагуу БОУАӨЯ-аас 2025 оны 10 дугаар сарын 6-ны өдөр 10/5084 дугаар бүхий Ерөнхий үнэлгээний дүгнэлт гаргасан. БОУАӨЯ-аас ирүүлсэн уг дүгнэлтэд, Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний (БОННУ) тайланг 2026 оны хоёрдугаар улиралд багтаан эрх бүхий, тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж, холбогдох тайлан, мэдээг агентлагт хүргүүлэх чиглэл өгсөн.

Дээрх чиглэлийн дагуу МоЭнКо ХХК нь байгаль орчны үнэлгээний чиглэлээр тусгай зөвшөөрөлтэй “Ойт бүс” ХХК-тай гэрээ байгуулан хамтран ажиллаж, Хөшөөтийн уурхайн өрөм болон лабораторид ашиглагдах химийн бодисын БОННУ- ний ажлыг гүйцэтгүүлж байна. БОННУ-ны ажлыг хийлгэсэнээр химийн бодисын аюулгүй хэрэглээг хангах, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, мөн төслийн үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд үргэлжлүүлэхэд чиглэгдэнэ.


10.3 Уурхайн газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийлгэх:

МоЭнКо ХХК-ийн үйл ажиллагаа явуулж буй төслийн талбайн газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны хугацаа 2025 онд дуусаж байгаатай холбогдуулан уг хянан баталгааны ажлыг зохион байгууллаа. Ажлыг “Газрын тухай” хуулийн 58 дугаар зүйл, Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоолоор баталсан “Газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хийх журам”, мөн Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 34 дүгээр тушаалын 4 дүгээр хавсралтад заасан “Газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны ажлын заавар”-ын дагуу гүйцэтгэсэн.

Хянан баталгааны хүрээнд тусгай зөвшөөрөлтэй талбайн газар ашиглалт, хөрсний хэв шинж, ангилал, ургамлын бүлгэмдэл, хөрсний эвдрэлийн хэмжээ, гадаргын өнөөгийн байдал болон байгаль орчинд үзүүлж буй нөлөөллийг тодорхойлон үнэлж, дүгнэлт гаргав.

Ажлыг гүйцэтгэх мэргэжлийн байгууллагыг сонгон шалгаруулж, тусгай зөвшөөрөлтэй “Аватар” ХХК-тай гэрээ байгуулан хянан баталгааны ажлыг хийлгэв.

Жишээ болгож “Газрын төлөв байдлын, чанарын хянан баталгааны нэгж талбайн сүлжээний зураг болон Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны цахимаар гарсан дүгнэлтийг орууллаа.



Зураг 55. Газрын төлөв байдлын, чанарын хянан баталгааны нэгж талбайн сүлжээний зураг

ГАЗРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ, ЧАНАРЫН ХЯНАН БАТАЛГААНЫ ДҮГНЭЛТ

1

ГАЗРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ, ЧАНАРЫН ХЯНАН БАТАЛГААНЫ ДҮГНЭЛТ

2

ГАЗРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ, ЧАНАРЫН ХЯНАН БАТАЛГААНЫ ДҮГНЭЛТ

Хянан баталгааны төрөл: Захиалгат
 Онгоо: 2025-11-29

- Газар эзэмшигч: "МөЭнКо" ХХК
- Аймаг (нийслэл): Ховд
- Байршил: Мөрөн 3-р баг, Хойд хамар, 1
- Нэгж талбарын дугаар: 8401000436
- Хөрсний нэр: Уулын хүрэн хөрс /1502/
- Ургамалжилт: Харгана-жижиг дэгнүүлт үетэн-Ленийн ботуулт /V-III-1-2/
- Нийт талбайн хэмжээ: 539724 м² /53.97 га/
- Газар ашиглах зориулалт: Ашиглалт, олборлолт явуулж буй уурхайн талбай
- Одоогийн газар ашиглалтын хэлбэр: Ашиглалт, олборлолт явуулж буй уурхайн талбай
- Газар ашиглах, эзэмших шийдвэр: Ховд аймаг /нийслэл-ийн Дарви сум/дүүргийн Засаг даргын 2009 оны 12 дугаар сарын 02-ний өдрийн 08413-124/2009 тоот захирамж
- Газар ашиглах эрхийн гэрчилгээний дугаар: 140218
- Эзэмшил газрын төлөв байдал, чанарын тодорхойлолт:

Талбайн нэр	Талбайн хэмжээ, м2	Үүнээс эвдрэл бохирдсон талбай
Нийт эзэмшил талбай	539724	539724
Нэгж талбарын талбай	539724	539724
Газар дээр ашиглаж байгаа талбай	539724	539724
Илүү ашиглаж байгаа талбай	-	-
Дутуу ашиглаж байгаа талбай	-	-
А. Зөвшөөрөлтэй ашиглаж байгаа талбай	539724	539724
1. Үйл ажиллагаанд өртөөгүй талбай	28488	28488
Үүнээс Сул чөлөөтэй талбай	28488	28488
2. Үйл ажиллагаанд өртсөн талбай	511236	511236
Ил уурхайн ухаш	425761	425761
Үүнээс Уурхайн дотоод зам	85475	85475

13. Газрын гадарга, төлөв байдал:

Газрын гадарга уулын орой, бэл, энгэр хажуу бүхий налуувар, уулархаг, хад чулуу ихтэй гадаргатай бөгөөд далайн түвшнээс дээш дунджаар 1950-2000м өндөрт оршино. Талбайн төв хэсэгт ил уурхайн түвшин (олборлолтын үйл ажиллагаагаар газрын хэвлий хүчтэй ухагдаж, гүн үхмэл үүссэн) бүхий ландшафтын эвдрэлд орж газрын гадаргын төлөв байдал өөрчлөгдөж техноген, автогений нөлөөнд өртсөн байна. Уурхайн олборлолт, дотоод тээврийн замын үйл ажиллагаанаас үүдэн гадарга нь дам нөлөөлөлд өртсөн газар хамрагдана. Дарви сумын засаг даргын 2009 оны 12 сарын 02 өдрийн 124 тоот шийдвэрээр 539724 м² газрыг ашиглалт, олборлолт явуулж буй уурхайн талбай зориулалттай ашигладаг бөгөөд 94.7 нь физик эвдрэлд өрсөн. Үүнээс 425761 м² талбай нь ил уурхайн ухаш, 85475 м² талбай нь уурхайн дотоод зам талбай байна.

14. Хөрсний доройтол, бохирдолт, түүний төрөл, зэрэглэл:

Хөрсний холимог дээжийн химийн найрлагын хувьд урвалын орчин дунд шүлтлэг, цахилгаан дамжуулах чанар их буюу давсархаг, их карбонатжсан, ялзмаг агууламж 2.12-5.16% буюу уулын хүрэн хөрсний хувьд багаас дунд зэрэг, шингээх багтаамж их, үржил шимийн хувьд 100 г хөрсөнд хөдөлгөөнт фосфор 1.78-3.5 мг буюу дундаас хангалттай, хөдөлгөөнт кали 3.5-14.8 мг буюу маш багаас бага хэмжээгээр хангагдсан байна. 2020 оны шинжилгээний дүнтэй харьцуулахад 0-20 см гүн дэх ялзмаг агууламжийн дундаж

0.93%-иар нэмэгдсэн, хөдөлгөөнт калийн дундаж агууламж 0.85 мг-иар буурсан, хөдөлгөөнт фосфорийн дундаж агууламж 0.46 мг-иар буурсан байна.

Талбайн хөрсний хими шинж чанар

Дээжийн дугаар	Гүн см	Ялзмаг, %	pH	ЦДЧ, ds/m	Давс, %	CaCO ₃ , %	Соллидох суурь, мг-экв/100гр		Шим тэжээлийн элементүүд, мг/100гр	
							Ca	Mg	K ₂ O	P ₂ O ₅
2020 оны шинжилгээний дүн										
ХӨ-20-16	0-20	2.76	8.29	0.035	0.012	1.28	7	0.31	10	3.1
2025 оны шинжилгээний дүн										
Дээж-2	0-10	2.12	8.34	0.165	0.069	1.96	20	3	14.8	1.78
Дээж-3	0-5	5.26	8.24	0.409	0.17	1.6	20	13	3.5	3.5

Хөрсний механик бүрэлдэхүүнийг элс, тоос, шаврын харьцаагаар тодорхойлоход элсэн фракц 1-0.05мм –ийн А өнгөн үеийн хэмжээ 45.9-60.3%, тоосон фракц 0.05-0.001 мм –ийн хэмжээ 31.4-44.7%, шавар фракц <0.001мм–ийн хэмжээ 8.3-9.4% хооронд байх ба тухайн хөрсийг механик бүрэлдэхүүний олон улсын гурвалжин аргаар тодорхойлоход 0.01мм-ээс бага диаметртэй физик шаврын хэмжээ 22.5-27.7% хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй хөрс байна. 2020 оны шинжилгээний дүнтэй харьцуулахад 0.01 мм-ээс бага физик шаврын хэмжээ 4.1-9.3%-иар өсж элсэндэр механик бүрэлдэхүүнээс хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй болсон байна.

Хөрсний механик бүрэлдэхүүн

Дээжийн дугаар	Гүн см	Жижиг хэсгийн эзлэх хэмжээ мм, хувиар					
		1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	0.001-с бага
2020 оны шинжилгээний дүн							
ХӨ-20-16	0-20	6.5	59.8	15.3	6.8	3.3	8.3
2025 оны шинжилгээний дүн							
Дээж-2	0-10	2.1	43.8	26.4	10.8	7.5	9.4
Дээж-3	0-5	1.8	58.5	17.2	9.4	4.8	8.3

Шавранцар механик бүрэлдэхүүнтэй хөрсөн дэх хүнд металлын элементийг тодорхойлоход кадмий илрээгүй, никель, цайр, зэс, хром, хар тугалга гэх мэт хүнд металлын агууламж MNS 5850:2019 стандарт хэмжээнээс бага буюу бохирдолгүй байна. 2020 оны шинжилгээний дүнтэй харьцуулахад хөрсний хүнд металлын агууламж стандарт хэмжээнээс хэтрээгүй хэвийн байна.

Хөрсний хүнд металл

Дээжийн дугаар	Гүн, см	Хүнд металлын агууламж, мг/кг					
		Pb /Хар тугалга/	Cd /Кадмий/	Zn /Цайр/	Cu /Зэс/	Ni /Никель/	Cr /Хром/
2020 оны шинжилгээний дүн							
ХӨ-20-16	0-12	35.1	ND	80.9	4.3	ND	53.5
2025 оны шинжилгээний дүн							
Дээж-1	0-5	14.3	ND	61.6	11.5	4.1	46.65
Дээж-2	0-10	14.3	ND	5.3	1.7	4.5	46.65
Дээж-3	0-5	23.1	ND	65.4	20.7	11.05	15

Зөвшөөрөөдөг дээд хэмжээ (механик бүрэлдэхүүний ангиллаар), MNS 5850:2019

- Элсэрхэг хөрсөнд	50	1	100	60	60	60
- Шавранцар хөрсөнд	70	1.5	150	80	100	100
- Шаваргаг хөрсөнд	100	3	300	100	150	150
Хулцан агууламж	100	3	300	100	150	150
Хортой агууламж	500	10	600	500	1000	400

Аюултай агууламж	1200	20	1000	1000	1800	1500
Хөрсөн дэх нянгийн тоо $8.2 \cdot 10^6$ буюу 1 гр дахь нянгийн бохирдлын түвшнээс хэтрээгүй, гэдэсний савханцрын таньц болон перфрингенсийн титр нь MNS 3297:2019 стандарт хэмжээнээс бага гарсан тул бохирдолгүй буюу цэвэр байна. 2020 оны шинжилгээний дүнтэй харьцуулахад хөрс эрүүл ахуйн бохирдолгүй хэвийн байна.						

Хөрсний эрүүл ахуй

Дээжийн дугаар	Гүн, см	Нянгийн тоо		Гэдэсний савханцрын титр		Перфрингенс титр	
		Шинжилгээний хариу	Шинжилгээний хариу	Бохирдлын зэрэг	Шинжилгээний хариу	Шинжилгээний хариу	Бохирдлын зэрэг
2020 оны шинжилгээний дүн							
ХӨ-20-16	0-20	$0.7 \cdot 10^6$	1	1	0.1	1	
2025 оны шинжилгээний дүн							
Дээж-3	0-10	$8.2 \cdot 10^6$	0.1	Цэвэр	0.1	Цэвэр	

